

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-11
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	12-74
<hr/>	
<i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /2023 оны 01 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	14-18
<i>2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	18-19
<i>3. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	19-24
<i>4. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/</i>	24-53
<i>5. “Ерөнхий хяналтын сонголын тайлан хэлэлцэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	53-74

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 42 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар;

Чөлөөтэй: Х.Ганхуяг, Б.Жавхлан;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аюурсайхан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /2023 оны 01 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

**Ц.Цэрэнпунцаг:** “Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 0

Бүгд: 12

100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлын 10 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар оролцов.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ц.Цэрэнпунцаг:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 0

Бүгд: 13

100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал Б.Эрдэнэхуяг, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын Ахлах референт Н.Энхбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн талаар Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** 1.Төслийн 8 дугаар зүйлийг 10 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

**“10 дугаар зүйл. Үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах**

10.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын хүрээнд гадаад улс, дотоодын үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргаж болно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар дотоодын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаас нь зөвхөн хаалттай хүрээнд байна.

10.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, мөнгөн хөрөнгийн нөөцийг удирдах зорилгоор мөнгөний зах дээр богино хугацааны үнэт цаас гаргаж болно.

10.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчийн үнэт цаасны зах зээл, мөнгөний зах дээр арилжаалагдах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг худалдаж, худалдан авч болно.

10.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк компанийн хувьцааг тав хүртэлх жилийн хугацаанд эзэмшиж болно.

10.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч, түүний холбогдох этгээдийн гаргасан хувьцааны 20 хүртэлх хувийг эзэмшиж болох бөгөөд эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна.

10.7.Энэ хуулийн 14.3-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, бүртгэл, хэмжээ, хэлцэл хийхэд баримтлах журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 25 дугаар зүйл шинээр нэмэх:

#### **“25 дугаар зүйл.Хяналт шалгалт**

25.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, түүний толгой компани, нэгдлийн бүтэц, зохион байгуулалт, актив, пассив, өөрийн хөрөнгөд тавих шаардлага болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, тэдгээрт хийх хяналт шалгалттай холбогдох харилцааг Банкны тухай хууль болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан журмаар зохицуулна.

25.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч гадаад улсын хуулийн этгээд бол тус этгээдийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтарсан хяналт шалгалт хийж болно.

25.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагчийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага энэ хуулийн дагуу үүсгэн байгуулж, бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд Монголбанкны зөвшөөрлөөр хяналт шалгалт хийж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13  
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 18 минутад хэлэлцэж дуусав*

***Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн оролцов

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, М.Оюунчимэг, Д.Батлут, Н.Ганибал, О.Цогтгэрэл, Т.Доржханд, Д.Бат-Эрдэнэ, Ч.Ундрам нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр нар үг хэлэв.

**Ц.Цэрэнпунцаг:** 1.Тогтоолын төслийн 1 дүгээр заалтын 4, 5 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 2  
Бүгд: 12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7.“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан хөрөнгийн бирж бүртгэлтэй компани болгох асуудлыг судалж танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0

Татгалзсан: 12

Бүгд: 12

0.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмэх:

“8.2023 онд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нийтийн сонголт явуулж, нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох, жилийн эцсийн цэвэр ашгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний ногдол ашгийг жил бүр хувьцаа эзэмшигчдэд хуваарилах асуудлыг судалж, танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0

Татгалзсан: 12

Бүгд: 12

0.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав. “Ерөнхий хяналтын сонголын тайлан хэлэлцэсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Доржханд, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Х.Хэрлэн, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар оролцов.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Т.Доржханд, М.Оюунчимэг, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт заасны дагуу “Ерөнхий хяналтын сонсголын тайлан хэлэлцэсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, в/байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударгаар хүртээх, баялгийн ашиглалт, хуваарилалтын ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтад оруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн бүтээгдэхүүний ил тод байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлэх, 1991 онд батлагдсан БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох асуудлыг судлан үзэж, саналаа Улсын Их Хуралд танилцуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** г/Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Монголбанк болон холбогдох төрийн байгууллагуудын нүүрсний тээвэрлэлт, экспорт, үнийн талаар гаргаж байгаа статистик мэдээллийн зөрүүтэй байдлыг судлан үзэж, бодитой мэдээлэл гаргах чиглэлээр анхаарч ажиллах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** д/“Шинэ сэргэлт”-ийн бодлогод тусгагдсан “Боомтын сэргэлт”-ийн хүрээнд хилийн боомтуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, боомт дагасан суурьшлын бүсүүдийн дэд бүтэц, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх Боомтын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** е/Ерөнхий хяналтын сонсголын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах, явц байдлыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тухай бүр танилцуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** 2/Төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр:

а/“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж, 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан, б/2021, 2022 онуудад 1072 ширхэг хувьцааны ногдол ашгаа авч чадаагүй иргэдэд хувьцааны ногдол ашгийг нөхөн олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан, Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн 1072 хувьцааг иргэн бүрд эзэмшүүлэх, урьд нь дээрх хувьцааны талаар иргэдэд олгосон мөнгөнүүдийн сүүлийн хувьцааны ашгаас суутган бүх хувьцааг иргэнд эзэмшүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 10

Бүгд: 11

9.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Ц.Цэрэнпунцаг:** 3/Ард түмний мэдэх эрхийг хангах чиглэлээр:

а/нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой хяналт, шалгалтын ажлын үр дүн, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, хэрэгжилтийн явц байдал, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцсон талаарх мэдээллийг олон нийтэд тухай бүр шуурхай мэдээлж байх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** б/нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой оффтэйк гэрээнүүд, түүний нууцад хамааруулсан шийдвэр, ажил гүйцэтгэх, туслан гүйцэтгэх гэрээнүүд, 2010 оноос хойших 1072 хувьцаа эзэмшигчдийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын хурлын бүх тэмдэглэл, тушаал, шийдвэр, худалдах, худалдан авах гэрээнүүдийн хуулбарыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд ил тод болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, М.Оюунчимэг, Д.Батлут нарын гаргасан, в/Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтэйк гэрээг байгуулахгүй байх, улсын нууцад хамруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, М.Оюунчимэг, Д.Батлут нарын гаргасан, г/“Эрдэнэс Тавантолгой” ХК-иас санхүүжүүлсэн оффтэйк гэрээний хүрээнд хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төмөр замын бүтээн байгуулалтад хөндлөнгийн аудит оруулах, аудитын дүгнэлт дээр үндэслэн санхүүжилтийг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** 2.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэлийг шалган тогтоох” үүрэг бүхий Хянан шалгах түр хороо үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, цуглуулсан нотлох баримтуудыг шинжлэн судлах сонсголыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо /Г.Ганболд/-нд даалгасугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** 3.Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд төрийн өмчит компанийг шинээр байгуулах, үйл ажиллагааны үр ашигтай, ил тод байдлыг хангах зохицуулалтыг сайжруулах, онцгой дэглэм тогтоох, бүрэн эрх төлөөлөгч томилох шаардлага, үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулах чиглэлээр анхаарч ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 7  
Бүгд: 11

36.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Ц.Цэрэнпунцаг:** 4.Монгол Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа нийтийн эрх ашгийг хөндсөн Ерөнхий хяналтын сонсголын зохион байгуулалт, үр нөлөөг сайжруулах зорилгоор оролцогчдын хамрах хүрээг нэмэгдүүлэх, эрх, үүргийг тодорхой болгох, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдийг оролцуулах, сонсголын үр дүнг мэдээлэх, сонсголын мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, зохих байгууллагад үүрэг даалгавар өгөх, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байх, шаардлагатай бол холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар саналаа Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг холбогдох Байнгын хороодод даалгасугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, М.Оюунчимэг, Д.Батлут нарын гаргасан. Төрийн байгуулалтын харилцан хяналт тэнцлийг хангах хүрээнд Улсын Их Хурал нь Засгийн газартаа тавих хяналтыг сайжруулах, шүүх, прокурорын байгууллагын томилгоог өөрчлөх, шинэчлэх, иргэдийн төлөөлөл сонгогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, сонгуулийн тогтолцоог өөрчлөх ажлыг эрчимжүүлсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 8  
Бүгд: 11

27.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 15 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 57 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 01 дүгээр сарын 10-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”  
танхим  
09 цаг 42 минут

### **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Цэрэнпунцаг:** Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Т.Аюурсайхан гишүүн өвчтэй байна. Ж.Ганбаатар сайд гадаад томилолттой явна. Хассуурын Ганхуяг гишүүн чөлөөтэй байна.

Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 52.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 01 дүгээр сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Гурав. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд.

Дөрөв. “Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тав. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн таван асуудал хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Ц.Даваасүрэн гишүүний микрофоныг.

**Ц.Даваасүрэн:** Нөгөө Биржийн тухай хуулийг дагаж гарах тогтоол дээр л би санал хэлэх гэсэн юм.

Ямар ч гэсэн яах вэ тэр хувьчлах асуудал нь больсон юм байна гэж ойлголоо. “Эрдэнэ Тавантолгой”-г. 1072 хувьцааны үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн юм байна. Тийм ээ.

Энэ дээр нэг ийм асуудал байгаад байгаа юм. Энэ 1072 хувьцааны 700 гаруй тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2019 онд ийм ногдол ашиг гарсан байхгүй юу. Иргэдэд. Тэр ногдол ашгийг нь аваачаад нөгөө Зүүнбаянгийн төмөр зам руу хийчихсэн байхгүй юу. Тийм ээ. 2019 онд.

Тэгэхээр энэ ногдол ашгийн тухай, энэ иргэдийн хувьцааны тухай ярихад тэр төмөр замын хувьцааны асуудлыг хамт шийдэхгүй бол ерөөсөө болохгүй зүйл. Энэ бол.

Тийм учраас л би энэ асуудлыг анхаараач гээд.

Хоёрт, 2016 онд баахан иргэн 300 мянга авчихсан. Тэр нь нөгөө Биржийн тэр тооцооны төвүүд дээр эцэслэж хийж, аль иргэн яасан тэр юм нь бүртгэл тодорхой дуусаагүй байгаа юм билээ.

Тийм асуудлуудыг шийдэхгүйгээр. Би иргэдэд хувьцааны үр өгөөжийг нэмэгдүүлэх биш тэр компанийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах арга хэмжээ ав гэж. Би бол тэгж бодоод байгаа юм. Хувьцааны үр ашгийг биш ээ. Яах вэ, тэр үр өгөөжийг нэмэгдүүлэх гэж байж болох л.

Зүгээр ер нь компанийн удирдлага менежментийг сайжруулах тухай асуудал чинь хамгийн чухал байгаад байгаа байхгүй юу. Тийм үүргийг Засгийн газарт өгмөөр байгаа юм. Гаднын жишээлбэл уул уурхайн сайн компани менежментийн багаар тодорхой тендер шалгаруулаад оруулж болж байна. 49.0 хувь дотроо тодорхой арга хэмжээнүүдийг авна гэвэл бас болно.

Тийм учраас миний бодол бол Засгийн газарт “Эрдэнэс Тавантолгой” компанийн менежментийг сайжруулах гэсэн ийм агуулгыг л оруулж өгмөөр байгаа юм л даа. Хувьцааны үр ашгаас гадна. Менежментийн. Тэнд дураараа хүн томилоод байгааг л. Жишээлбэл, уул уурхайн тодорхой шаардлага хангасан хүн байх ч юм уу. Мэргэжлийн хүн байх ёстой юм уу. Тэр салбарт тийм туршлагатай гэдэг юм уу. Бүр ийм тодорхой энэ менежментийн багийг нь яаж шийдэж байх юм бэ гэдэг асуудлыг л шийдэхгүй бол энэ тодорхой ахиц дэвшил гарахгүй байх л гэж ингэж болгоомжлоод байгаа шүү. Үүнийг Та

бүхэн бас анхаараач. Хэрвээ тэгнэ гэх юм бол мөн “Эрдэнэс Тавантолгой” компанийн менежментийг хувьцааны үр өгөөжийг. Заавал 1072 гэж бичээд яах вэ дээ. Хувьцааны үр өгөөжийг дээшлүүлэх, менежментийг сайжруулж, хувьцааны үр өгөөжийг дээшлүүлэх гээд явчихвал яасан юм бэ л гэсэн нэг ийм санал байгаад байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Ц.Даваасүрэн гишүүний саналыг сонслоо. Энэ таны яриад байгаа асуудлууд ерөнхийдөө Нийтийн хяналтын сонголын тайланг нь сонссон. Дүгнэлттэй нь танилцсан. Чуулган дээр.

Тэгээд үүнийг дагаж гарч байгаа тогтоолын төсөл байгаа. Энэ дээр таны яриад байгаа бүх юм байгаа.

Тэгэхээр энэ тогтоолын төсөл өнөөдөр хэлэлцэх асуудлын тав дээр байна уу. Тийм. Ерөнхий хяналтын сонголын тайлан хэлэлцсэн энэ асуудлыг хэлэлцэхээр байгаа юм.

Тэгэхээр энэ дээр та яг энэ саналаа тодорхой хэлэх хэрэгтэй байна. Биржийн хууль дагаж гарч байгаа тогтоолын төслийг бас дахиад хэлэлцэнэ.

Тэгэхээр энэ дээр энэ гурван чиглэлээр иргэд маань санал гаргасан байгаа юм. Ер нь нийт тэр гаргасан саналуудыг нь ангилаад үзвэл нийт гурав ангилчихаж болмоор байгаа юм.

Тэгээд үүний хоёр дахь ангилал дээр нь тэр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр гээд “а”, “б”, “в” гэсэн ийм гурван чиглэл тогтоолын төсөл дээр явж байгаа. Тэгээд энэ дээр яг саяын яриад байгаа энэ бүх санаанууд тусгагдсан.

Тийм учраас ерөнхийдөө бид энэ хоёр тогтоолын төслийг хооронд нь давхцуулаад байлгүй хооронд нь уялдаа холбоотой явуулъя гэж ярьж байгаа. Энэ дээр та тогтоолын төсөл хэлэлцэж эхлэхэд энэ санаагаа дахиж хэлээд. Тогтоолын төсөл тараагаад өгчихсөн

байгаа биз дээ. Тараагаад өгчихсөн байгаа. Үүнтэй та танилцаж байгаад тогтоолын төсөл хэлэлцэхэд саналаа тодорхой хэлээрэй.

Өөр саналтай гишүүн байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

*Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /2023 оны 01 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/*

Хэлэлцэх асуудал нэг. 2023 оны 01 дүгээр сард Байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлбэ.

Төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард хэлэлцэх асуудлыг тогтоох тухай 201 дүгээр захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2.Хуульд хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газрын дарга Л.Өлзийсайханд үүрэг болгосугай.

Саналтай гишүүд байна уу? Нэрээ өгнө үү. Ц.Даваасүрэн гишүүнээр тасалъя. Б.Баттөмөр гишүүн асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Энэ 01 дүгээр сар ч яах вэ ингээд чуулган завсарлах байх. Тэгээд яах вэ, Хөрөнгө оруулалтын банкны тухай, Аялал жуулчлалын тухай, энэ нөгөө хууль батлагдсантай холбогдуулаад гээд гурван асуудал хэлэлцэх юм байна л даа.

Бид сүүлийн үед дандаа хулгай яриад хөгжил ерөөсөө ярихгүй байгаа. Эдийн засгийн Байнгын хороон дээр гол гол асуудлууд байгаа. Би энд жишээ

хэлье. Боловсрол, шинжлэх ухааны байнгын хороон дээр голлож ярих байх л даа. Тэр Шинжлэх ухаан, технологийн хууль гэж байгаа юм.

Манайд Эдийн засгийн байнгын хороонд бас харьяалагдана, хамаарна. Энэ хууль өргөн баригдаад их удсан байгаа. Засгийн газраас бас оруулж ирнэ гээд л тэгсэн. Одоо тэгээд оруулж ирсэн ч юм алга. Одоо ингээд байгаад байгаа юм.

Дараагийн асуудал. Энэ Худалдааны хууль байгаа. Дэлхийн олон оронд хийсэн судалгаагаар дэлхийн нийт орнуудын бараг 90 орчим хувь нь Худалдааны хуультай байдаг.

Монгол Улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн 30 жилийн хугацаанд хууль байхгүй. Дураараа. Одоо нүүрсийг аман дээрээс нь 60 доллараар худалддаг. Хил дээр очихоор 240. Дөрөв дахин хямд үнээр худалддаг. Дунд нь тэр далд эдийн засаг дээр хулгай нь явж байдаг.

Сая яах вэ дээ, ингээд Биржийн хууль хилийн үнээр худалдана гээд л явж л байгаа юм л даа. Тэгээд ийм юмнуудыг их сайн бодож яримаар, хиймээр юмнууд байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын эдийн засгийн бүтцийг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах маш их олон асуудлууд байна.

Маш их хэмжээний ашигт малтмал гадаадад гараад байдаг. Үр өгөөж нь ерөөсөө байдаггүй. Монгол Улсын эдийн засаг 2022 орны 4 хувь өслөө гэж байгаа юм. Зүгээр тоогоороо 4 хувь өсөж байгаа юм. Энэ өсөлтийг нь хэдэн хувь нь энэ ханштай холбогдож байгаа юм. Үр өгөөж юу байгаа юм.

Мэдээж хуримтлал энэ тэр гээд л янз бүрийн юмнууд ярьж болох байх.

Гадаад валютын нөөц гээд янз бүрийн юмнууд ярьж болох л байх л даа. Нэмэгдсэн гээд.

Ард түмний амьдралд ямар өөрчлөлт гарав гэхээр зэрэг бас л чамлалтай л байдаг л даа. Ер нь боломжийг дайчлаад ажиллах юм бол боломж маш их байна шүү дээ. Тухайлбал сүүлийн нэг сарын хугацаанд одоо бараг 600-гаад сая доллар Монголд ороод ирж байгаа байхгүй юу. 12 сарын хугацаанд ажилласан бол 5-аас 6 тэрбум доллар Монголбанканд тушаачих ийм боломж байна шүү дээ.

Тийм учраас манай Эдийн засгийн байнгын хороо энэ улс орны эдийн засгийг бүхэлд нь их том харж, үр өгөөжийг дээшлүүлэх, одоо энэ эдийн засгийн өсөлтийг нь хүртээмж, тэр өгөөжийг дээшлүүлэх, улс орны хөгжилд дорвитой хувь нэмэр болох томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, гаднаас авч байгаа зээлийн үр өгөөжийг дээшлүүлэх ийм асуудлууд дээр анхааръя.

Сүүлийн үед маш их хэмжээний их мундаг мундаг гоё нэртэй, мөчлөг сөрсөн ч гэх шиг сонин сонин нэртэй. Тэгээд төсвийн дэмжлэг гэдэг утгатай. Монголоос өөр газар гаднаас зээл авч төсвийнхөө алдагдлыг нь нөхдөг юм хаана ч байхгүй шүү дээ. Тэгээд ийм ийм юман дээр би бас манай Байнгын хороо 2 дугаар сар, 3 дугаар сар, 4 дүгээр сар, 5, 6 гээд дараагийн саруудад өргөн баригдсан хуулиуд дээрээ их голлож анхаарахыг би даргаас хүсэж байна.

Ер нь маш их олон хуулиуд өргөн баригдсан байгаа шүү. Шинээр их олон хууль санаачлах боломж байна. Бидэнд үүрэг өгвөл бид бас.../минут дуусав/



**Ц.Цэрэнпунцаг:** Б.Баттөмөр гишүүний тодорхой хэлсэн саналыг ойлголоо. Ингээд үүнийг бас Байнгын хорооноосоо хаврын чуулганаар энэ хуулиудыг оруулж ирэх боломж нь ямар байна. Судалъя, үзье.

Их Хурал дээр Д.Өнөрболор гишүүн Худалдааны хууль дээр байгаа. Би танд мэдээлэл өгсөн. Тийм ээ. Би тэгээд ер нь хэлсэн. Д.Өнөрболор гишүүн. Та энэ дээрээ яаравчилж ажиллахгүй болл энэ яаралтай гаргах шаардлагатай гээд гишүүд ч ярьж байна, бас чуулган дээр ч яригдсан. Энэ талаараа мэдээлэл өгөөрэй гэсэн. Бид энэ талаар мэдээлэл авч байгаад хаврын чуулганаар энэ хуулиудаас оруулж ирэх бололцоотой хууль юу байна. Хаврын чуулганы хуваарьт оруулах ажлыг байнгын хорооноос санал тавья.

Ц.Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

**Ц.Даваасүрэн:** Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавартай холбогдуулаад нөгөө Валютын зохицуулалтын хуулийн асуудлыг л би яриад байгаа юм л даа. Ажлын хэсгийг нь би ахалж байсан юм.

Тэгээд уг нь эцэслээд ингээд өгчихсөн байгаад байдаг. Түүнээс хойш бараг жил болчихлоо шүү дээ.

Тэнд нэг заалт байгаад байгаа юм л даа. Одоо энэ уул уурхайн бүтээгдэхүүн гадагшаа ачигдсан бол орлогыг нь 72 хоногийн дотор Монголд оруулна. Оруулахгүй торгуультай гэсэн ийм заалттай байхгүй юу.

Ер нь яах вэ, энэ Чили, тэгээд нь энэ уул уурхайн баялагтай орнуудад л бас яг иймэрхүү л загвар байдаг юм байна л

даа. Тэгээд энд нөгөө Оюу Толгой нь бас орчихдог. Тэгээд тэр лобби нь явдаг юм уу. Одоо ингээд энэ хууль гацсан.

Тэгэхээр энэ хууль байхгүй бол угаасаа энэ нүүрсний асуудал чинь шийдэгдэхгүй. Энэ заалт байхгүй бол.

Бид бараагаа ямар үнээр ачуулаад, ямар үнээр борлогдож байгаагаа мэдэж байж татвараа авна шүү дээ.

Өнөөдөр жишээлбэл нүүрсэн дээр одоо ингээд асуудлууд үүсээд, тэр төмөр замын компанид ажиллаж байсан залуугаас гарч байгаа мөнгөн дүн гэдэг чинь хачин юм сонсогдож байна шүү дээ. Энэ чинь юунаас болоод байгаа юм. Яагаад тэр нүүрс тээвэрлэж байгаа машинууд, тээвэрлэлт, тэр төмөр замын тээвэрлэлт дээр тийм өндөр авлигал байна вэ гэж. Яагаад тэгээд байгаа юм гэж. Яагаад гэвэл нүүрс чинь өөрөө шороо шиг үнэгүй байгаа байхгүй юу. Цаашаа гаргаад гурав, дөрөв, тав дахин зарчхаж байгаа учраас тэр машинд нь авчрахын тулд тийм өндөр хахууль яригддаг юм байна шүү дээ. Тийм өндөр дүнтэй мөнгүүд гарч ирж байна шүү дээ.

Үүнийг болиулья гэвэл ерөөсөө л ийм л арга хэмжээнүүд байх хэрэгтэй шүү дээ.

Нэг гэрээгээр нэг хаалгаар гардаг. Тэгээд тэр борлуулалтын орлогыг нь заавал татварын дансанд татаж хянадаг л байх ёстой. Одоо өнөөдөр бид Оюу Толгойг бүрэн хянаж чаддаггүй. Бүрэн хянаж чаддаггүй.

Тэр дотор чинь маш олон. 21 төрлийн газрын ховор элемент ачигдаж байгаа. Бид зөвхөн тэндээс юу авч байгаа гэвэл алт, зэс, мөнгө. Молибденыг нь

авдаг байснаа тэр Дубайн гэрээгээр больчихсон байх.

Ингээд цаана нь байгаа арван хэдэн төрлийн газрын ховор элементээ зүгээр л өгч байгаа байхгүй юу. Цаашаа ямар борлуулалт хийж байгааг нь ч бид мэдэхгүй. Тэр дотор явж байгаа элементүүд. Жишээлбэл, **vanadium**. 1 грамм нь 8000 доллар. Одоо өссөн ч байж магадгүй. 1 грамми нь. Гар утсанд ордог элемент шүү дээ.

Тэгэхээр ингээд гар утас, эрчим хүчний эх үүсвэр болгож байгаа энэ газрын ховор элементүүдийг бид зүгээр үнэгүй ачуулаад байна шүү дээ. Үнэгүй ачуулаад байна. Эрдэнэтээсээ ч авч чадахгүй байна. Эндээс ч авч чадахгүй байна.

Тийм учраас энэ бүгдийгээ хянадаг. Энэ Монголд хөрөнгө оруулсан компани хэн гуай ч бай Монголын татварын дансанд заавал борлуулалтынхаа орлогыг оруулдаг. Ингэж л бид зохицуулалт хийж чадахгүй юм бол яаж энэ валютын нөөц чинь нэмэгдэх юм. Тэр оффшор чинь яагаад ч алга болохгүй шүү дээ.

Тэр нүүрс дээр байгаа хоёр давхар гэрээ чинь байдгаараа л байна. Татварт үзүүлдэг нэг гэрээтэй. Цаашаа борлуулдаг нэг гэрээтэй. Тэгээд зөрүү мөнгө нь оффшор луу явдаг.

Тийм учраас энэ Валютын зохицуулалтын хууль дээр л уг нь тэрийг зохицуулъя гэдэг нэг ийм заалт орчихсон байхгүй юу. 72 хоногийн дотор Монголд.

Энэ юу ч гэсэн тийм юм билээ. Норвеги ч гэсэн бас яг тиймэрхүү заалттай юм билээ. Бид ер нь ингээд уул уурхайгаар бас амжилттай явж байгаа,

газрын баялгаа амжилттай ашиглаж байгаа орнуудын л тэр менежментүүдийг, маркетингуудын давуу талуудыг нь харж байгаад л энэ Валютын зохицуулалтын хуульд нэг ийм заалт хийсэн юм. Яг тийм юм билээ.

Ер нь Та бүхэн ч гэсэн мэдэж байгаа шүү дээ. Гадаадад татвар төлөхгүй байна гэдэг ямар аюул байдаг билээ. Тэр дээр ямар өндөр хяналт байдаг билээ. Гэтэл манайд тийм юм байхгүй болчихоод байна шүү дээ.

Тийм учраас нэг ийм заалт орсон чинь одоо нөгөөдөх нь ингээд гацаад.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ц.Даваасүрэн гишүүн өмнө нь Байнгын хорооны хуралдаан дээр бас энэ асуудлыг ярьсан.

Би даргын дэргэдэх зөвлөл дээр ярьсан. Бас хариу өгсөн байх. Ер нь энэ дээр бас нэлээн Засгийн газартайгаа ойлголцох. Тэгээд Засгийн газар нь цаашаа Оюу Толгойтойгоо харьцаж байгаа учраас энэ дээр тодорхой яг хэрэгжих тал руу нь хоорондоо ойлголцол хэрэгтэй юм байна гээд л ойлгосон.

Тэгээд яах вэ, даргын дээрх зөвлөл дээр дэмжээгүй. Дараагийн хэлэлцэх асуудалд оруулъя гэхээр. Дахиад энэ даргын дэргэдэх зөвлөлөөр оруулъя. Тэгээд одоо энэ намрын чуулганаар амжихгүй бол хаврын чуулганаар оруулах ямар арга хэмжээ байна. Үүнийг асууя. Хэлэлцэх тал дээр.

Даргын дэргэдэх зөвлөл дээр санал дэмжигдэхгүй болохоор зэрэг ингээд унаад байгаа юм. Би бол таны наад саналыг Эдийн засгийн байнгын хорооноос оруулаад байгаа.

Хоёрт, таны ярьж байгаа саяын асуудалтай холбоотой хоёр, гурван асуудал ярьж байна. Нэг гарцаар зарах. Тэр гэрээний үнэ тодорхой, ил байх. Энэ чиглэл рүү сая Биржийн хууль одоо ингээд гарчихсан. Мэдэж байгаа. Биржийн хууль 07 сарын 01-нээс хэрэгжинэ. Наана нь Засгийн газар, Уул уурхайн яам журмаа гаргаад явж байгаа.

Биржийн хууль гараад ирэхээр энэ асуудлууд бас нэлээн цэгцрэх байх гэж харж байгаа.

Тэр татвараа бүрэн гүйцэд авч чадаж байна уу, чадахгүй байна уу гэдэг асуудал бол Валютын зохицуулалтын хуулиар зохицуулагдаж энэ асуудал шийдэгдэх ёстой гэж ярьж байгааг би даргын дэргэдэх зөвлөл дээр тодорхой ярья.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Санал хураалтаа явуулья.

### ***Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл***

Хоёр дахь асуудал. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын хэлэлцүүлгийг хийе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүний талаарх тогтоолын төслийг уншиж танилцуулья.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүнээс өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр

“Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд 100 хувь дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. “Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Ингээд дараагийн асуудалдаа оръё.

байгуулахыг төр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай, Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс өргөн мэдүүлсэн “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батлут  
Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд: Н.Ганибал Улсын Их Хурлын гишүүн, Т.Доржханд Улсын Их Хурлын гишүүн, С.Чинзориг Улсын Их

Хурлын гишүүн, Б.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжилтэн, албан хаагчийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг Д.Батлут зөвшөөрсөнгүй гэсэн тогтоолын төсөл байна.

Ингээд Ажлын хэсгийн бүрэлдэхүүний талаар саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд санал хураалт явуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд 100 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

*Гурав.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

Ингээд дараагийнхаа асуудалд оръё. Хэлэлцэх асуудал гурав.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсэг орж ирээрэй. Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч миний бие уншиж танилцуулъя.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 30, 2023 оны 01 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсэг нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийг үндэслэн нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд тусган Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг бэлтгэсэн бөгөөд чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалгалгүй нээлттэй үлдээсэн 10 дугаар зүйл, 25 дугаар зүйлүүд дэх Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран батлах журмуудын талаарх ерөнхий зохицуулалтыг дэлгэрүүлж тусгасан нэмэлт саналын томъёоллуудыг бэлтгэн ажиллалаа.

Хуулийн төслийн нэрийг Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай гэж өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй саналын томъёолол чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэнтэй холбогдуулан хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд дэх нэр томъёог үүнд нийцүүлж жигдэлсэн хууль зүйн техникийн засваруудыг хийсэн болно. Хөрөнгө оруулалтын

төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдэд үг, хэллэг, хууль зүйн техникийн загвар засваруудыг хийсэн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн Банкны тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хувилбарын талаар ажлын хэсгээс гаргасан танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсандаа баярлалаа.

Танилцуулгаа хийлээ. Ингээд ажлын хэсгийг танилцуулья.

Г.Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Д.Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Б.Эрдэнэхуяг Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал, Б.Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Н.Энхбаатар Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын Ахлах референт.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт. Алга байна.

Ийм учраас хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн

боловсруулах чиглэл өгсөн 2 саналаар санал хураалт явуулж эхэлье.

1.Төслийн 8 дугаар зүйлийг 10 дугаар зүйл болгон, доор дурдсаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

**“10 дугаар зүйл.Үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах**

10.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын хүрээнд гадаад улс, дотоодын үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргаж болно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар дотоодын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаас нь зөвхөн хаалттай хүрээнд байна.

10.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, мөнгөн хөрөнгийн нөөцийг удирдах зорилгоор мөнгөний зах дээр богино хугацааны үнэт цаас гаргаж болно.

10.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчийн үнэт цаасны зах зээл, мөнгөний зах дээр арилжаалагдах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг худалдаж, худалдан авч болно.

10.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк компанийн хувьцааг тав хүртэлх жилийн хугацаанд эзэмшиж болно.

10.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч, түүний холбогдох этгээдийн гаргасан хувьцааны 20 хүртэлх хувийг эзэмшиж болох бөгөөд

эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна.

10.7.Энэ хуулийн 14.3-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, бүртгэл, хэмжээ, хэлцэл хийхэд баримтлах журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 92.3 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хоёр дахь санал. Төсөлд доор дурдсан агуулгатай 25 дугаар зүйл шинээр нэмэх:

#### “25 дугаар зүйл.Хяналт шалгалт

25.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, түүний толгой компани, нэгдлийн бүтэц, зохион байгуулалт, актив, пассив, өөрийн хөрөнгөд тавих шаардлага болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, тэдгээрт хийх хяналт шалгалттай холбогдох харилцааг Банкны тухай хууль болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан журмаар зохицуулна.

25.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч гадаад улсын хуулийн этгээд бол тус этгээдийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтарсан хяналт шалгалт хийж болно.

25.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагчийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага энэ хуулийн дагуу үүсгэн байгуулж, бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд Монголбанкны зөвшөөрлөөр хяналт шалгалт хийж болно.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Асуулт. Санал хураалтыг зогсооё. Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэж байна.

Энэ хууль батлагдсанаар гаднын хөрөнгө оруулалтын банк орж ирэх ийм нөхцөл бололцоог нээж өгөх ёстой гэж ойлгоод байгаа шүү дээ.

Тэгээд энэ заалт дээр жишээ нь Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч, гадаадын улсын хуулийн этгээд бол тус этгээдийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран хяналт шалгалт хийж болно гээд.

Энэ хяналт шалгалттай холбоотой асуудлууд байх шиг байна л даа. Мэдээж хяналт шалгалтын асуудлуудыг хийлгэвэл яах вэ. Гэхдээ нэг гараараа бид нөгөө гаднын хөрөнгө оруулагчдаа нээж өгөөд, нөгөө гараараа хаах талын юмнууд энэ дотор бас орж ирээд байгаа юм биш биз гэж.



Өөр нээлттэй ажиллах, зөв зохистой ажиллах, яг хуулийнхаа дагуу нээлттэй бүрэн, одоо юу гэдэг юм хуулийнхаа дагуу ажиллах ийм нөхцөлүүд маань энд хэр их заалттай байгаа гэсэн нэг ийм асуулт байна. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсэг. 2 номерын микрофоныг нээе. Г.Энхтайван хариулья.

**Г.Энхтайван:** Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад тодруулья.

Дэд ажлын хэсгээс гаргасан энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хяналт шалгалттай холбоотой бүтэн тийм зүйл байгаа. Энэ дээр 25.2 дээр Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч нь гадаад улсын хуулийн этгээд бол тус улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтарсан шалгалт хийж болно гэж байгаа.

Энэ бол олон улсын Базелийн хорооноос /The Basel Committee on Banking Supervision (BCBS)/ гаргаж гишүүн орнуудаа мөрдүүлдэг олон улсын зарчим байгаа.

Энэхүү зарчмын 13 дугаар заалт дээр тухайн орон нь тухайн оронд байгаа хуулийн этгээд гадаад улс, санхүүгийн байгууллага нь гадаад улсад хөрөнгө оруулж санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхдээ тухайн оршин байгаа газар хөрөнгө оруулж байгаа газрын хянан зохицуулах байгууллагад хамтарсан шалгалт хийж нэгдсэн нэг тайлан балансыг мөрдүүлнэ. Нэгдсэн нэг зарчмыг бүрдүүлнэ гэсэн олон улсын хяналт шалгалтын нэгдсэн зарчмын хүрээнд энэ заалтыг оруулж ирсэн байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Та нэмж асуух юм уу? Саяын таны асуултад нэмээд хариулчих. Ажлын хэсгээс.

Мөнгө угаах, терроризмтай тэмцэх тухай хуульд бас энэ заалтууд байгаа. Тийм ээ. Ил тод болгох. Цэвэр мөнгө орж ирж байна уу, үгүй юу гэдэг дээр олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллахад нээлттэй байх шаардлагууд байгаа. Үүнтэй энэ нийцэж байгаа юм.

Ажлын хэсгээс Г.Амартүвшин гишүүн нэмж хариулья. Г.Амартүвшин гишүүний микрофоныг. Ж.Бат-Эрдэнэ гишүүн нэмэлт асуулт. 1 минут.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ 25.3 дээр бүртгэгдсэн Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд Монголбанкны зөвшөөрлөөр хяналт шалгалт хийж болно гэгчихсэн байгаа байхгүй юу. Зөвшөөрснөөс болно. Болохгүй ч байж болно.

Тэгэхээр бид ингээд байгаа шүү дээ. Хэн нэгэн даргаас хамааралтайгаар, эрх ашгийн зөрчилтэй байгаад ч байдаг юм уу, харьцааны холбоотой. Одоо юу гэдэг юм. Бие биедээ хувийн харилцаанаас болоод ч юм уу. Энэ хүний хүчин зүйлээс болоод шалгалт шүүлэг хийгээд явчихдаг энэ зүйлийг л бид таслан зогсоох гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр энд жишээ нь Монголбанкны зөвшөөрлөөр хяналт шалгалт хийж болно гэгчихсэн. Болохгүй ч байж болно, болж ч болно. Дургүй хүргээд байвал шалгалт хийчихнэ. Дурыг нь хүргээд байвал тэр чигээр нь дураар нь дургиулаад байна.

Тэгэхээр энэ заалтууд чинь бүр тодорхой байх ёстой байхгүй юу даа. Тодорхой ийм ийм заалтуудыг ингээд

зөрчсөн байвал хяналт шалгалтыг хийнэ ээ ч гэдэг юм уу. Нэг ийм байгаа.

Тэгээд миний асуугаад байгаа нэг асуудал байгаа шүү дээ. Бүрэн дүүрэн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн гишүүн Г.Амартүвшин хариулъя. Г.Амартүвшин гишүүний микрофоныг нээе.

**Г.Амартүвшин:** Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмээд тодруулчихъя гэж бодсон юм.

Ер нь жишээ ярья л даа. Япон Улсын банк манайд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нэе гэсэн тохиолдолд Японы Төв банк тухайн Япон банканд зөвшөөрлийг нь өгнө. Өөрөөр хэлбэл аливаа улсын Төв банк нь өөрийнхөө хянадаг тэр банкууд нь гадаад улсуудад салбараа нээхэд Төв банк нь заавал зөвшөөрөл өгдөг. Зөвшөөрөл өгсний дагуу жил болгон бас шалгалт хийдэг.

Энэ зохицуулалт юу вэ гэхээр тэгсэн тохиолдолд Японы Төв банк, Монголбанк хоёр хамтарч шалгалт хийж болно. Монголбанкны хийсэн шалгалт дээр нэмээд Японы Төв банк орж ирж болно гэсэн үг. Аль эсвэл Японы Төв банк нь манай Төв банкнаас зөвшөөрөл аваад бид Японы энэ банкны танай дээр үйл ажиллагаа явж байгаа салбар дээр нь охин компани дээр нь бид шалгалт хийх шаардлагатай байна. Зөвшөөрөл өгнө үү гээд л. Тиймэрхүү л зохицуулалт яригдаж байгаа болохоос түүнээс биш үйл ажиллагааг нь хааж боомилсон тийм заалт биш ээ, Ж.Бат-Эрдэнэ гишүүн ээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Г.Амартүвшин гишүүний хариулт дээр бас нэмээд хариулахад.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн ээ. Энэ бол Монголбанк зөвшөөрөл олгоно гэдэг бол ерөнхийдөө гадаадын тэр толгой компанийн зохицуулах байгууллага нь орж ирээд шалгахдаа мэдээж заавал мэдэгдэх шаардлагатай байхгүй юу. Ер нь энэ агуулга нь Монголбанканд мэдэгдэнэ ээ л гэсэн агуулга байгаа.

Тэгэхээр Г.Энхтайван энэ дээрээ нэмээд хариулчих. Ажлын хэсэг дээр.

**Г.Энхтайван:** Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк маань өөрөө Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд шүү дээ.

Төв банкнаас тусгай зөвшөөрөл авч байгаа.

Төв банкнаас тусгай зөвшөөрөл авч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд Банкны тухай хууль болон Төв банкны тухай хуулиар зөвхөн Монголбанкны зөвшөөрлөөр гаднын байгууллага мэдээлэлтэй нь танилцаж байгаа.

Энэ дээр хяналт шалгалт дээр ч гэсэн олон улсын жишиг стандартынхаа дагуу тухайн үүсгэн байгуулагч орны эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хяналт шалгалт хийдэг.

Мөн ялгаагүй манай хуулийн этгээдүүд гадаад оронд салбар төлөөлөгчийн газар байгуулаад үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд Төв банк ч гэсэн хяналт шалгалтынхаа үйл



ажиллагааг тухайн орны зохицуулагч байгууллагын зөвшөөрлөөр л хийдэг. Энэ бол тухайн орны хяналт, зохицуулалтын байгууллагад мэдэгдэж мэдээллээ хуваалцаж байгаа нэг хэлбэр. Яг энэ асуудлыг олон улсын хяналт шалгалтын Базелийн хороон дээр яг энэ нэр томъёогоор зохицуулж өгсөн байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Санал хураалтаа явуулъя. Саналыг уншсан учраас санал хураалтаа шууж явуулъя. Санал хураалт. /алх цохив/

*Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай  
хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан,  
эцсийн хэлэлцүүлэг/*

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэллээ.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсантай холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын

Гишүүдийн 76.9 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууссан тул төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч миний бие уншиж танилцуулна.

Ингээд дараагийнхаа асуудалд оръё.

төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Ажлын хэсэг тогтоолын төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг болон нэр томъёо, найруулгын саналыг төсөлд тусган төслийн эцсийн хувилбарыг бэлтгэлээ.

Чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хуралдаан даргалагчаас тогтоолын төслийн зарим заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу саналыг бэлтгэн томъёоллоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Цэрэнцунцаг:** Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Б.Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Орохгүй байна уу? Д.Батлут гишүүнээр тасаллаа. Б.Баттөмөр гишүүн асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Ер нь энэ Биржийн хууль гарч байгаатай холбогдуулан авч байгаа арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын гол агуулга, гол асуудлыг дэмжиж байгаа.

Энд тэр 5 дугаар заалт дээр Уул уурхайн бирж гэж явж байснаа гэнэт “Эрдэнэс Тавантолгой” болоод л явчхаж байгаа юм л даа. “Эрдэнэс Тавантолгой”-н тодорхой хувийг, одоо 40 хүртэл хувийг Монголын ард түмэнд эзэмшүүлье.

Энэ дотор 2012 оноос 2022 он хүртэл төрсөн хүүхдүүдэд бас тэр 1072-ыг нь эзэмшүүлье.

Энэ арга хэмжээг авсны үр дүнд нийт хувьцааны 40 орчим хувь гэдэг чинь нэг хүнд 2252 орчим хувьцаа болох юм гэсэн ийм тогтоолын төслийг Улсын Их

Хурлын нэр бүхий гишүүдээс Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа.

Энд энэ 5 дахь заалтаа үзэхээр яах вэ, гол агуулгын хувьд болж л байна л даа. Тэгээд энд жоохон найруулгын ч юм уу, хийх ёстой ч юм уу гэж ингэж бодогдоод байна л даа.

Сая түрүүн тэнд Ц.Даваасүрэн гишүүний ярьж байгаа. Тэр яах вэ дээ олон нийтийн болгох хэрэгтэй. Бид ер нь нэг орхигдуулаад байгаа юм нь менежментийн л асуудал байгаа юм л даа. Одоо энэ Тавантолгой компани дээр ингээд үзэхээр зэрэг гол алдаа юунд байсан гэхээр зэрэг хүнээсээ л олоод байгаа байхгүй юу.

Монголын хөгжлийн мухардал гэдэг ч юм уу, өнөөдөр бий болсон энэ ядуурал, энэ өр зээл, энэ эдийн засгийн муу үзүүлэлтүүд дандаа хүнээс л шалтгаалсан байгаа шүү дээ.

Хоёр хөрштэй найрамдал, хамтын ажиллагааны сайхан харилцаатай. Дэлхийн 130 гаруй оронтой худалдаа, хамтын ажиллагааны гэрээ хэлцэл хийж худалдаа хийж байгаа.

Юу болохгүй байгаад байна гэхээр хүний хүчин зүйл энд болохгүй байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас тэр менежментийг сайжруулах, хүний хүчин зүйлийг сайжруулах, тэр удирдлагын багуудыг чадвартай хүмүүсээр бүрдүүлэх энэ чиглэлийн юмнууд энэ юунд бас л оруулмаар санагдаж байгаа юм л даа.

2019 онд 700-гаад тэрбум төгрөг тараахаас үндсэндээ миний тооцож байгаагаар 40, 50-иад тэрбум төгрөг дутуу тараагдсан байдаг юм. 2020 онд

ногдол ашиг байхгүй. 2021 онд байхгүй. 2022 оны баланс ингээд гарч байгаа байх.

Гурван жилийн ногдол ашгийг Монголын ард түмэн авахгүй юм уу? 1072 хувьцааныхаа ногдол ашгийг авахгүй юм уу?

Тэр төмөр замуудад оруулчихсан гээд байгаа. Төмөр замуудад оруулсан юуг тодорхой хувь өгч тэр төмөр замын хувьцаа эзэмшигч болох юм уу. Эсвэл бондоо гаргаж ард түмэнд өгөх. Хувьцааг нь өгөхгүй хоёр, гурван жил явж болохгүй шүү дээ.

Тэгээд ийм ийм юмнуудыг жоохон тийм бодож л, их сайн бодож л хиймээр л санагдаад байгаа юм л даа. Тэгээд энэ дээр юу бодсон юм бэ? Яг энэ 5 дахь заалт дээр асуугаад байгаа юм. Үүнийг тэр ажлын хэсгийн ахлагчаас асуучихъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Уул уурхайн биржийн тухай хууль батлагдсан. Үүнийг манай гишүүд бүгдээрээ дэмжиж байгаа. Ойлгомжтой.

Хүнээс үл шалтгаалан биржээр зарагдах, тухайн аж ахуйн нэгжүүдийн компанийн захирал нь дур мэдэн цаашаагаа наймаалцах, гэрээ хийх, нууц гэрээ хийх гэх мэтчилэн. Эсвэл гэрээнийхээ дундаас ашиг олох ч байдаг юм уу ийм бидний мэдэхгүйгээр тэнд үйл ажиллагаа зөндөө юм явчхаад байна шүү дээ.

Тэгэхээр үүнээс зугтаалгаад. Одоо өөрөөр хэлбэл үүнийг ил тод болгоод Уул уурхайн биржийн тухай хууль батлагдаад явж байгаа. 07 сарын 01-нээс энэ маань

хэрэгжинэ. Үүнийг та бүхэн мэдэж байгаа.

Тэгэхээр энэ зүгээр хуулиа баталчих биш энэ хуулиа дагалдуулаад хэд хэдэн асуудлуудыг шийдчихвэл яасан юм бэ гээд энэ ажлын хэсэг дээрээс орж ирж байгаа юм.

Нэгдүгээрт, тантай санал нэг байгаа. 1072 хувьцааны үр өгөөжийг нэгдүгээрт нэмэгдүүлье.

Хоёрдугаарт, 2012 оны 04 дүгээр сарын 11-нээс өдрөөс хойш төрсөн. Өөрөөр хэлбэл сая орчим хүүхдүүд байгаа.

Тэгэхээр энэ хүүхдүүдэд төрийн эзэмшлийн хувьцаанаасаа тодорхой хэмжээний хувьцааг эзэмшүүлье гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл 1072 маань яг таны, бас та бүхний гаргаж байсан саналтай ижилхэн санал орж ирж байгаа.

Энд нэгдүгээрт шинээр төрсөн иргэддээ эзэмшүүлье гэж.

Хоёрдугаарт, түрүүн Ц.Даваасүрэн гишүүн ч нэлээн хэд хэдэн удаа яриад байгаа юм. Менежментийг сайжруулъя гээд. Энд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга, хүртээмжтэй болгох, компанийн сайн засаглал, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэж байгаа шүү.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болгох гэж байгаа.

Тэгэхээр энэ хөрөнгийн бирж дээр. Одоохондоо хөрөнгийн бүртгэлд байхгүй. Биржид бүртгэлтэй компани болно гэдэг чинь энэ өөрөө засаглал нь

нэмэгдээд сайжраад явах нөхцөл нь бүрдэх юм. Өөрөөр хэлбэл таны хэлээд байгаа менежментийг сайжруулах гэдэг асуудал орж ирж байгаа.

Гуравдугаарт, энд эцэст нь 2023 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Засгийн газарт даалгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ тогтоол гарснаараа цаашаагаа хэрэгжээд үл мэдэгдэх, яаж хэрэгжиж байгаа нь мэдэгдэхгүй биш. Энэ үг, үсгийн дагуу буцаад Засгийн газар маань бидэнд танилцуулаад ороод ирэх юм.

Тэгэхээр нээлттэй болгох, менежментийг нь сайжруулах гэсэн саналууд нь Засгийн газраас буцаад орж ир ээ. Бид буцаад үүнийг чинь танилцъя. Яг яаж хийх гээд байгаа юм. Эргэж бид нарт танилцуул гэсэн үг, утгатайгаар 2023 оны 1 дүгээр улиралд багтааж танилцуул гэж байгаа юм.

Тэгэхээр тэр үед нь хэдүүлээ дахиад саналыг нь гаргаад, дахиад менежментээ сайжруулах, тэр баг оролцуулах байдаг юм уу, гаднын менежмент оролцуулах ч байдаг юм уу, ил тод байх гэдэг юм уу энэ зүйлүүд нь яриад явахад боломжтой гэж үзэж байгаа юм. Тийм.

Ногдол ашгийн хувьд С.Чинзориг гишүүн нэг санал гаргаж байгаа. Одоо үүний дараа санал хураах байх. Сүүлийн хоёр жил ногдол ашгаа хуваалгүйгээр бид төмөр зам руу өгчхөөд байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг иргэддээ буцааж олгоё гэсэн саналыг С.Чинзориг сайд орж ирсэн. Одоо үүний ар дээр санал хураагаад явчихна. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** М.Оюунчимэг гишүүн асуулт асууя.

**М.Оюунчимэг:** Уул уурхайн биржийг дагаад тодорхойгүй байгаа, хүлээгдэж байгаа асуудлуудыг шийдээд явчих нь зөв гэж харж байгаа.

Яг энэ хүрээнд миний хөндөх гэж байгаа асуудал сая ярьж байна. Энэ ногдол ашигтай холбоотой асуудал.

“Эрдэнэ Тавантолгой”-г тойрсон асар их авлига, хээл хахууль, мөнгө угаалтын асуудал, оффтэйк гэрээ, одоо янз бүрийн маш ихээр гэрээнүүд сая энэ шалгалтын үеэр гарч ирж байна гээд л ингээд яваад байна шүү дээ. Энэ чинь өөрөө хэсэг бүлэг хүрээний хүмүүсийн хувьд асар их мөнгө эргэлдээд байдаг. Гэтэл яг иргэдэд очих ёстой 1072 хувьцааны ногдол ашгаа сүүлийн хоёр жил өгч чадахгүй ингэж яваад байна.

Сая ч гэсэн хугацаандаа өгсөнгүй. Ногдол ашгаа авъя гээд л иргэдийн зүгээс энэ үүсэж байгаа нөхцөл байдалтай уялдаад л бухимдаж байна шүү дээ. Хэн ч бухимдана. Мэдээж. Тэнд хэдэн тэрбумаар нь эргэлдээд л нэг айлын гэрээс хэдэн тэрбумаар мөнгө олж байна гээд л шуугиад байдаг. Үнэн хэрэгтээ энэ нь “Эрдэнэ Тавантолгой”-гоос иргэддээ ногдуулах 1072 хувьцааныхаа ашгийг хүртэл тооцоод өгч чадахгүй байна гэдэг бол төр дэндүү арчаагүй байгаагийн шинж шүү дээ.

Тийм учраас энэ дээр шинэ төрсөн иргэддээ нөгөө “бүртгэлтэй иргэдэд эзэмшүүлэх асуудлыг судалж” гэдгийн ар талд нь бас энэ сүүлийн хоёр жилийн “2021, 2022 оны 1072 ноогдол ашгийг тооцож олгох” гэдэг үгийг оруулаад тэгээд “эргэж танилцуулах” гээд явчихвал энэ 5 дугаар заалт дээрээ болох

юм байна гэж би харж байна. Энэ дээр тэгж оруулах санал байна.

**С.Чинзориг** гишүүн тийм санал гаргаж байгаа бол би бас энэ дээр санал нэгдэж байна. Энэ маш чухал шүү. Иргэддээ очих ёстой юмыг нь хүртээхгүй байна гэдэг бол энэ бол хууль зөрчиж байгаа үйлдэл гэж харж байгаа.

Тиймээс энэ 5 дугаар заалтын тэр хэсэг дээр нь тэр “2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд төрсөн иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрд эзэмшүүлэх асуудлыг” гэдгийн араас “мөн сүүлийн хоёр жилийн иргэдэд очих ёстой 1072 хувьцааны ногдол ашгийг олгох тооцоог судалж эргэж танилцуулах” гэдэг юм уу, “олгох” гэдэг өгүүлбэрийг оруулах нь зөв болов уу гэсэн санал байна. Баярлалаа.

Ажлын хэсгийн ахлагчаас асууя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя. Нэгд.

Хоёрт, өмнө нь бас нэг товчхон мэдээлэл. М.Оюунчимэг гишүүн ээ.

Энэ Нийтийн хяналтын сургалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай гэсэн тогтоолын төсөл байгаа. М.Оюунчимэг гишүүн ээ. Та хараадхаарай. Таны яриад байгаа бүх юмнууд тэнд явж байгаа шүү. Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгэхээр үүний ар дээр нийтийн сонсголтой холбоотой тогтоолын төсөл байгаа.

Энэ тогтоолын төсөл дээр ард иргэдээс орж ирсэн саналуудыг багцлаад С.Чинзориг гишүүн тайлбараа хийх байх. Саналуудыг багцлаад тогтоолын төсөл

болгоод хэрэгжүүлэхээр явж байгаа. Ийм тогтоолын төсөл орж ирж байгаа.

Тэгэхээр хоёр талдаа ийм төслүүд яваад байхаар одоо нэг тийш нь гаргая гээд 5 дугаар заалтаа үндсэндээ энэ тогтоолын төсөл рүү оруулж байгаа юм.

Тэгэхээр тогтоолын төсөл дээр та харж байгаад. Жишээ нь, “2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд төрсөн иргэний шинэчилсэн бүртгэлтэй иргэн бүрд эзэмшүүлэх асуудлыг судалж” гэж байгаа шүү дээ.

Асуудлыг Улсын Их Хуралд 2023 оны 1 дүгээр улиралд багцаанд танилцуулах гээд “судалж” гэдгийг нь хаячихвал энэ чинь яг болоод явчих байхгүй юу. Асуудлыг ерөөсөө буцаж эргэж боловсруулж танилцуулах гэдэг үгээр энэ тогтоолын төсөлд оруулчад болчих гээд байгаа юм.

Хамгийн гол нь тантай санал нэг байгаа нь сая орчим шинээр төрсөн иргэддээ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын иргэн хүүхдүүддээ Тавантолгойн, өөрөөр хэлбэл төрд байгаа хувийг өгье гэж байгаа шүү дээ. Энэ дээр бид бүгдээрээ санал нэг байгаа. Тийм. Үүнийгээ ингээд засаад оруулаад явчихаж болох юм шүү. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Д.Батлут гишүүн асуултаа асууя.

**Д.Батлут:** Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе.

Энэ тогтоолын төсөлтэй холбоотой 5 дахь заалттай холбоотой асуудал дээр нэлээн анхаарах ёстой гэж харж байгаа. 1072 хувьцааг Монгол Улсын иргэн бүр хүртэж байгаа гээд бид бүхэн нэлээн сенсацитайгаар, бас

идэвхжүүлэлт хийж Монгол орон даяар нэлээн хөл хөөрцөг болцгоосон.

Гэсэн хэдий боловч энэ маань өнөөдөр хүртэл өгөөжөө өгөхгүй байгаа. Тэгээд иргэд маань ч гэсэн энэ хувьцаа байгаа эсэхдээ, энэ хувьцаа нь баталгаатай эсэхдээ эргэлзчихсэн тийм л цаг хугацаа байна.

“Эрдэнэс Тавантолгой” компани маань сүүлийн жилүүдэд ашигтай ажиллаад байдаг. Гэсэн мөртлөө иргэддээ хувьцаа, хувь хишгээ хүртээдэггүй.

Зүгээр хувийн компаниар бодъё л доо. Тухайн хувийн компани ашигтай ажиллаад ногдол ашгаа авахгүй нэг, хоёр жил болох юм бол хувьцаа эзэмшигч нар маань яах бол оо. Мэдээж шүүхэд хандана. Түүнтэй холбоотой нөхөн төлбөр, баахан л асуудлууд босож ирнэ. Нөхөж олгох асуудлууд ч босож ирнэ. Гэтэл иргэд маань 1072 хувьцаа эзэмшиж байгаа мөртлөө ногдол ашгаа авахгүй яваад байгаа нь хэр зүй зохистой юм бэ гэж.

Тэгэхээр би С.Чинзориг гишүүний тэр гаргаад байгаа энэ 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэд маань хувь хишгээ нөхөж авах ёстой гэдгийг санал нэгтэй дэмжиж байгаа юм.

Хууль нь байгаад энэ хувьцаа нь өөрөө үнэхээр л үнэт цаас болоод баталгаажчихсан л юм бол бид хуулиа биелүүлж, иргэн болгондоо энэ хувьцаагаа, хувьцааны ашиг шимийг компанийн ашиг ч бас олгож байх ёстой.

Тэгэхээр энэ тогтоол албажиж гарснаараа энэ мэт алдаа дутагдлууд ахиж гарах вий дээ. Илүү сайн бодож боловсруулж энэ хөрөнгийг бий болгох,

эргэлтэд оруулах тал дээр онцгой анхаарч ажиллах ёстой гэдэг байр суурьтай байна.

Хоёрдугаарт нь, би урдны Байнгын хорооны хурал дээр санал гаргаж байсан. Төрийн өмчийн компаниудыг бид олон нийтийн оролцоотой болгоё гэдэг дээр гишүүн болгон л ярьж байгаа. Хамгийн наад зах нь Тавантолгой компаниасаа авхуулаад бид олон нийтийн болгож эхэлье. Олон нийтийн болгосноороо менежмент сайжирна, засаглал сайжирна, цаашлаад үр өгөөж сайжирна. Янз бүрийн булхай луйвар, болж бүтэхгүй байгаа бүх зүйл гарах үүд хаалга хаагдана гэж харж байгаа.

Тийм учраас “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг иргэдэд олгохдоо 34-өөс доошгүй хувийг олгоё гэдэг санал гаргасан. Иргэдэд олгоё гэдэг.

Манай Б.Баттөмөр гишүүн тэргүүтэй гишүүд маань бас яг үүнтэй ижил төстэй саналууд гаргаад явж байна лээ. Энэ санал дэмжигдээд явсан.

Тэгэхээр энэ санал санал хураана гэж ойлгож байгаа. Зөв үү? Дарга аа. Энэ тогтоолын төсөл дээр орох уу? Байхгүй байгаа учраас би асуугаад байгаа юм.

Уг нь Байнгын хорооны хурлаар энэ асуудал яригдаад “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 34-өөс доошгүй хувь нь иргэдэд олгоё гэдэг дээр санал дэмжигдсэн. Энэ дээр нэг хариулт авъя. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулчих.

**Ж.Бат-Эрдэнэ:** Д.Батлут гишүүнтэй санал нэг байгаа.



Ер нь үндсэндээ Улсын Их Хурлын гишүүд бид чинь энэ Засгийн газрын хүрээний компаниудынхаа үйл ажиллагааг тэр бүр хянаж чадахгүй байгаа шүү дээ. Яагаад гэхээр энэ чинь өөрөө гүйцэтгэх засаглалын ажил. Засгийн газрын ажил. Тэндээс хүмүүсийг нь томилж байгаа. Тэгээд томилж байгаа хүмүүс нь болохоор цаашаа харж байгаад элдэв янзын гэрээ хийгээд явчихдаг. Нууц гэрээ ч байдаг юм уу, оффтэйк гэрээ. Тэгээд үнэ ханш нь дээр нь мэдэхгүй хаанаасаа тогтоодог юм. Дундаас нь нөгөө юу гэдэг билээ. Ашиг гаргаад ч байдаг юм уу. Ингээд янз янзын зүйл хийчхээд байгаа шүү дээ. Энэ болгоныг бид чинь хянаж чадахгүй байгаа байхгүй юу. Та ч адилхан, бие ч адилхан, энд байгаа гишүүд ч адилхан байхгүй юу.

Тэгэхээр энэ Биржийн тухай хуулийг баталсантайгаар уялдуулаад энэ Улсын Их Хурлын тогтоолыг Улсын Их Хурлын даргаас болон бид бас ярьж байгаад удирдамж гаргаад тогтоолын төсөл гаргаад явж байгаа.

Тэгэхээр тантай санал нэгтгэйгээр энэ хэрвээ тогтоол гарснаар. Өөрөөр хэлбэл олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, ингээд хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болсноор нөгөө дураараа дургиддаг зүйл маань алга болох юм. Өөрөөр хэлбэл нээлттэй биржээр харагдаж байдаг. Тэгээд 1072 хувьцаа буюу сүүлд нь нэмэгдээд 3.4, 3.5 сая ард иргэд маань төлөөлөл нь энэ компанийн удирдлага руу бас тодорхой хэмжээгээр хяналт хийгээд явах, нээлттэй болох энэ бүх боломж бололцоо маань гарах юм.

1072 маань өнөөдрийг хүртэл Хөрөнгийн бирж дээр компани болж чадаагүй. Тэндээ эргэлтэд ороогүй байгаа

шүү дээ. Төвлөрсөн хадгаламжийн газар хадгалаатай, бүртгэлтэй л байгаад байгаа болохоос биш яг бирж рүүгээ ороогүй. Компанийн систем рүүгээ хөрөнгийн бүртгэлтэй компани болж чадаагүй болохоор эргэлтэд ороогүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энд нь эргэлтэд оруулья, хяналтыг нь сайжруулья гэдгээр цаашдаа алдаа дутагдлаа хаахын тулд энэ тогтоолын төсөл маань орж ирж байгаа юм.

Хоёрдугаарт, таны оруулж ирсэн санал байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг иргэдэд эзэмшүүлэх асуудлыг судалж танилцуулах гээд орж ирж байгаа. Тэгээд Байнгын хорооны дарга бас танилцуулах байх. Дараагийн санал хураалтаар. Тийм. Санал хураалтаар явах байх. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Д.Батлут гишүүн таны гаргасан саналууд Байнгын хороон дээр хураагдаад дэмжигдээд явчихсан. Чуулган дээр санал хураагаагүй орхисон. Нээлттэй орхисон. Та мэдэж байгаа. Тийм ээ.

Тэгэхээр одоо бид нөхцөл байдал юу болсон бэ, түүнээс хойш гэхээр зэрэг Нийтийн хяналтын сонсголтой холбоотой дахиад нэг тогтоол гарах болж байгаа юм. Нийтийн хяналтын сонсголтой холбоотой тогтоол.

Тэгэхээр зэрэг энэ Биржийн хууль гарсантай холбогдуулан гаргаж байгаа тогтоол энэ хоёр чинь ингээд маш олон санаа давхцаад. Ялангуяа манай 4 гишүүний гаргасан. С.Чинзориг гишүүн, Та, Х.Ганхуяг гишүүн Г.Дамдинням

гишүүний гарсан саналууд бүгд тэр нийтийн хяналтын сонголт дээр гарсан ард иргэдийн саналтай давхцаад.

Ер нь гишүүд ард түмнийхээ талд байна л гэсэн ийм л юм харагдаж байгаа юм л даа. Ер нь санал бодол нэг байна бид нар. Харин гишүүд түрүүлээд энэ нийтийн хяналтын сонголын дүгнэлт, тайлан гарахаасаа өмнө энэ саналуудаа гаргачихсан байсан учраас энэ дүгнэлт гаргаад үүнтэй холбогдуулаад тогтоолын төсөл бичигдэнгүүт, энэ дээр давхцаад ирэнгүүт энэ рүүгээ оруулчихъя гээд ингээд явж байгаа. Одоо энэ дээр санал хураана.

Санал хураахын өмнө бид Биржийн хуулийг дагуулж гаргаж байгаа тогтоолынхоо төслийг батлаад. Эндээс Та нарын гаргасан санал. Дээр нь хоёр заалт давхацсан байгааг нийтийн хяналтын сонголынхоо тогтоол руу оруулчихъя гээд тус тусад нь санал хураагаад явчих юм.

Тэгэхээр 4 гишүүнийхээ саналыг ерөнхийдөө энд Байнгын хороон дээр ер нь үүнийг хэлэлцээд, энэ рүүгээ орж байгаа гэдгээ ойлголцолд хүрээд явчих юм бол бид аягүй юм хялбар болох гээд байгаа юм.

Энэ ерөөсөө таны агуулга тэр чигээрээ орно. Тэгэхдээ гишүүдээс өмнө нь Байнгын хороон дээр энэ саналуудыг гаргаж, дэмжигдэж байсан гэдэг нь протокол дээр тэмдэглэгдээд явчихна.

Тогтоол дээр яг наад агуулга чинь тэр чигээрээ байгаа. Та тэр юугаа хараарай. Төслийг уншиж байгаарай.

Н.Ганибал гишүүн асуултаа асууя.

**Н.Ганибал:** Яагаад бид нар чинь энэ хуулийг дагалдуулаад ийм балай асуудлууд яриад байгаа юм бэ. Энэ ямар захиалгаар ингэж яваад байгаа юм.

Ер нь сая энэ нүүрсний хулгай гэж баахан хашхирч, хашхирч тэгээд ард дээр нь гарч байгаа ганц хууль нь уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр борлуулах тухай хууль шүү дээ.

Түүнээс ямар 1072 хувьцаа, “Эрдэнэс Тавантолгой”-н тэр хувьцааг ард иргэдэд нэмэгдүүлэх ийм хууль биш шүү. Яахаараа ийм утгагүй юм ярьж хэдүүлээ ингээд сууж байгаа юм бэ.

Тэр биржээр бүтээгдэхүүнээ харин яаж хил нөхцөлөөр зарах тухай асуудлаа л өнөөдөр бид тогтоол дээрээ суулгаж өгч цааш нь явна уу гэхээс өө бүр хаа хамаагүй хуулийг дагалдуулаад энэ “Эрдэнэс Тавантолгой”-н асуудлыг оруулаад, тэр дээр нь ард түмнийг хуурдгаа больё.

Ард түмний дүн дэндүү их хуурч байна.

Одоо “Эрдэнэс Тавантолгой” компанийн нийт үнэлгээ ямрыг энэ Засгийн газар мэдэж байгаа юм уу? 1072 хувьцаа чинь өнөөдөр ямар нэгэн баталгаажсан хувцас мөн юм уу? Тэр бирж дээр ямар нэгэн бүртгэл байгаа юм уу? Байхгүй шүү дээ.

Өнөөдөр энэ “Эрдэнэс Тавантолгой” чинь 19 их наядын оффтэйк гэрээ хийчхээд байгаа шүү дээ. Хэзээ энэ ард түмэндээ хувьцаа өгөх юм бэ? Хэзээ тэр ногдол ашиг өгөх юм бэ? Тэрийг тооцоолсон байгууллага гэж байна уу? Засгийн газар гэж байна уу?



Эхлээд Засгийн газар тэр юмнуудаа эхлээд бүгдийг нь гаргаж ир. Тэр урьдчилсан төлбөрөөрөө 700 сая доллар авчихсан юм билээ. Нүүрс худалдан авах талаасаа авчихсан. Урьдчилаад.

Тэгээд жоохон нээлттэй хувьцаат компани гээд л ярингуут нөгөө Монголын олигархууд нь авах гэж байна ч гэж байх шиг. Тийм мэдээллийг зориудаар цацаад л. Хятадын худалдан авах талаасаа болохоороо 2.4 их наядын зээл авангуутаа хүүтэйгээр нүүрс нийлүүлээд өнөөдрийг хүртэл явж л байна шүү дээ.

Тэгээд ард түмэнд одоо эргээд 34 хувь, 40 хувь гээд. Боломжгүй юмнуудыг хуурамчаар амламааргүй байна.

Эхлээд бодитой тоонуудаа, боломжуудаа гаргаж ирчхээд энэ “Эрдэнэс Тавантолгой” цаашид амьдрах ямар чадвартай юм, яаж амьдрах юм. Амьдарвал хувьцаа нь яаж явах ёстой юм. Энд хөрөнгө оруулалт нь яаж татах ёстой юм. Эсвэл өнөөдөр “Эрдэнэ Тавантолгой”-гоор дамжуулаад Засгийн газар 300 сая долларын төсвийн алдагдлаа нөхчихсөн ч юм шиг. 2022 оны 4 сард авчихсан байна лээ шүү дээ. Тэр мөнгө байгаа юм уу, байхгүй юм уу? Тэр зээл нь яг тэр компани авсан зээл мөн юм уу, биш юм уу?

Энэ болгоныг бүгдийг тодорхой болгочоод дараа нь энэ асуудлаа тусад нь тогтоолын төсөл болгоод тэр “Эрдэнэс Тавантолгой” дээр ард түмэндээ яг хувьцаа өгөх юм уу, өгөхгүй юм уу? Тэрийгээ яг тодорхой ярь.

Түүнээс ийм нэг уул уурхайн бүтээгдэхүүнийг зарах тухай хуулийг дагасан, холбогдуулан арга авах арга

хэмжээг дагалдуулаад гаргаж байгаа Их Хурлын тогтоол нь “Эрдэнэс Тавантолгой”-н асуудлыг хөнддөг нь ямар ч учиртай юм. Ямар логик байгаа юм?

Энэ бол болохгүй ээ. Үүнийг ингэж оруулдаг нь ч буруу. Үүнийг бид өнөөдөр энэ тогтоол дээр оруулаад. Засгийн газар захиалсан юм уу? Та нар ингээд оруулаад ир. Бид нар тэрний чинь дагуу ард түмнийг нэг хуураад өгье гэж байгаа юм уу? Ийм байж болохгүй. Үүнийг би эсэргүүцэж байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Би дараа нь нэмээд хариулчихъя. Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Ганибал гишүүн ээ, энэ үнэхээр Тавантолгойн 1072 чинь тантай санал нэг байна л даа. Эргэлтэд ороогүй шүү дээ.

Тэгээд бид ингээд л хойш нь тавьсаар байгаад л өнөөдрийг хүрээд л. Өнөөдрийг хүрсээр байгаад л. Хойш нь хойш нь. Болохгүй болохгүй гэж ингэж авч явсаар байгаад өнөөдрийг хүртэл бид энэ ард иргэддээ үр өгөөжийг нь ч үзүүлэлгүй ингээд явчихлаа шүү дээ.

Тэгээд одоо нэг алдаа гаргасан. Алдаа дутагдлаа цэгнэж байгаа дээрээ асуудлаа шийдээд явчихъя л даа гэж байгаа шүү дээ. Өнөөдөр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид л хадгалаатай болохоос биш 1072 хувьцаа яг бирж дээр гарах, иргэддээ үр өгөөжөө өгөх ийм боломж бололцоо нь хаалттай байгаад байгаа байхгүй юу. Хаалттай компани.

Тэгэхийн тулд үүнийгээ нээлттэй компани болгочихъё. Нийтийн хяналт, оролцоог нь нэмэгдүүлчихье. Хөрөнгийн

биржид бүртгэлтэй компани болчихъё гэж байгаа юм.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болчихвол энэ бол эдийн засгийн эргэлтэд орох ийм нөхцөл бололцоо гарчихна. Өөрөө энэ чинь хяналтдаа орчихно. Ил тод болчихно. Үүнийг бид айгаад байх юм байхгүй. Энэ чинь биржийн асуудлаа мэдэж байгаа. Хэн ч хүн ойлгомжтой шүү дээ. Тэр чинь ил тодоор бүгдээрээ ингээд гараад ирчих байхгүй юу даа.

Тийм болохоор энэ дээр хардах айх зүйл байхгүй ээ. Одоо өнөөдөр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид хадгалаатай байгаа энэ 1072-ыгөө л ашиглалтад оруулъя гэж байгаа юм.

Дээрээс нь миний түрүүний ярьсан шүү дээ. Нэг сая орчим шинэ иргэддээ өгчихье л дөө. Үүнийгээ. Эргэлтэд оруулчихъя. Боломж бололцоог нь нээчихье. Хойш нь тавиад яах вэ л гэж байгаа юм шүү. Тийм. Н.Ганибал гишүүн ээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн ахлагчийн хариулсан хариулт дээр нэмээд хариулчихъя.

Манай Н.Ганибал гишүүн хамгийн гол нь энэ Биржийн хуультай огт холбоогүй юмтай холбоод тогтоол болгож оруулж ирэх гээд байна. Энэ тогтоол дунд энэ Тавантолгойн асуудал хамаагүй юм гээд байгаа юм.

Хамгаас хамаатай байгаа юм. Биржийн хууль угаасаа төсөл явж байсан. Биржийн хууль дээр ажиллаж байсан. Гэхдээ энэ цаг нөхцөл байдал бидэнд ямар шаардлага бий болсон гэхээр зэрэг энэ төрийн өмчтэй компаниуд дээр явж байгаа үйл ажиллагаа ил тод биш байна.

Ийм учраас Биржийн хуулийг яаралтай түргэн гаргая гээд Биржийнхээ хууль дээр шаргуу ажилласан юм.

Энэ бол энэ ил тод байдал, тэр гэрээ, тэр бараа, бүтээгдэхүүнээ ямар үнээр хэнтэй яаж хийдгийг нь бид мэдэхгүй байна. Энэ бол нэг талаасаа хийж байгаа ажил. Тэгтэл нөгөө талаас нь дахиад бид нар энэ олон нийтийн хяналтыг оруулж ирэх, энэ засаглалыг нь сайжруулах чиглэл рүү давхиад цаг алдахгүй бас арга хэмжээ авах хэрэгтэй юм байна гэдэг агуулгаар энэ тогтоолын төсөл орж ирсэн. Энэ хоёр хоорондоо шууд холбоотой. Нэгд.

Хоёрт, энэ үед юу болсон. Нийтийн хяналтын сонголт болсон. Тавантолгойн асуудал. Тийм үү. Нүүрсний хулгайтай холбоотой асуудал. Эндээс гарч ирсэн иргэдийн санал. Тэнд байсан гишүүд ч санал гаргаж байсан.

Ингээд энэ бүгдийн саналуудыг нэгтгээд гаргаад ирэхээр энэ Тавантолгой компанийг гарцаагүй нээлттэй болгох ийм шаардлага ард түмэн тавьж байгаа юм. Бид нар, гишүүд хүртэл тавьж байгаа.

Сая хүртэл ярьсан. Одоо манай 4 гишүүн хүртэл Байнгын хороон дээр санал гаргаж байсан. Эд нар бүгд яг үүнтэй давхцаж байгаа учраас энэ “Нийтийн хяналтын сонголттой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол гарна.

Энэ тогтоол дээрээ энэ санаануудаа суулгаад өгчихье гээд өнөөдөр би санал хураалгана. Энэ зөвхөн яг биржтэйгээ холбоотой, Биржийнхээ хуультай холбоотой, Биржийн хуулиа яаж үр дүнтэй хэрэгжүүлэх вэ гэдэг рүү чиглэсэн, чиглэл өгсөн, Засгийн газар

луугаа энэ хуультайгаа холбогдуулан гаргасан Их хурлаас гаргаж байгаа тогтоол бол энэ Биржийн хуультайгаа холбогдуулж бид Байнгын хороон дээр хэлэлцэж байгаа юм шүү.

О.Цогтгэрэл гишүүн асуулт асууя. Н.Ганибал гишүүн нэмж асуултаа тодруулж асууя. 1 минут.

**Н.Ганибал:** 1072-ын асуудлыг яаралтай ярих нь зөв өө. Зөв гээд байгаа байхгүй юу.

Гэхдээ хууль баталсантай холбогдуулаад авах арга хэмжээний 5 дугаар заалт болгоод ийм бүдэгхэн байдлаар явуулмааргүй байна. Үүнийгээ маш тодорхой болгож байгаад явуулъя. Тэгэхгүй өнөөдөр бид нэг тоо яриад 34, 40, тэгээд шинээр тэдэн оноос өмнөх хүүхдүүд гээд нэг ийм гуравхан асуудлыг тойрч яриад байгаа байхгүй юу.

Энэ компани чинь ер нь ямар байгаа юм бэ? Энэ компанийнхаа эхлээд тэр үйл ажиллагааны хорих юмнуудыг нь хорьё л доо. Тэгж байж тэр ард түмний авах ашгийг нь нэмэгдүүлбэ. Цаашлаад эргээд энэ баахан оффтэйк гэрээнүүдийг санхүүжүүлэх юм уу? Жишээлбэл, бүр ямар ч энэ компанид үл хамаарах оффтэйк гэрээнүүдийг тэр нефть дамжуулах хоолойн оффтэйк гэрээ хийчихсэн, Тавантолгойн цахилгаан станцын оффтэйк гэрээ хийчихсэн. Тэр ямар хамаатай юм. Тэр төмөр зам нь яах вэ, хувийг нь эзэмшиж байгаа бол тэрийг нь тодорхой болгоод энэ компаниа эхлээд цэгцэлчих.

**Ц.Цэрэнпунцаг:** Н.Ганибал гишүүн. Таны хэлж байгаа санаатай нэг байгаа юм. Та бид хоёр нэг л ойлголттой байгаа юм байна. Нэг саналтай байгаа юм байна гэж бодож байна.

Ер нь та сая хэлж байна. Энэ бүдэг бадаг байна гээд. Зүгээр тогтоолын нэг зүйл, заалт болгоод ингээд бүдэг бадаг оруулж ирж байна гээд.

Би бүр тодоос тод үүнийг тусгах гээд. Тэгээд чуулган дээр хүртэл, Байнгын хороон дээр хүртэл дайн үүссэн. Та байсан уу, үгүй юу. Ялангуяа танай намын гишүүд намайг үүнийг ил тод болгож, бүр нарийн одоо үүнийг нээлттэй ил тод болгох, яах ёстойг нь зааж тогтоолын төсөл дээр тусгаад ороод ирэхээр танай намын нөхдүүд, журмын нөхөд чинь, С.Ганбаатар гишүүн гээд би нэг нэр хэлчихье. Ингээд чуулган дээр над руу янз бүрээр дайрч, энэ хувьчлах гэж байна, Тавантолгойг ингэх гэж байна гээд л ийм болгоод дайрсан шүү.

Тэгээд энэ асуудлыг бид. Тэгвэл гишүүн миний гаргасан, миний Байнгын хорооноос дэмжээд явж байгаа, гишүүний хувьд дэмжээд явж байгаа тэр саналуудыг дэмжихгүй байвал тэгвэл ард түмнийг хар. Энэ нийтийн хяналтын сонсгол дээр ард түмний гаргасан санал дандаа энэ байгаа.

Тэгэхээр энэ дээр нэгд ард түмэн саналаа гаргачихсан учраас бид одоо бас арай ингэж эсэргүүцэхгүй байх гэж бодоод бид ер нь ярилцаад энэ ажлын хэсэгтэй ярилцаад Биржийнхээ хуулийг сая хэлсэн. Яг таны хэлдгээр Биржийнхээ хуультай холбоотой тогтоолын заалтуудыг энэ дээрээ тусгаад, энэ тогтоол дээрээ тусгаад нөгөөдөхийг нь нийтийн хяналтын сонсголынхтой холбогдуулан гаргах тогтоол дээр тусгачихъя гээд ингээд явж байгаа юм шүү.

О.Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Энэ Биржийн хуулийг мэдээж дэмжиж байгаа.

Тэгэхдээ сая Н.Ганибал гишүүний ярьдаг Тавантолгойн асуудал гэдэг чинь, Тавантолгойг олон нийтэд нээлттэй болгох гэдэг асуудал чинь өөрөө том асуудал байгаад байна л даа. Үүнийг Биржийн хуулийн тогтоолын нэг заалт, хавсралт байдлаар ингэж орох чинь өөрөө зохимжгүй байгаад байна л даа. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, ер нь цаашдаа тэгээд яах юм. Тавантолгой гэдэг чинь бас цагаа тулбал Монголын уул уурхайн нэг л орд. Тэгээд бусад ордууд болоод ер нь бусад улс оронд чинь уул уурхайн баялгийг чинь олон нийтэд хүргэдэг тэр баялгийн сангийн менежмент гээд нэг том зүйл байх шиг байгаа юм. Манайхан чинь гадагшаа дотогшоо судалж олон л удаа гадагшаа явсан байх.

Тэр асуудал гол нь хаачихсан юм бэ. Одоо тэр нэг нүүрсний уурхай дээр хувь хувьцааны асуудал ярьж байна. Удахгүй аяндаа Эрдэнэтийн асуудал. Эрдэнэтийг тэгье, ингэе гээд л босоод ирнэ.

Ер нь энэ баялгийн сангийн асуудал, Оюу Толгой. Дахиад шинээр нэг орд нээгдвэл яах юм. Бүгдийг нь ингээд л хэсэглээд л бараг энэ том бүхэл бүтэн уул уурхайн баялгийн сан, баялгийн менежмент гээд энэ том асуудлыг чинь ингээд. Нөгөө энгийнээр нөгөө хаа гуяар нь салгаад ингээд жижиглээд яваад байх юм уу. Тус бүрд нь яриад яваад байх юм уу. Нөгөө баялгийн сангийн менежмент гэдэг тэр дэлхий нийтэд шалгарсан арга. Энэ чинь зөвхөн нэг баялаг хувааж эзэмшихдээ ч биш. Үүний цаана тэр бусад салбартаа хэрхэн нөлөөлөх вэ.

Балансыг нь барих уу. Тэр Голланд өвчин ч гэдэг. Олон зүйл. Энэ чинь эдийн засгийн том агуулгаараа эдийн засгийн балансаа тэнцвэрээ барьж явахад олон зүйл үүний цаана байдаг том бодлогын асуудал юм шиг байгаа юм.

Тэгэхээр одоо ингээд нэг ийм улс төрийн асуудал босож ирэхээр тэр тэрэнд нь таарсан гал унтраах арга хийгээд уурхайн уурхайд зориулсан бодлого цаашид аваад яваад байх юм уу. Баялаг баялаг бүхэн тэнд гарч ирж байгаа тус бүрд нь зориулаад ингээд жижиглээд л яваад байх юм уу?

Гол нь Эдийн засгийн байнгын хороон дээр Баялгийн сангийн менежментийн тухай тэр хууль бодлого маань хаана явна. Бараг үүнийгээ нэгтгэж үүн дээр чинь ярьж байж энэ 1072-ын асуудал чинь яригдах ёстой юм биш үү. Цаг хугацаа болоод ач холбогдол, эрэмбэ дарааллын хувьд. Ийм л нэг бодол байна. Ажлын хэсэг дээр энэ дээр ярилцсан зүйл байдаг юм уу. Тодруулж өгөөч.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулья.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ Ашигт малтмалын тухай хууль шинэчилсэн найруулга явж байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгээд энэ хүрээнд тэр баялагтай холбоотой асуудлууд нэлээн дэлгэрэнгүй ороод ирэх болов уу гэж бодож байгаа юм. Өнөөдөр яагаад энэ Уул уурхайн биржийн тухай хууль. Мэдээж Уул уурхайн биржийн тухай хуулийг О.Цогтгэрэл гишүүн та болон бид бүгдээрээ л сайхан дэмжээд зүй зохисоор нь явуулья гээд ингээд л орж ирж байгаа юм.

Тэгтэл энэ “Эрдэнэс Тавантолгой” компанитай холбоотой, тэр тусмаа ард иргэдэд очих ёстой 1072 хувьцаагаа. Бид хийх ёстой юмаа хийхгүй л өнөөдрийг хүргэчхээд байгаа байхгүй юу даа. Зайлшгүй хийх ёстой.

Энэ чинь 2012 онд бүртгэлтэй 1072 хувьцаа өглөө гээд л ард иргэдэд баярлуулаад л ийм зүйл хийчхээд өнөөдрийг хүртэл бид хаалттай явчхаад байгаа байхгүй юу даа. Түрүүн Н.Ганибал гишүүн хүртэл хэллээ шүү дээ.

Ард түмнийг бид 2012 оноос хойш дахиад л хуурчихсан байгаа байхгүй юу. Хаалттай компаниа энэ чигээр нь явуулчихсан л байгаа байхгүй юу даа. Тийм болохоор хийх ёстой юмнуудаа ядаж хийчихье.

1072-ыгоо эргэлтэд нь оруулчихъя. Дээрээс нь нөгөө сая иргэндээ өгчихье. Хийх ёстой юмаа хийчихье. Тэгчхээд харин дараагийнхаа хуульд ер нь баялгийн сангаа яах юм. Энэ төрийн өмчит компаниудаа яах юм. Хаана нь байх юм. “Эрдэнэс Тавантолгой” болон тэр баялгийн сантай холбоотойгоор бусад компаниуд нэг доор байж байх юм уу. Ямар хүрээлэлд байх юм. Засгийн газрын дэргэд байх юм уу. Эсвэл тусдаа Уул уурхайн яамныхаа дэргэд байх юм уу. Жишээ нь, би Уул уурхайн яамных нь дэргэд нь байлгаад явбал яасан юм гэсэн санаа байж байдаг юм. Наад дээр чинь.

Тэгэхээр энэ хийх зүйлүүд бол дараагийнх нь асуудлаар томоороо ороод ирэх байх. Хэдүүлээ үүнийг дараа нь би ярилцъя. Гагцхүү хийх гээд хийх ёстой байгаад өнөөдрийг хүртэл хийж чадаагүй зүйлээ хэдүүлээ нөхөөд хийчихвэл яасан

юм бэ гэдгээ Ажлын хэсэг ийм зүйлийг оруулж ирж байгаа юм. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Сая Ж.Бат-Эрдэнэ, ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн бас тодорхой тайлбарлалаа. О.Цогтгэрэл гишүүн ээ.

Энэ Баялгийн сангийн хууль бол Засгийн газар дээр явж байгаа юм. Тэгээд энэ одоо орж ирээгүй байна. Хэзээ орж ирэх юм. Энэ хугацаанд ямар ч байсан энэ зөндөө хугацаа алдаад байна. Яг Ж.Бат-Эрдэнэ гишүүний хэлснээр бид нэгэнт өмнө нь гарчихсан хийх ёстой ажлаа хийхгүй байгаа учраас үүнийг шахаж сануулж өгье. Энэ чиглэл рүүгээ юу хийх юм. Тэрийгээ эргэж Байнгын хороон дээр орж ирж мэдэгдээч ээ гэж байгаа юм.

Одоо үүнийг. Тийм. Явцтай нарийн танилцъя. Дээрээс нь яг тантай санал нэг байгаа. Бид энэ асуудлыг нэг талд нь нэг мөсөн шийдэхийн тулд энэ чиглэл рүү явж байгаа хууль, ажиллаж байгаа юмнууд байдаг бол эд нар нь шахаж, багцалж ойролцоо нэг нэгэнтэйгээ уялдаа холбоотой орж ирж явах чиглэл рүү нь ажлыг бүгдээрээ Байнгын хороон дээрээ сонсьё.

Тэгээд Засгийн газрыг дахиж энэ тогтоол гарсны дараа тодорхой хугацаанд энэ чиглэлээр юу хийсэн тухай нь авч хэлэлцэхдээ энэ дээр нь тэр дараагийн хууль нь хаана явж байна. Нэгмөсөн одоо бид нар сайн шийдэлд хүрчих ямар бололцоо байна. Цөмөөрөө Байнгын хороон дээр үүнийг бүр онцгойлон авч хэлэлцье.

Т.Доржханд гишүүн та асуултаа асууя. Т.Доржханд гишүүний микрофоныг.

**Т.Доржханд:** Баярлалаа. Энэ Биржийн хууль батлагдсантай холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоол гарч байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр нэг ийм зүйлийг л анхаарчихмаар. Ц.Цэрэнпунцаг дарга аа, ажлын хэсгийнхэн.

Монгол Улс бол өөрөө ингээд газрын доороо маш их баялагтай мөртлөө юмаа зарж чаддаггүй, тээвэрлэж чаддаггүйг харлаа шүү дээ. Гэтэл бирж гээд судлаад үзэх юм бол хамгийн их Ази дээр юмаа, эрдэс түүхий эдийг зарж борлуулдаг бирж нь хаана байна вэ гэхээр Хонг Конгийн бирж байна. Хонг Конгийн түүхий эдийн бирж.

Тэгээд энэ чинь нийт яг энэ бүс нутгуудын 70-аас 80 хувийг ингээд арилжиж байгаа байхгүй юу. Гэтэл Хонг Конг гэдэг нь өөрөө газрынхаа доор эрдэс баялаг байна уу гэхээр байхгүй. Тэгсэн мөртлөө тэндээсээ, арилжаанаасаа ашгаа олоод, орлогоо олоод. Тэгээд тэр Хонг Конг гэдэг улс үндэстнээрээ бас ингээд өндөр орлоготой амьдарч байна.

Үүгээрээ юу хэлэх гээд байна гээд тэгэхээр бид одоо яг энэ уламжлалт байдлаар, уламжлалт биржийн байдлаар өрсөлдөөд явах юм бол бүтэхгүй ээ. Байхгүй.

Гэтэл дэлхийн биржүүд чинь бүгдээрээ энэ гар утас руу шилжээд, блокчейн технологи руу ороод, одоо Лондонгийн эксченж ч гэдэг юм уу, металлын бирж ч гэдэг юм уу бүгдээрээ ингээд блокчейн дээр үндэслэсэн ийм цахим руу орчихоод байгаа байхгүй юу.

Тэгээд цахим руу орж байгаа тохиолдолд манай үндэсний компаниуд энэ цахим платформуудыг нь бүгдийг нь

угсарчихсан хоёр, гуравхан компаниуд байна аа. Байна. Хангалттай.

Тэгэхээр бид ингээд Хонг Конгийн биржтэй өрсөлдье гээд тэгэх юм бол зөвхөн Монгол Улсын эрдэс, түүхий эдийг зарах биш бусад энэ хажууд байгаа Казакстан гэдэг юм уу, хойно байгаа Оросын ч гэдэг юм уу, энэ Эрхүүгийн энэ хавийн бүтээгдэхүүнүүдийг зарах хэрэгтэй байхгүй юу. Зарахын тулд энэ платформ нь өөрөө ингээд олон тоглогчтой, тэгээд олон худалдан авагчтай ийм байдлаар явах боломж нь энэ цахим бирж байгаа шүү.

Тийм болохоор энэ цахим биржийг үндэсний компаниудтай хамтарч ажиллуулах нь зүйтэй гэдэг ийм чиглэлийг тогтоолдоо тусгаж өгмөөр байна. Ингэж бид хөгжлийг товчлох боломж байна гэж. Нэг.

Хоёр дахь зүйл нь юу байна вэ гээд тэгэхээр. Би бас энэ О.Цогтгэрэл гишүүн, Н.Ганибал гишүүн эд нартай бас нэг талаар санал нэг байна л даа. Үндэсний баялгийн сан гэдэг энэ платформоо бид угсраагүй мөртлөө өнөөдөр өм цөм ингээд явах нь буруу шүү дээ. Буруу байхгүй юу.

Тэгэхээр өчигдөр Засгийн газраас өргөн барьсан гэсэн. Нийгмийн даатгалын цогц нөгөө багц хуулиа. Тэгээд бодвол Баялгийн сангийнх нь агуулга орж ирж байгаа байлгүй дээ.

Түүнтэйгээ уялдуулаад явах ёстой юм биш үү дээ. Тэгээд тэндээсээ бид зөвхөн “Эрдэнэс Тавантолгой” биш Эрдэнэт ч гэдэг юм уу, бусад уул уурхайн төрийн өмчийн компаниудаа яаж орлогыг нь бид төвлөрүүлэх юм. Хэдэн хувийг нь төрд байх юм, хэдэн хувь нь хувийн сектор байх юм, хэдэн хувь нь иргэд байх



юм бэ гэдгээ маш тодорхой болгосны дараа үүнийгээ ярихгүй бол зөвхөн энэ “Эрдэнэс Тавантолгой” гээд явахаар өрөөсгөл байна л гэж харж байна.

Эдийн засагч хүний хувьд үүнийг нээлттэй болгоод Хөрөнгийн биржид бүртгэлтэй байх нь зүйтэй. Үүнийгээ зүгээр энэ тогтоолоор хийгээд явах нь зүйтэй байх.

Харин цаашаа нэг хулгай гараад ирэнгүүт л ард түмэндээ нэг хайр зарласан. Тэгээд л тэдэн хувийг нь иргэддээ өгье гээд явдаг нь буруу байх. Нэг хэсэг нь 40 хувь гэж явж байна. Дараагийн хэсэг нь болохоороо 60 хувь гээд л. Бүр их хулгайч нөхдүүд тухайлбал ингээд л 100 хувь өгнө ч гэдэг юм уу ингээд попоороо явчихдаг. Гэтэл бодит байдал дээр чинь энэ яг Оюу Толгойтой адилхан байхгүй юу. Оюу Толгойгоо бид 15 жил тухайлбал 34 хувь авчихсан гэсэн мөртлөө 34 хувьд ногдох өр нь гэсэн чинь 22 тэрбум доллар болчихоод байна гээд. Шилний цаанаас чихэр долоолгоод байхтай яг адилхан өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой”-н хөрөнгө оруулалтаар 18, 19 их наяд төгрөгөөр чинь хөрөнгө оруулалт, үр ашиггүй бүтээн байгуулалт хийчихсэн. Оффтэйк гэрээгээр. Хэзээ ч монголчууд үүнийг эзэмшлээ гээд үр дүнгээ үзэхгүй.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Та нэмж авах юм уу? Т.Доржханд гишүүнд нэмж 1 минут өгье.

**Т.Доржханд:** Тэгэхээр бид зөв асуудлыг хөндөх гэж байгаад ард түмэнд таалагдах гэсэн байдлаар буруу тийшээ эргүүлчхэж болохгүй.

Ийм болохоор агуулгаар нь, цогцоор нь асуудалд хандах нь зүйтэй. Бүх уул уурхайн компани. Эрдэнэтийг

оруулмаар байгаа юм. Өнөөдрийн хулгай юунаас болоод байна вэ гэхээр хаалттай төрийн өмч. Тэгээд төрөөс дарга томилдог болохоор тэнд чинь хулгай болоод байгаа. Үр ашиггүй ийм нөхцөл байдал үүсээд байна шүү дээ.

Төмөр зам яасан. 40, 50 тэрбум төгрөгийн алдагдалтай гэсэн мөртлөө нэг залуугаас л 10 тэрбум төгрөг гарч ирж байна гээд. Энэ чинь л бодит жишээ шүү дээ. Ийм болохоор бүх компаниудыг нээлттэй болгох энэ зарчмаа бариад явах нь зүйтэй.

Ингэхийн тулд бид хувь оролцоог одоо ингэж оролдоод тэд эд гэж яримааргүй байна. Тэгж ярьж байгаа юмыг Улсын Их Хурлын дээр хаамаар байна.

Ингээд иргэддээ зөв мэдээллийг нь өгөөд. Гол нь хувийн менежментийг оруулаад, үр ашгийг нь өсгөсний дараа, үнэлгээг нь өсгөсний дараа харин иргэддээ болон хувийн сектор оролцсон хэд байх вэ гэдэг нь ярьдаг.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Та тэгвэл. Энэ тогтоолын төсөл дээр орчихсон. Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулаадахья. Дараа нь би нэмж хариулья.

**Ж.Бат-Эрдэнэ:** Т.Доржханд гишүүнтэй ерөнхийдөө санаа нэг байгаа юм.

Би хоёр дахь удаагаа энэ Их Хуралд сууж байгаа юм. Тэгээд энэ микрофоны араас хэдүүлээ гишүүд ингээд л янз янзын саналуудаа ингээд л хийгээд л байдаг, яриад л байдаг, яриад л байдаг.

Энэ маань яг хэзээ ажил болдог вэ гээд тэгэхээр үүрэг, даалгавар өгч байж, Засгийн газар дээр очиж байж, чихдэж байж бид ажил олгодог шүү дээ.

Тэгэхгүй бол сайхан сайхан зүйлүүдийг яриад хэн биелүүлэх юм бэ. Хэн хийх юм бэ. Тэр чинь Засгийн газар л хийдэг шүү дээ. Зөндөө олон сайхан ярьсан юмнууд маань ажил болохгүй өнөөдрийг хүртэл яваад л байгаа байхгүй юу даа.

Тийм болохоор би хэллээ шүү дээ. Баялгийн сангийн тухай хуультай санал нэг байна. О.Цогтгэрэл гишүүнтэй санал нэг байна. Н.Ганибал тантай ч санал нэг байна.

Хамгийн гол нь хэдүүлээ тэгвэл энэ дээр зарчмын зөрүүтэй санал руу оруулж ирж байгаад энэ дээр гэх юм уу, нэмэлт санал болгоод бүр үүрэг, даалгавар өгчихье. Тэдний дотор оруулж ир гээд.

Ингэж араас нь мөшгиж, хөөж. Та жишээ нь яаманд ажиллаж байсан. Би ч яамд ажиллаж байсан. Ингэж сайд нарт даалгавар өгөөд ингээд араас нь ярихгүй бол бид эндээс ингээд нэг сайхан сайхан зүйлүүдийг ярьдаг. Энэ зүйлийг ард иргэд маань хараад л алга ташаад л өнгөрчихдөг. Цаана нь яг гүйцэтдэг засаглал маань үүнийг шүүрж авч чадаж байгаа юу гэдэг л асуудал болчихоод байдаг байхгүй юу.

Тийм болохоор өнөөдөр энэ асуудлыг жишээ нь Эрдэнэс Тавантолгойтой асуудал. Би түрүүн хэлсэн шүү дээ. Хийх ёстой ажлаа өнөөдрийг хүртэл бид хийгээгүй байхгүй юу даа. Тийм болохоор үүнийг ядаж үүрэг, даалгавар өгөөд хийлгүүлчихье.

Тэгээд магадгүй зүгээр 6 дугаар зүйл болгоод юм уу, 7 дугаар зүйл болгоод юм уу та санал гаргаад ёстой Баялгийн сантай холбоотой асуудлаа томоор нь оруулж ир. Тэгэхдээ тэдэн сарын тэдний дотор оруулж ирээч ээ гээд хэдүүлээ нэг үр дүнтэй юм л болгох гээд байгаа нь энэ байхгүй юу даа. Тийм.

Тэгэхээр магадгүй зүгээр дараагийнхаа хэдүүлээ юу руу оруулаад ингээд явчихад болох байх.

Нөгөө платформтой холбоотой асуудалд энэ 3 дугаар зүйлийг та нэг хараадхаарай. Уул уурхайн бүтээгдэхүүн биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын гэж байгаа шүү. Үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн систем, программ хангамжийг биржийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой эсэхийг судалж, холбогдох арга хэмжээ авах гэж байгаа юм.

Тэгэхээр тэр платформыг үнэхээр монголчууд маань өөрсдөө хийж чадаж байгаа. Тэрийгээ ямар хэмжээнд хийж байгаа юм. Тэр саналыг нь танилцъя. Тэгээд олон улсын хэмжээнд ч байдаг юм уу, цахим байдлаар хийх боломж бололцоо байна уу гэдгээр энд ийм заалт оруулаад ирсэн. Яг таны саналтай чинь нэг байгаа байх гэж ойлгож байгаа шүү. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Т.Доржханд гишүүний санаа зовж ярьж байгаатай санал нэг байгаа. Ялангуяа манай Байнгын хорооны гишүүд ерөнхийдөө энэ дээр ер нь ихэнх нь Т.Доржханд гишүүн ээ. Бид бүгд санал нэгтэй юм бол гарцаа байхгүй энэ өвчний онош бол энэ байна гээд бүгд эмч нар өвчнийг оношлоод нэгдэж байгаа юм шиг



Байнгын хороо энэ төрийн өмчтэй компаниуд дээр байдаг энэ заваан юм нийгмийг бухимдуулж байна.

Үүний цаад шалтгаан нь ерөөсөө нээлттэй биш, олон нийтийн хувьцаа эзэмшигчдийнх нь эздийнх нь хяналт байхгүй хувьцаат компанийн хуулиар явдаггүй. Тийм ээ. Хөрөнгө эзэмшигч хөрөнгийн менежмент хийж хийж байгаа энэ хоёр чинь хувьцаат компани чинь энэ хоёрыг салгаж байгаа гол агуулга байгаа шүү дээ. Тэгтэл энэ хоёрын хоёуланг нь хөрөнгийн эзний эрхийг нь чиг л Засгийн газар ард түмний өмнөөс гүйцэтгэж эрхийг нь эдэлж байдаг. Нөгөө менежментийн удирдлагыг нь хөрөнгийг нь удирдах, нөгөө менежментийг нь авчирч тавихдаа Засгийн газар нь тавьж л байдаг. Энэ хоёрыг л бид салгаж өгмөөр байгаа юм. Энэ дээр санал нэг байгаа.

Сая Ж.Бат-Эрдэнэ гишүүн ч хэлж байна. Бид анхнаасаа оруулж ирээд л Ж.Бат-Эрдэнэ гишүүн энэ ажлын хэсэг дээр ажилласан. Ер нь ингэж шахаад нарийвчилж тусгаад үүнийг явуулъя гээд, 1072 гээд л оруулаад л явсан чинь юу боллоо. Чуулган дээр. Т.Доржанд гишүүн та байсан уу, үгүй юу.

Энэ ийм бас эсэргүүцэл гарч ирдэг юм байна лээ. Энэ буруу ойлголцлоос үүссэн үү. Ямар учиртай юм бүү мэд. Тэгэхдээ ингээд Байнгын хороон дээр ингээд эрүүл саруул бид ярихад Эдийн засгийн байнгын хороо л үүнийг гарцаагүй санаа зовж ярьж байгаа юм.

Дээрээс нь өмчийг эзэд нь өгье. Тэр хувийн өмчийг, ялангуяа хамгаалдаг, хүний өмчийг хамгаалдаг, хөрөнгийг хамгаалдаг тэр үнэт зүйлийг, энэ зарчмыг алдахгүй байя. Ялангуяа энэ Тавантолгой, жижиг Тавантолгой дээр гарсан суудал дээр хүртэл ярьсан. Тийм

үү. 49 хувь нь өнөөдөр хяналтаа тавиад ингээд явж байгаа хувийн компани дээр хүртэл бүрэн эрхт төлөөлөгч тавигдсан асуудалд бид яригдсан шүү дээ.

Энэ дээр бүгд энэ тал дээр бид энэ хувийн өмч гэдэг юм бол чухал. Үүнийг хамгаалах тал дээр компани хувьцаат компанийнхаа хуулиар л явах ёстой байхгүй юу. Тэр хувьцаа эзэмшигч нийлж байгаад бүрэн эрхт төлөөлөгч тавья гэсэн бол тавина биз дээ.

Тэгэхээр энэ бол нэг талаасаа ингээд энэ хувьцаат компанийн хуулиар явахгүй байгаа юм байна гэдэг дээр бид үүнийг явуулах чиглэл рүү нь явуулъя. Нээлттэй болгоё гэдэг дээр бүгд санал нэг байгаа.

Тэгээд 34 хувь гээд нэг ийм тоонууд гарч ирсэн дээр та ойлгоорой. Энэ хамгийн гол нь ард түмэндээ. Одоо Д.Батлут гишүүн Байнгын хороон дээр санал хураалгасан. Тийм ээ. Энэ бол зүгээр яах вэ ингээд нэг ийм тэр талаасаа биш. 34 гэдэг тоо түүнээс дээш гэдэг тоо ямар агуулгаар гарч ирсэн юм гэхээр зэрэг энэ компанийн хяналтын багц болгож өгч байж тэр хяналт, төлөөлөн удирдах зөвлөл, хяналтынхаа хороог байгуулах эрхийг нь нээж өгч болох юм. Тэр нь өнөөдөр хүүхдүүд маань ингээд дунд нь завсарлаад үлдчихсэн байгаа. Хүүхдүүдийн хувьцааг нь өгвөл бараг гучин хэд аваад ингээд л ард түмэндээ нэг ийм хяналтыг нь өгөх л арга л бодож л энэ тоо гаргаж ирж энэ агуулгаар ярьсан байх гэж Д.Батлут гишүүнийг ойлгож байгаа. Гишүүн ч тэгж ойлгосон. Тэгээд эхний энэ Байнгын хороон дээр үүнийг дэмжээд бид явсан юм байгаа юм шүү.

Ингээд Д.Бат-Эрдэнэ эгшин асуултаа асууя дээ. Д.Бат-Эрдэнэ гишүүн.

**Д.Бат-Эрдэнэ:** Гишүүдийнхээ энэ өдрийн амраг эрье.

Тэгэхээр Монгол Улсад төсвийн нэгдсэн бодлого алдагдсан. Хэдэн төсөвтэйгөө бид мэдэхээ байсан. Их Хурлын гишүүд маань тойрогтоо төсөв мөнгө татах гэж, төсвийн хөрөнгө оруулалт татах гэж баахан ярьдаг. Гэтэл төсвөөс том хөрөнгүүд “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой” гэх мэтийн том стратегийн ордууд дээр эргэж байдаг.

Тэгэхээр энэ асуудал чинь уг нь тэндхийн ногдол ашиг татвараас Монгол Улсын нэгдсэн төсөв бүрдээд үүнийгээ Их Хурал дээр эдийн засгийнхаа Байнгын хороон дээр цаашдаа хэрхэн хөрөнгө оруулалт хийх вэ гэж ярих ёстой юм маань дахиад бид юмыг дандаа араас нь хөөж ярьдаг болчихсоныгоо цаашдаа анхаарах хэрэгтэй юм.

Өнөөдөр ажлын хэсгийн явж байгаа ажлыг дэмжиж байгаа. Уул уурхайн бирж Монголд зайлшгүй шаардлагатай. Энэ юу гэсэн үг вэ гэхээр ер нь уул уурхайн бүтээгдэхүүнийгээ энэ зах зээлээ хамгийн өндөр үнээр зарья л гэсэн үг шүү дээ. Ер нь жирийн үгээр. Үүнийгээ л бид цаашдаа сайн хийх ёстой. Гэхдээ энэ уул уурхайн биржийг ажиллуулах гэж байгаад өнөөдрийн экспорт маань эдийн засагт маань нэмэр болж байгаа энэ нүүрсний экспорт нэг өдөр ч гацаж болохгүй шүү гэдгийг бид цаашдаа их сайн анхаарах ёстой юм.

Яг үнэндээ одоо ингээд ажлын хэсгийн хэнээс ч асуусан “Эрдэнэс Тавантолгой” өөрөө ямар үнэтэй юм бэ. Value хэд юм гэхээр хэлэх хүн байхгүй шүү дээ. 1072 хувьцаа ямар үнэтэй юм гэхээр мэдэх хүн байхгүй шүү дээ. 1072 хувьцаа гэж байхгүй. Хөрөнгийн бирж

дээр хувьцаа нь үнэтэй. Тэр нь тодорхой 15-аас 20 хувийн ногдол ашиг өгч үнэ нь тогтож байдаг ийм хувьцаатай компанийг л хувьцаат компани гэх болохоос биш үнэлгээгүй, худлаа ингэсэн ийм хөрөнгийн хаалттай хувьцаат компани нь хувьцаат компани биш юм. Энэ бол төрийн өмчит хувьцаат компани байгаа. Ингэж ард түмнийгээ бид ингэж төөрүүлж, түр зуур ингэж хуурч болохгүй.

Үүнийг цаашдаа харин хөрөнгийн бирж дээр гаргах, Баялгийн сан болгох асуудлыг цаашдаа тусгай нэг асуудал болгоод сайн ярих ёстой байх гэж бодож байгаа.

Уул уурхайн бирж байгуулагдсанаараа цаашдаа нөгөө нэг оффтэйк гэрээгээр хийгдсэн нүүрсний энэ олон жилийн тохироотой үнүүдээ яах гэж байгаа юм. Хэдэн төгрөг оффтэйк гэрээгээр зээл байгаа юм. Оффтэйк гэрээний үнэ байгаа юм. Хэдэн төгрөгийн зээл байгаа юм. Үүнийг тодруулмаар байна.

Цаашдаа оффтэйк гэрээ олон жил хийгдсэн нь нүүрсний менежментийг алдагдуулдаг юм. Үүнийг бид сайн бодох хэрэгтэй юм. Үүний менежмент алдагддаг шүү.

Бид цаашдаа дандаа л ингэж өнөөдөр бөгөөд урт цагаа яриад байгаа болохоос биш маргаашаа ярьж чадахгүй байгаа. Энэ мөнгөөрөө Улсын Их Хурлын бөгөөд Эдийн засгийн байнгын хороо бид бүхний алдаа.

Цаашдаа эдийн засгаа яаж тэлэх юм. Хоёр дахин тэлэхгүй бол энэ улс төрийн сонгуулиа хүлээсэн улс төрчдийн хүлээлт, попролт энэ ард түмэнд энэ халамжийн тогтолцоо хэзээ ч салахгүй.

Тийм учраас эдийн засгаа ядаж хоёр дахин тэлж байж өнөөдөр улс төрийн халалт багасдаг. Үүнийг бид анхаарах хэрэгтэй. Ханшаар тооцох юм бол энэ ерөөсөө бид нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн ерөөсөө өсөөгүй байгаа шүү дээ. Өнөөдөр экспортоо нэмж байж, нүүрсний экспортоо нэмж байж эдийн засгаа бага зэргийн тэлэх боломжтой.

Одоо хийгдчихээд байгаа, их мөнгө оруулчхаад байгаа тэр Гашуунсухайтын төмөр замаа Ганцмодтой холбох хэрэгтэй. Үүнийг хоёр жил, гурван жил хүлээх биш 6 сарын хугацаанд хувийн хэвшилтэйгээ түншлээд гаднын хөрөнгө оруулагчдыг дуудаад үүнийг яаралтай хийх хэрэгтэй. Энэ дээр шинэ боомтын сайд бас сайн ажиллана, сайн эдийн засагч хүн оччихсон гэж би үзэж байгаа.

Тэр Хангийн боомт хувийн хэвшлийнхэн очоод авааччихсан байгаа. Хангийнхаа Мандалтай холбох холболтоо сайн хий. Ингэснээр төмөр замаар тээх нүүрс маань нэгд холболт хийсэн тохиолдолд нэг боомт дээр 15-аас 20 сая тонн нэмэгдэнэ.

Тэгэхэд чинь 30 сая тонн орчим экспорт нэмэгдэх боломжтой. Нөгөө 10 мянган жолоочийн зөөж байгаа 20 сая тонн. AGV[automated guided vehicles] ГЭЭД НӨГӨӨ нэг жолоочгүй тээвэрлэлт 10 орчим нэмэгдэх юм бол нийт 50-иас 60 сая тонн нүүрсний экспорт яваад эхэлсэн тохиолдолд эдийн засаг маань гайгүй болно.

Энэ асуудлыг Эдийн засгийн байнгын хороо бид нар авч энэ тэлэлтийн асуудал, энэ хөгжлийн асуудлыг сайн ярилцах ёстой юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Нэмж минут авах уу? Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Д.Бат-Эрдэнэ гишүүний үгэнд орлоо шүү дээ. Энэ хөрөнгийн биржид бүртгэлтэй болох нь зүйтэй гэж. Тийм үү. Үнэхээр хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй болох нь зүйтэй.

Одоо өнөөдөр 1072 хувьцаа маань яг хэдэн төгрөг болчихоод байгаа юм. Бирж дээр ямар үнэлгээтэй байгаа юм. Цаашаа яаж эргэлтэд орох гэж байгаа юм. Жишээ нь, үе дамжаад өвлүүлэх асуудал нь хаана байгаа юм гэх мэтчилэн олон асуудал байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ л бид. Түрүүн би хэлсэн. Одоо эргэлтэд оруулах асуудлаа нэг мөр шийдээд. Хойш нь тавиад яах вэ. Шийдээд явчихъя гэж байгаа юм.

Тэгэхээр таныг би олон жил мэдэхийн хувьд энэ биржтэй холбоотой асуудал дээр ерөнхийдөө эдийн засгийн мэдлэг нэлээн гайгүй гэж ойлгодог.

Тэгэхээр биржид бүртгэлтэй компани болохын тулд үүний чинь үнэлгээ явагдана шүү дээ. Тийм үү. Үнэлгээ нь явагдана. Нэг бүрийн үнэлгээ, нэг хувьцааны үнэлгээ хэд гарах юм. Тэр үнэлгээг чинь гаргаж ирнэ. Тэгээд 1072 хувьцааны үнэ нь гарч ирнэ. Би одоо өнөөдөр үнэхээр үнэ хэлж чадахгүй.

Тэгэхээр энэ үнэлгээ чинь бүгдээрээ гарч ирнэ. Өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” компани ямар үнэлгээтэй, цаашдаа ямар ашиг гаргах компани юм гэдэг бүх зүйлүүд чинь түүгээр чинь тооцоолууд гаргаад, эдийн засгийн тооцоолууд гараад, тэгж байж биржээр

бүртгэлтэй болоод, тэгээд 1072 буюу нэг хувьцааны үнэ нь гараад, тодроод, тэгж байж биржид бүртгэлтэй компани болно шүү дээ. Энэ чинь. Процедураараа явчихна.

Тэгэхээр 5 дугаар зардлын хамгийн сүүлд 2023 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах гэж байгаа байхгүй юу. Нэгдүгээр улирал багтаамж танилцуулах.

Тэгэхээр энэ хооронд бүх бэлтгэл ажлууд чинь хийгдээд. Засгийн газар бид иймэрхүү үйл ажиллагаа явуулах гэж байна. Ингээд ингээд бүртгэлтэй болгох гэж байна. Тэгэхийн тулд энэ компани өөрөө төдий хэмжээний хөрөнгө оруулалттай юм байна. Ийм юм байна. Цаашдаа нэгж хувьцааны үнэ тэд болох юм байна. 1072 чинь өөрөө тэд юм байна гэсэн юмыг буцаад эргээд танилцуул гээд байгаа байхгүй юу.

Түүнээс биш Засгийн газрын өмнөөс би үүнийг бас тооцооллыг нь хийж ажлын хэсэг амжаагүй. Энэ дээр хариулж үнэхээр чадахгүй байгаа юм.

Хоёрдугаарт, боломжгүй байна.

Оффтэйк гэрээтэй холбоотой асуудлууд дахиад энэ орж ирэх байхгүй юу. Үүнтэй уялдаатай оффтэйк гэрээтэй холбоотой асуудал чинь Засгийн газрын л асуудал шүү дээ.

Түүнээс биш оффтэйк гэрээг цаашаа яах юм бэ гэдэг асуудлыг өнөөдөр ажлын хэсэг хариулж чадахгүй. Оффтэйк гэрээтэй холбоотой асуудлуудыг. Би түрүүн хэлээд байгаа байхгүй юу. Үр дүн хэрвээ үзье гэж байгаа бол энэ оффтэйк гэрээтэй холбоотой асуудлыг цаашаа яах ёстой юм. Засгийн газар танилцуулах л хэрэгтэй байхгүй юу даа. Магадгүй

зүгээр хэрвээ шаардлагатай гэвэл одоо энд зохих яамных нь сайдыг дуудаж байгаад хэдүүлээ хариу авъя л даа. Яг яах гээд байгаа юм. Оффтэйк гэрээгээ бид нөхөж хийх юм уу, яах юм. Тэр дээр ингээд тогтчихсон гэрээнийхээ үнийг өөрчлөх юм уу, өөрчлөхгүй юм уу.

Түрүүний таны хэлдэг тэр чинь зөв шүү дээ. Яагаад биржээр худалдаж байгаа юм. Хамгийн дээд үнийг бид тодорхойлохын тулд биржээр худалдаж байгаа шүү дээ.

Тэгвэл өнөөдөр оффтэйк гэрээгээрээ тэр хямдхан хийчихсэн гэрээгээ тэгвэл задлах юм уу, хүчингүй болгох юм уу. Тэгж байж биржээр өөрөөр хэлбэл 07 сарын 01-нд бирж маань үйл ажиллагаагаа эхлээд явах хүртэл бэлтгэл ажлаа хийгээд, тэндээсээ эхлээд дахиад шинээр хийгээд явах юм уу.

Бидний ойлгож байгаагаар шүү. Бидний ойлгож байгаа энэ хууль батлуулж байгаа, ойлгож байгаагаар 07 сарын 01-нээс биржийн үйл ажиллагаа шууд эхлээд явна.

Тэгэхээр ерөөсөө төрийн өмчтэй энэ компаниудын бүх бүтээгдэхүүн алт, зэс юу байдаг юм бүгдээрээ биржээр ингээд явчих юм шүү. Баярлалаа.

Эдийн засаг тэлэхтэй холбоотой дарга бас таван үг хэлчихнэ биз дээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Тодорхой нэг асуулт нь юу байсан гэхээр зэрэг энэ Тавантолгойн асуудлаар тэр мэдээллүүд тодорхой бус байна. Энэ дээр мэдээлэл сонсох хэрэгтэй байна. Одоо тэр оффтэйкийн талаар гээд Н.Ганибал гишүүн ч түрүүн яриад байсан.

Энэ чиглэлд Г.Ганболд гишүүний хилийн боомтын асуудлаар Төрийн хянан шалгах хороо байгуулагдсан. Бид энэ нийтийн хяналтын сонсгол явуулсантай холбоотойгоор тогтоолын төсөл явж байгаа. Тийм. Их Хурлын тогтоолын төсөл дээр яг энэ ажлаа эрчимжүүлэх ийм чиглэл үүрэг өгч байгаа. Г.Ганболд гишүүн.

Тэгэхээр Г.Ганболд гишүүний ахалж байгаа Түр хянан шалгах хороо нийтийн сонсголууд явуулах юм. Энэ сонсголууд дээр бид яг нэг сонсголыг нь яг Тавантолгойд зориулж явуулья гэж бодож байна. Байнгын хорооноосоо энэ дээр Г.Ганболд гишүүнтэй цөмөөрөө дараагийн Байнгын хороон дээрээ уулзаад хэзээ сонсгол явах гэж байгаа юм. Хуваарийг нь сонсоод тэгээд яг нэг асуудлыг нь Тавантолгой дээр ерөөсөө сэдэв болгоё. Тэгэх үү. Гишүүд та бүхэн бас энэ дээр санал бодлоо хэлбэл зүгээр байх. Тавантолгой компани дээр. Тийм.

Одоо энэ чинь хэд хэдэн нийтийн сонсгол явуулах байхгүй юу. Нээлттэй сонсголууд. Тэгэхээр тэр дунд нь боомтын асуудал гээд боомтоор нь салгачихаж байгаа юм. Асуудлууд дундаа Тавантолгойгоо. Асуудал байгаа учраас Тавантолгойгоо ойрын хугацаанд. Бидэнд ямар боломж байна. Болохгүй бол хаврын чуулганы хамгийн эхэнд хуваарийг нь тавиулдаг ч юм уу. Ингээд дараагийн Байнгын хороон дээр ер нь Г.Ганболд гишүүнийг мэдээлэл өгөөч ээ гээд, сонсьё гээд. Тэгэх үү. Та бүхэн дэмжиж байвал дараагийн Байнгын хорооныхоо хуралдаан дээр хуваарьт би оруулчихъя. Тийм.

Тэгээд Д.Бат-Эрдэнэ гишүүний санаа зовж байгааг ойлгож байгаа. Эдийн засгийн байнгын хороо энэ Их Хурал

эхэлснээс хойш Д.Бат-Эрдэнэ гишүүн байнга энэ асуудлыг ярьж байгаа.

Эдийн засгийн байнгын хороо, Их Хурлын эдийн засгийн бодлого энэ Байнгын хороон дээр зангидагдаж явах ёстой. Эдийн засгийн байнгын хорооны маань гол ярьж байх ёстой зүйл яаж бид эдийн засгаа тэлэх юм, яаж энэ өсөлтийг авчрах юм. Ялангуяа нэг хүнд ногдох. Тийм ээ. Энэ эдийн засгийн өсөлт алга.

Энэ асуудлыг их ярьдаг манай Б.Баттөмөр гишүүн байна.

Тэгэхээр бүгдээрээ Байнгын хороон дээрээ санаачилга гаргая л даа. Бид нарт бүрэн эрх байна. Тийм үү. Та бүгд саналаа нэгтгээд Байнгын хороон дээрээ дахиад энэ асуудлаар нь нарийсгаж яриад. Ингээд бүгдээрээ тал талаасаа яриад энэ асуудал дээр бид одоо яах юм. Төрийн өмчтэй компаниуд бөөгнөрчхөөд ингээд яваад байх юм уу. Эсвэл хувийнхандаа хувийн хөрөнгө оруулагчдыг нээлттэй болгоод. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлээр ямар юм хийх юм. Энэ чиглэлүүдээр ямар ажлууд хиймээр байна. Бүгдээрээ саналаа нэгтгээд энэ дээр бас ийм бодлого гаргая. Тодорхой ярьдаг асуудлуудаа эрэмбэлж зөв цэгцлээд Байнгын хороон дээрээ.

Эдийн засгийн зөвхөн өсөлтийг авчрах талаар бид Байнгын хорооноосоо тогтоол гаргаж болно. Тийм үү. Үүнийгээ цааш нь санаачлаад Их Хурлын тогтоол хүртэл гаргаад. Бүр шаардлагатай бол бусад яадаг юм, ямар арга хэмжээ, шийдвэрүүд гаргах боломжтой байдаг юм. Энэ хүрээнд нь хуулийн хүрээнд нь бид ажиллах боломжтой.

Ингээд Ж.Бат-Эрдэнэ гишүүн та нэмэлт нэг асуултаа асууя. 1 минут.

**Д.Бат-Эрдэнэ:** Манай ажлын хэсгийн ахлагч Ж.Бат Эрдэнийн хэлж байгаа үнэн. Тийм ээ.

1995 оны 8 сарын 28-нд Хөрөнгийн биржээр хоёр дахь зах зээл нээгдсэн. 2004 оны сүүлээр Монголын нүүрсний экспорт анх удаа эхэлсэн. Энэ бүхэнд би бас анхдагч. Би энэ бүхнийг бас зовлон жаргалыг нь мэднэ.

2005 онд нүүрс зарагдахгүй 10-аас 15 доллар хүртэл байдаг. Зарагдахгүй үеүд байдаг.

2010 оноос л нүүрсний зах зээл гайгүй болж эхэлсэн байдаг юм. Тэгээд энэ үеийнх нь бүх асуудлуудыг, бүх хүндрэлийг нь би мэднэ.

2007 оны Ашигт малтмалын хууль дээр стратегийн ордуудын 10 хүртэлх хувийг нь хувьчилна гэсэн байдаг. Энэ нь одоо хүртэл хэрэгжихгүй байгаа. Үндэсний компаниудыгаа өөрийнх нь хөрөнгийг оруулж байж хяналт тогтоодог болохоос биш халамжийн маягтай шууд тараасан юм хяналтыг тогтоодоггүй юм.

Тийм учраас 10 хүртэлх хувиудыг нь “Эрдэнэт”, “Оюу Толгой”, “Эрдэнэс Тавантолгой” дээр хувьцааг нь гаргах ёстой. Хөрөнгийн биржээр.../минут дууса/

**Ц.Цэрэнпунцаг:** Ж.Бат-Эрдэнэ гишүүн нэмж хариулья.

**Ж.Бат-Эрдэнэ:** Д.Бат-Эрдэнэ гишүүн маш зүйтэй санал гаргаж ирж байгаа юм.

Ашигт малтмалын тухай хуульд төрийн өмчит уул уурхайн компаниудын гэж байгаа байх аа. Бид үг, үсгийг нь сайн

мэдэхгүй байна. 10 хүртэл хувийг байгаа байх. Тийм ээ. 10-аас доошгүй ч байдаг билүү. Тийм. Хөрөнгийн биржээр хувьчлах гэсэн одоо энэ заалт ерөөсөө хэрэгжихгүй байгаад байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр үүнийг магадгүй зүгээр ёстой энэ дотор оруулах ёстой байдаг юм уу, яадаг юм. Эсвэл дараагийн тогтоолд орох ёстой байдаг юм уу. Байгаа юу. Тэгж оруулахгүй бол болохгүй шүү. Яг үнэн. Тийм. Энэ үнэхээр хэрэгжих ёстой. Хууль хэрэгжихгүй байгаад байгаа шүү. Тийм. Энэ дээр санал нэг байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Ундрам гишүүн асуултаа асууя.

**Ч.Ундрам:** Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн тогтоолын төслийг дэмжиж байгаа юм.

Гэхдээ “Эрдэнэс Тавантолгой”-н асуудлыг бид нэлээн нухацтай тусдаа тогтоолоор зохицуулах ёстой юм шиг надад санагдаад байгаа юм.

Тэгээд сая Ж.Бат-Эрдэнэ гишүүн ярьж байна л даа. “Эрдэнэс Тавантолгой” компанийг анх байгуулах 2010 оны тогтоол дээр 10 хувийг ард иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэх, 10 хувийг үндэсний аж ахуйн нэгжүүдэд нэрлэсэн үнээр худалдаалах, 30 хувийг гадаад, дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалах гэж бүр яг ингэж зааж өгч 2010 онд энэ тогтоолыг Улсын Их Хурлаар баталсан байдаг.

Гэтэл ард иргэдэд өнөөдөр бид 20 хувь болох 3 тэрбум ширхэг хувьцааг олгочихсон байгаа. Үндэсний аж ахуйн нэгжүүдэд худалдаалсан юм байхгүй. Гадаад дотоодын бирж нь байхгүй. Энэ хоёр нь хэрэгжээгүй.



Тэгэхээр ийм тогтоолын төсөл Улсын Их Хурлаас гараад гараад Засгийн газар нь хэрэгждэггүй ийм нөхцөл байдал ч гэсэн эндээс харагдаж байгаа юм. Тэгээд Ж.Бат-Эрдэнэ гишүүний хэлсэнтэй би бүр 100 хувь санал нэг байна. Үндэсний аж ахуйн нэгжүүдэд нэрлэсэн үнээр энэ 10 хувийг нь худалдаалж байж бид хяналтаа тавина. Бодит болно. Яг энэ компанийн засаглал чинь эрүүл болно. Ингээд зөвөөр ажиллаж эхэлнэ.

Тэгэхээр энэ тогтоолын төсөлдөө биш тусдаа “Эрдэнэс Тавантолгой”-той холбоотой тогтоолын төсөл боловсруулаад үүнийг оруулж ирж болдоггүй юм уу гэдэг санааг түрүүнээс хойш хэлэх гээд л ингээд хүлээгээд байлаа л даа.

Тэгээд түрүүн бас 1072 хувьцааг тухайн үедээ 1072 нийлээд нэг сая төгрөгийн үнэлгээтэйгээр өгч байсан буюу нэгж хувьцаа нь 933 төгрөг гээд 2012 онд өгч байсан.

Тэгэхээр өнөөдөр энэ үнэлгээ мэдээж нэлээн өссөн байх ёстой. Тэгээд энэ хувьцааны ногдол ашиг гээд миний санаж байгаагаар хоёр удаа. Нэг удаа 300 мянган төгрөг хүн болгонд өгч байсан санаж байна. Нөгөөдөх нь оюутнуудад сургалтын төлбөр ч билүү бас нэг тийм боломж олгоод. Тийм. Нэг тийм зүйл болж байсан байхгүй юу.

Тэгээд түүнээс хойш ерөөсөө ард иргэд энэ 1072 хувьцаатайгаа холбоотой ямар нэгэн эдийн засгийн эргэлтэд оруулсан ч юм байхгүй, ногдол ашиг хүртсэн ч юм байхгүй байгаад байгаа юм.

Тэгээд өнөөдөр энэ яригдаж байгаа нүүрсний хулгай гэдэг чинь тэр

хүмүүст очих ёстой байсан ногдол ашгийн чинь бас тодорхой хувийг хулгайлчихсан л гэсэн үг шүү дээ. Одоо 20 хувь нь ядаж л тэр хүмүүсийн.

Тэгэхээр бид энэ хулгайтай тэмцээд тодорхой хэмжээний хулгай илрүүлээд улсад хурааж авах юм бол энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн өмч байхгүй юу. Тэгээд тэндээсээ энэ компанийн өр зээлэнд явах ёстой, ард иргэдийн 1072 хувьцааны ногдол ашигт очих ёстой гэж би үзээд байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбоотой зүйл тогтоолын төсөлд орох л ёстой юм шиг болоод байгаа юм.

Бас нэг зүйл нь ард иргэд 1072 хувьцаагаа уг нь тодорхой хугацаанд арилжихгүйгээр яг өөрсдөд нь байж байдаг байхгүй бол нөгөө цэнхэр, ягаан тасалбар шиг нэг жоохон мөнгө хүмүүст өгөөд зарим хүмүүс нь хураагаад цуглуулаад ингээд тэрнийхээ ашгийг хүртчих ийм боломж байгаад байгаа юм. Одоо энэ ардчилал бий болоод л өмч хувьчлал яваад юу боллоо. Цэнхэр, ягаан тасалбар гээд л хамаг мэдээлэлд ойрхон хүмүүс нь хувьцаануудыг нь хураагаад авчихсан шүү дээ.

Тэгэхээр яг ийм зүйл дахиад гарах боломжтой. Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой”-той холбоотой нэлээн нухацтай хэдүүлээ судалж үзэж байгаад тусдаа тогтоолын төсөл бүр ингээд нарийн гаргаж Засгийн газарт үүрэг даалгавар болгохгүй бол энэ дээр нэлээн ийм бөөрөнхий маягтай тусчихаар үүнийг нь яаж ч хэрэгжүүлэх юм билээ. Юуг нь ч дутуу орхичих юм билээ. Би маш их санаа зовж байна. Энэ өнгөрсөн хугацаанд 2010 оны тогтоол одоо хүртэл хэрэгжээгүй явж байна шүү дээ. 12 жилийн дараа.



**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Ундрам гишүүн ерөнхийдөө санал хэлж байна.

Таны ярьж байгаа саналуудыг миний хувьд дэмжиж байна. Наадхыг чинь дэмжээд ганц нэгийг нь бас энэ рүү нэлээн шаргуу ярихаар зэрэг цаашаа мушгигдаад явчхаад улс төрийн хувьд жоохон хэцүү юм шиг байна лээ.

Энэ чинь тэгээд бас бид нарын ярих ёстой асуудал л даа. Тэгэхдээ энэ юу байгаа шүү дээ. Хоёр тогтоолын төсөл явж байгаа. Хоёр тогтоолын төслийг нэгтгээд төрийн өмчтэй компаниудын талаар Д.Цогтбаатар гишүүн өргөн барьсан. О.Цогтгэрэл гишүүн өргөн барьсан хоёрыг нэгтгээд Д.Батлут гишүүн ажлын хэсгийг нь ахалж байгаа.

Яг энэ ажлын хэсэг дээр орж ажиллаад, та энэ дээр саналуудаа оруулаад. Эндээ оруулж ирэхдээ эд нарыг сайн ярьж оруулж ирмээр байна. Нэгтгээд. Тэгвэл тусдаа нэг ийм тогтоолын төсөл биш. Энэ төрийн өмчтэй компаниудтай л холбоотой бид энэ асуудлуудыг энэ дээр оруулж болох учраас энэ дээр оруулья.

Ажлын хэсгээ ингэвэл өргөтгөж болно. Д.Батлут гишүүнтэй та уулзаадах. Тэр нь 4 гишүүнийг түрүүн уг нь яачихсан байгаа. Сольчихож болно шүү дээ. Бид нэмж оруулж болно.

Тэгээд энэ дээр Та бүхэн хоорондоо ярилчихаарай. Ж.Бат-Эрдэнэ гишүүн нэмж хариулья.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ч.Ундрам гишүүний хэлсэн саналуудаас нэг зүйлийг протоколд тэмдэглээд үлдээчихвэл зүйтэй байх гэж бодож байгаа юм.

Үнэхээр нөгөө цэнхэр, ягаан тасалбартай адилхан. Өөрөөр хэлбэл нөгөө 1072 хувьцаа чинь 18 хувь байгаа. 18 хувь чинь яах вэ, дээр нь иргэд, хүүхдүүд дахиж нэмэгдээд тэр одоо хэд болохыг нь би хэлж мэдэхгүй байна. 20 гаран болох байлгүй. Бодвол. Тийм ээ. 30 хавьцаа ч юм уу.

Тэгэхээр энэ хувьцааг нөгөө цэнхэр ягаан тасалбартай адилхан зараад үрчих вий дээ. Нөгөө талхны мөнгөөр өгчих вий дээ. Өнөөдрийн хүнд байгаа нөхцөл байдалд.

Тэгэхээр энэ дээр яг Уул уурхайн сайдын өөрийнх нь хэлсэнчлэн магадгүй үе шаттайгаар үүнийг өгье. Эхлээд нийт иргэдийн эзэмшиж байгаа 30 хувь, 20 хувь дотроос тийм үү, одоо өнөөдрийн 18 чинь нэмэгдэнэ гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр чинь 20 гаруй энэ хувь дотроос эхний 5 хувийг нь эргэлтэд оруулна ч гэдэг юм уу. Ингээд нэг жоохон үе шаттайгаар гэсэн ийм зүйл яригдаж байгаа шүү.

Тэгэхээр бид зайлшгүй тэр болгоныг гэрээн дотор ингээд л Засгийн газар хийх зүйлийг бичээд байх гэхээсээ илүү протоколд хэдүүлээ хөтлөөд одоо энэ нь зүйтэй шүү. Засгийн газар хэрэгжүүлэхдээ яг ийм байдлаар одоо жишээ нь Ч.Ундрам гишүүний хэлсэнчлэн энэ хувийг тийм үү, Засгийн газар хэрэгжүүлэхдээ тодорхой үе шаттайгаар хийх нь зүйтэй гэсэн нэг ийм үг, үсэг ядаж протоколдоод энэ Засгийн газар зохих сайд нь сонсож байгаа байлгүй. Сонсох ёстой байлгүй. Тийм. Ингээд явчихвал зүйтэй байх л гэж бодож байгаа юм.

Үүнийг тэмдэглээд үлдээе гэж байгаа шүү. Тийм. Эхлээд 5 хувь ч байдаг юм уу. Тийм. Тэгэхгүй бол энэ бас их санаа зовсон асуудал байж байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн энэ дээр тодорхой санал хэллээ. Ингээд ажлын хэсгээс Д.Бат-Эрдэнэ гишүүн нэмээд хариулчихъя. Саналаа хэлчихье.

**Д.Бат-Эрдэнэ:** Тэгээд Ж.Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа их зөв. Одоо Ч.Ундрам гишүүний хэлж хэлж байгаа.

Тэгэхээр тэр иргэдийнхээ хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч маягтайгаар түгжих хэрэгтэй. Тодорхой хугацаанд. Тийм ээ. Хэдэн жил. Хоёр, гурван жил. Ногдол ашиг нь үнэ тогтчихсон. Ногдол ашиг нь доод тал нь 15 хувиас доошгүй. Одоо банкны хүү, хадгаламжаас дутуугүйгээр өгдөг энэ үүргийг л өгөгдөөд үнэ тогтоод явах ёстой.

Тийм учраас стратегийн хөрөнгө оруулагчаар түгжээд. 10 хүртэлх хувийг нь ч юм уу үндэсний компаниуддаа Монголын хөрөнгийн бирж дээр тэр 2007 оныхоо хуулийн дагуу борлуулж байж. Яг бодит мөнгөө хийсэн хүмүүс бодит хяналтыг тавьдаг. Зүгээр авсан хүмүүс бол зүгээр л тэр бол бас тийм бодитой явдаггүй. Тийм учраас энэ тал дээр цаашдаа бид дараа дараагийнхаа тогтоолууд дээр нь нэлээн анхаараад ажиллах ёстой юм байна. Тийм ээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Б.Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

**Б.Баттөмөр:** Энэ Тавантолгой дээр маш сайн тооцоо хийж, маш сайн бодож ингэж ажиллах ёстой гэдгийг би хэлэх гээд байгаа юм.

2010 оны тогтоол гэж байгаа. Тийм ээ. 12 жилийн өмнө гарсан байна л даа. 2010 онд нүүрс үнэгүй шахуу байсан. 2010 оноос хойш өнөөдөр 12 жил өнгөрчихөж. Дэлхий ертөнцийн байдал, дэлхий ертөнц шал өөр болчихсон байгаа. Тэр үед ийм хулгай байгаагүй. Ард түмэн 42.5 хувь болтлоо ядуураагүй байсан шүү.

Тийм учраас 2010 онд нэг ийм тогтоол гарчихсан юм. Үүнийгээ хэрэгжүүлнэ гэж дайраад байх нь хэр зэрэг оновчтой юм бол. Үзэх шаардлагатай.

Гадаад, дотоодын хөрөнгийн зах дээр 30 хувийг нь зарна л гэж байгаа юм. Яах вэ ингээд хэлчихэд амархан л даа.

Монголын ард түмэнд чинь мөнгө байна уу, үгүй юу. Нөгөө нүүрсний хулгай. Энэ нэг далд эдийн засгаас олсон мөнгөтэй хэдэн улсууд нь авдаг. Нөгөө ард түмэн нь байдаггүй. Нөгөө ядуурал гэдэг юм чинь, баян хоосны ялгаа гэдэг юм чинь ингээд л цаашаа гаараад байгаа юм.

Дэлхийн нэг ухаантай хүний хэлсэн үг байгаа шүү дээ. Энэ дэлхий ертөнцийг энэ баян хоосны ялгаа чинь дэлхийг сүйрүүлнэ шүү гэж.

Ийм учраас Тавантолгой дээр их олон талаас нь сайн бодож, ултай үндэстэй шийдвэр гарах ёстой шүү гэдэг санааг би хэлэх гэж байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Б.Баттөмөр гишүүн санал хэллээ. Тийм ээ.

Тэгээд ер нь Их Хурлаас хууль, тогтоол, шийдвэр гараад байдаг. Ингээд хэрэгждэггүй асуудал бол байгаад байгаа

юм. Ингэхээр бид ерөнхийдөө Байнгын хороон дээрээ нэг ажил уламжлал болгоод явуулж байвал зүгээр юм уу гээд л яах вэ бодогдож байна л даа. Та бүхэн юу гэж бодож байгаа юм.

Ер нь манай Эдийн засгийн байнгын хороогоор дамжаад гарсан хууль. Ялангуяа Их Хурлын тогтоолуудыг бид жилдээ нэг удаа дүгнээд, Засгийн газраас мэдээллээ аваад энэ дээрээ нэг тайланг нь сайхан сонсчихож байя. Дүгнэчихье гэж бодож байна.

Ер нь энэ дээр бас жилийнхээ ажлын хуваарьт оруулж ерөнхийдөө үүнийг бас нэг Байнгын хорооны хийдэг нэг ийм ажил болгох ёстой гэж бодож байгаа.

Гишүүд хэлэлцэх асуудалтай холбоотойгоор асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Ажлын хэсгийн боловсруулсан саналыг уншъя. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч

хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэд даалгасугай:

1/Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд экспортод гаргах нөөцийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим системээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх, экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаатай холбогдох харилцааг зохицуулсан журмыг баталж, мөрдүүлэх;

2/биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг баталж, шаардлагатай дэд бүтэц /итгэмжлэгдсэн лаборатори, агуулах, терминал, тээвэр логистикийн төв/-ийг бий болгох;

3/уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн систем, программ хангамжийг биржийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой эсэхийг судалж, холбогдох арга хэмжээ авах;

4/Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэх;

5/газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга бүтээмжтэй болгох, компанийн сайн засаглал, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болгох, иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийт гаргасан хувьцааны

төрийн эзэмшлийн хувьцаанаас 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд төрсөн иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрд эзэмшүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд 2023 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан экспорт гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаанд хяналт тавихтай холбогдох журмыг баталж, хэрэгжүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо Д.Баярсайханд даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо Ц.Цэрэнпунцагт даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн төсөл байна.

Тэгээд эндээс Нийтийн хяналтын сонсголтой холбогдуулаад Их Хурлын тогтоолын төсөл гарах гэж байгаа шүү дээ. Түүн дээр давхцаж байгаа хэсгүүдээ эндээс хасаад, яг Биржийн хуультайгаа холбоотой хэсгээ үлдээгээд ингээд баталчихъя гэсэн шүү.

Тэгээд би хасах зүйлүүдээ уншаад та бүхэнд сонсгочихье.

/Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэх;

5/газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга бүтээмжтэй болгох, компанийн сайн засаглал, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх

зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болгох, иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийт гаргасан хувьцааны төрийн эзэмшлийн хувьцаанаас 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд төрсөн иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрд эзэмшүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд 2023 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах.

Үүнийг хасаад. Тэгээд түрүүний уншсанаар энэ хоёрыг хасаад ингээд тогтоолын төсийг дэмжье гэдэг энэ томьёоллоор санал хураалт явуулья. 4, 5 хоёрыг. Миний сая уншсан.

Тэр Нийтийн хяналтын сонсголтой холбоотой Улсын Их Хурлын тогтоол дээр яг давхцаад орчихсон байгаа.

Ингээд санал хураалт явуулья. Гишүүдээ санал хураалт. Анхааралтай байгаарай.

Гишүүдийн 83.3 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ дээр нэг ийм асуудал байгаа юм. Бид түрүүчийн Байнгын хороон дээр 4 гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаад санал хураалт явуулсан юм. Тэгээд Байнгын хороон дээр дэмжигдээд гарсан. Тэгэхдээ чуулган дээр үүнийг бид санал хураалт явуулалгүй нээлттэй орхисон. Гүйцээн боловсруулах чиглэлүүд өгсөн.

Ингээд буцаад бид өнөөдөр Нийтийн хяналтын сонсголтой холбоотой тогтоол гаргаж байгаатай холбоотой энэ давхцаж байгаа хэсгүүдээ ийш нь оруулахаар зэрэг манай энэ 4 гишүүний

гаргасан саналууд уг нь үндсэндээ үүнтэй давхацаж байгаа юм.

Тэгээд одоо жишээлбэл сая Засгийн газар дээр дуудагдаад явчихлаа. С.Чинзориг гишүүн бол өөрийнхөө саналыг татаж байгаа. Д.Батлут гишүүн та бас саналаа. Яах вэ, оруулаад хураалгаж болно. Бусад саналуудыг би ингээд уншаад явчихна.

С.Чинзориг гишүүн татсан учраас С.Чинзориг гишүүнээс бусад гурав дээр нь хураалгачихъя.

Ерөнхийдөө гишүүдээ хэлэхэд түүн дээр бүх юм давхцаад орчихсон учраас ер нь зүгээр ингээд Байнгын хороон дээр дэмжихгүй явчихъя л гэсэн ийм бодолтой байгаа юм шүү.

М.Оюунчимэг асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Ямар ч байсан Эдийн засгийн байнгын хорооны даргатай санал нэг байна. Саяын хэлсэн дээр.

Зүгээр энэ дээр дарга аа, юу байхгүй байх юм. Одоо давхацсан гэж хэлээд байгаа хэрнээ нь сая зарим гишүүдийн, бид нарын гаргаад байгаа нөгөө сүүлийн хоёр жилийн 1072 ширхэг хувьцааны олгогдоогүй ногдол ашгийг нөхөж олгох гэдэг үг, яг тэр өгүүлбэр нь байхгүй байгаа юм.

Энэ дээр одоо байхгүй байна шүү дээ.

Тэгэхээр орно гэсэн үг үү? Яг тэгж. Ойлголоо.

**Ц.Цэрэнпунцаг:** М.Оюунчимэг гишүүн саяын та гаргасан саналаа энэ Нийтийн хяналтын сонсголтой холбоотой

авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай гэсэн ийм тогтоол байгаа шүү дээ. Тэр тогтоолын төслийг хэлэлцэх дээр үүнийгээ та зарчмын зөрүүтэй саналаар оруулж ирээд санал хураалгаад эндээ оруулж болно.

Ингээд би 4 гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулъя.

Нэгд, С.Чинзориг гишүүний гаргасан санал байгаа юм. Үүнийг өөрөө татаж авсан.

Тийм учраас шууд 2-ыг уншъя.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7.“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан хөрөнгийн бирж бүртгэлтэй компани болгох асуудлыг судалж танилцуулах.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням. Санал хураалт. /алх цохив/

Дэмжсэн гишүүн алга байна. Ингээд санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмэх:

“8.2023 онд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нийтийн сонсгол явуулж, нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох, жилийн эцсийн цэвэр ашгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний ногдол ашгийг жил бүр хувьцаа эзэмшигчдэд хуваарилах асуудлыг судалж, танилцуулах.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг. Санал хураалт. /алх цохив/

Нэг ч гишүүн дэмжсэнгүй. Ингээд санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх дэд заалт нэмэх:

“9.“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт гарсан энгийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг иргэдэд эзэмшүүлэх асуудлыг судалж, танилцуулах.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут.

Д.Батлут гишүүн санал дээр та санал хэлэх үү? Гаргасан санал дээрээ. Д.Батлут гишүүний микрофоныг нээе.

**Д.Батлут:** Энэ дээр зүгээр найруулгын чанартай жижигхэн засвар хийж болох уу? Дарга аа. Тэгээд санал хураалтад оруулах гэж байгаа юм л даа. Жишээлбэл, Улсын Их Хурлын 4 гишүүн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 40 хувийг иргэдэд олгох гээд ингээд саналууд оруулж ирээд. Нэлээн олон гишүүд тийм санал гаргаад байгаа.

Тэгэхдээ зүгээр яах вэ, шууд ингээд нэг хувь заах нь өөрөө хэр зохилтой юм бэ.

Тийм учраас жижигхэн найруулгын шинж чанартай өөрчлөлт оруулаад явчихъя гэдэг санал байгаа юм. Тухайлах юм бол энэ дээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс 49 хүртэлх хувийг иргэдэд эзэмшүүлэх асуудлыг судалж танилцуулах гээд өөрчилчихье гэдэг санал байна. Дарга аа.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс 49 хүртэлх хувийг иргэдэд эзэмшүүлэх асуудлыг судалж танилцуулах гээд.

Тэгэхээр энэ 49-өөс цаашаа яг ингэж зааж өгөхгүй болохоор, тодорхой хувийг зааж өгөхгүй болохоор ингээд янз бүрийн эрсдэл рүү орчих нөхцөл байдал бий болгочих вий гэсэн болгоомжлууд Их Хурлын гишүүд маань ярьж байгаа.

Тийм учраас иймэрхүү найруулга оруулаад явчихъя гэж. 34-өөс 49 хүртэл хувь.

**Ц.Цэрэнпунцаг:** Д.Батлут гишүүн ээ, та Нийтийн хяналтын сонсголттой холбоотой тогтоолын төслийн ажлын хэсэг ахалж байгаа.

Тэгэхээр таны энэ саналуудаа тэнд оруулаад явчихвал яг өнөө зарчимтай нийцэхээр байна. Тэгэхээр та ямар саналтай байна. Энэ дээр уг нь та энэ дээр саналаа татаж аваад. Эсвэл одоо гишүүд. Тэнд та бүрэн ажлын хэсгээ ахалж байгаа учраас. Одоо жишээлбэл Ч.Ундрам гишүүн ажлын хэсэгт орвол тодорхой саналууд байгаа. Энэ ажлыг хэсэг дээр их сайхан нягт нямбай ажиллаад, үүнийгээ ажлын хэсэг дээрээ сайн ярилцаад явчихвал зүгээр байгаа юм.

Тэгэхээр та саналаа татаад авчихвал зүгээр байгаа юм. Тэгье. Д.Батлут гишүүнд микрофон өгье.

**Д.Батлут:** Энэ угаасаа ажлын хэсэг дээр эргэж яриад энэ асуудал дээр нь нэлээн тодорхой байр суурь илэрхийлж гаргаж ирэх нь зүйтэй гэж үзэж байна.



Тэгэхээр энэ тогтоолыг “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээрээс энэ саналыг татаж авъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ингээд Д.Батлут гишүүн саналаа татаж авлаа.

Ингээд зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдааны ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ уншиж танилцуулна.

Ингээд дараагийнхаа асуудалд орёе. Хэлэлцэх сүүлийн асуудал.

***Тав. “Ерөнхий хяналтын сонголын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

“Ерөнхий хяналтын сонголын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Нүүрсний олборлолт, тээвэрлэлт, экспортын асуудлаарх Ерөнхий хяналтын сонголын тайланг хэлэлцэх үеэр хуралдаан даргалагчаас тайлангийн үр дүн болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх чиглэлийг Эдийн засгийн байнгын хороонд өгсөн.

Энэ дагуу Тамгын газрын холбогдох нэгж Ерөнхий хяналтын сонголын тайлангийн агуулгын дагуу тогтоолын төслийг бэлтгэн тус Байнгын хороонд ирүүлсэн байна.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Ингээд тогтоолын төслийн талаар санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Ингээд Ш.Адъяаа гишүүний микрофоныг нээе. Асуултаа асууя.

**Ш.Адъяаа:** Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Энэ нүүрсний экспорт, тээвэрлэлтэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагуудын тайланг сонсоод Улсын Их Хурлаас тогтоолын төсөл гаргах гэж байгаа юм байна л даа.

Энэ дээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хил боомтуудын асуудлаар Түр хороо байгуулагдсан байгаа. Түр хорооноос шийдвэр гарч таарах байх л даа. Энэ чинь өчнөөн шалгалт, шүүлэг болоод л зөндөө л асуудал яригдаж байгаа юм чинь.



Үүнтэйгээ холбогдуулаад тогтоолоо гаргахгүй юм уу. Урьдчилаад үүнийг гаргаж байх юм уу. Энэ талаар Байнгын хорооны даргаас асуулт асууя.

Хоёрдугаарт нь, тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй санал байна. Энэ саналаараа санал хураалгая гэсэн ийм хоёр л асуудал байна даа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ш.Адьяшаа гишүүн одоо энэ тогтоолын төслийг хэлэлцэнэ. Та ингээд энэ дээр тодорхой саналуудаа оруулаад ингээд хураалгаад явж болно. Ш.Адьяшаа гишүүнд нэмэлт 1 минут өгье.

**Ш.Адьяшаа:** Ерөнхий сонсголын тайлан хэлэлцээд тогтоол гаргах гэж байгаа юм байна л даа.

Тэгэхээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Түр хороо байгуулагдаад нүүрсний тээвэрлэлт, ложистик бүх асуудлыг чинь шалгаад явж байгаа шүү дээ. Дахиад нэг тогтоол гарах юм уу?

Одоо ингээд тайлан хэлэлцээд нэг гараад, дараа нь Түр хороо шалгалт хийгээд. Тэгээд тэрний үр дүнгийн талаар дахиад тогтоол гаргахаар хоёр тогтоол. Нэг нь Эдийн засгийн байнгын хороо гаргах. Нөгөөдөх нь Түр хороо гаргах ийм асуудал болчихоод байна шүү дээ. Энэ нь ямар учиртай юм? Үүнийг тайлбар авъя.

Дээр нь тогтоолтой холбогдуулаад үнэхээр хэлэлцэхээр бол нэг зарчмын зөрүүтэй санал байна. Эхлээд хариултаа авчихъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ш.Адьяшаа гишүүний асуултад хариулья.

Ш.Адьяшаа гишүүн ээ, Г.Ганболд гишүүний ахалж байгаа Хяналт шалгалтын түр хороо чинь бол аль 6 сар, 7 сарын өмнө байгуулагдаад сунгаад явж байгаа шүү дээ. 6 сараар сунгасан.

Хяналт шалгалтын түр хорооны гол хамарч байгаа тэр асуудлууд их өргөн хүрээтэй. Боомт ингээд ороод явчихсан. Саяын Нийтийн хяналтын сонсгол нүүрсний хулгайтай холбоотой явсан.

Тийм учраас онцгойлон энэ дээр яг нүүрсний холбоотой асуудлууд дээрээ бид дагуулж Их Хурлын тогтоолын төслийн дүгнэлт тайлантай холбогдуулан Их Хурлын тогтоол гаргая гэж байгаа юм.

Т.Доржханд гишүүн асуултаа асууя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Надад санал байгаа юм.

Тэгээд ямар асуудалтай холбоотой юм бэ гэхээр оффтэйк гэрээтэй холбоотой. Оффтэйк гэрээг өнөөдөр бүгдээрээ мэдлээ. Ил болсон. Зарим нь бас ил болоогүй гэрээ байна гэж яриад байна. Ил болсны хүрээнд 18-аас 19 их наяд төгрөгийн ийм гэрээ ил болсон байна гээд.

Тэгээд энэ гэрээнүүд ил болсноороо ямар үр дүн гарсан бэ гэхээр тухайлбал төсвийн хөрөнгөөр хийгдэх ёстой тэр бүтээн байгуулалтуудыг нэг компани нээсэн байна. Тэр компани хийхдээ улсын нууцад оруулж хийсэн байна. Тэгээд үр дүнд нь тухайлбал нэг төмөр замыг хийхдээ олон улсын тэр өртгөөс хоёроос гурав дахин үнэтэй хийсэн байна. Тэгээд мөнгөө авахдаа нүүрсээр авсан байна. Тэгээд нүүрсээ мөн тухайн үеийн зах зээлийн үнээс гурваас

дөрөв дахин бага үнээр авсан байна. Хөнгөлөлттэй авсан байна гэдэг энэ мэдээлэл ил болсон. Иргэд маш их дургүйцсэн. Иргэд талбайд дүүргэсэн шүү дээ. Тийм биз.

Тэгэхээр нүүрсний хулгайн хамгийн том хэсэг бол энэ оффтэйк гэрээн дээр байгаа юм. Ийм болохоор цаашид оффтэйк гэрээг хийх юм уу. Цаашид ингэж хулгайгаа нууцлах юм уу. Цаашид Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэдэг энэ байгууллага нь зөвлөмж дээрээ үүнийгээ тусгаад явдаг байх юм уу. Ийм болохоор энэ асуудлуудыг хориглох хэрэгтэй. Цаашид.

Хориглохын тулд энэ хориглосон заалтаа оруулах нь зүйтэй юм. Ийм болохоороо энэ 3 дугаар заалтын “а”, “б” гэж хэсэг байна. Тэгээд “си”, “ви” гэдэг хэсэг оруулмаар байна. Үүнд оффтэйк гэрээний хүрээнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хөндлөнгийн аудит оруулах, аудитын дүгнэлтээр үндэслэн санхүүжилтийг гүйцэтгэх эсэхийг шийдвэрлэх гэдэг заалт оруулмаар байна.

Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр тэртээ тэргүй хулгай гэдэг нь, бүр дээрэм гэдэг нь тодорхой ийм кэйс гарч ирчхээд байхад “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компанийн бүрэн эрхт төлөөлөгч нь яриа өгч байна. “Бодь интернэйшнл” гэдэг компанид энэ гэрээгээ эргэж хараач ээ гэсэн байдлаар бид хүсэлт явуулсан гээд.

Үгүй ээ тэгээд энэ чинь иргэд үүнийг чинь хүлээн зөвшөөрчихөж байгаа юм уу. Одоо гэрээгээ эргэж харна гэсэн үг байна шүү дээ. Үгүй шүү дээ. Олон улсад үүнийг чинь шууд зогсоох ёстой. Хөндлөнгийн аудит оруулах ёстой. Санхүүжилтүүдийг нь зогсоож байж. Хэрвээ үнэхээр бодитой асуудал гарсан байна гэх юм бол санхүүжилтээ шийдээд

явдаг. Үгүй бол тэрийг нь холбогдох хуулийн байгууллага нь хянаад явах ёстой юм. Ингээд Монгол Улсын төр тов тодорхой хулгайн дээр ямар нэгэн үйлдэл гаргадаггүй. Эвлэрдэг. Энэ байдлыг нь Засгийн газар хэрвээ явж байгаа бол Улсын Их Хурлын нь зогсоох ёстой юм биш үү.

Тэгэхээр үүнийг тодорхой тусгаж өгөх нь зүйтэй байна. Нэг.

Хоёрт, нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дахиж ийм аж ахуйн шинж чанартай хөрөнгө оруулалттай холбоотой аливаа оффтэйк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамруулахгүй байх гэдэг тов тодорхой заалтыг оруулж өгмөөр байна.

Үндэсний аюулгүй байдалтай холбоотой, тэгээд батлан хамгаалахтай холбоотой, хил, хилийн бүстэй холбоотой эдгээр асуудлууд дээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаад зөвлөмжөө гаргах нь зүйтэй. Гэтэл Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд огт хамаарал байхгүй, улсын нууцад оруулах шаардлагагүй иймэрхүү аж ахуйн шинж чанартай дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр татаж авчирч ярьдаг. Тэгээд зөвлөмж гаргадаг. Түүн дээр нь үндэслээд нууцын зэрэглэлтэйгээр нууж байгаад Монгол Улсад асар хэрэгтэй байгаа энэ мөнгийг чинь үр ашиггүй бүтээн байгуулалтад зарцуулдаг схем чинь болохгүй. Үүнийг хориглох ёстой. Олон улсад “**Vulture fund**” гэж байдаг. **Vulture fund**-д юу хийдэг вэ гэхээр эх үүсвэрийг нь ийм үр ашиггүй бүтээн байгуулалтад зарцуулж байж үнэгүй.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Т.Доржханд гишүүнд нэмэлт 1 минут өгье.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгээд дараагийн нэг зүйл нь бид энэ тайлангийнхаа хураангуй хэсгийн 6 дугаар хэсэгт оруулсан байгаа. Төрийн байгууллагын тогтолцоог өөрчлөх чиглэлээр гээд.

Тэгээд яг энэ зүйл, заалтыг нэмээд оруулчихмаар байна. Өөрөөр хэлэх юм бол 5 дугаар зүйл болгож нэмж оруулмаар байна. Үүнд төрийн байгууллагын харилцан хяналт, тэнцлийг хангах хүрээнд Улсын Их Хурал нь Засгийн газартаа тавих хяналтаа сайжруулах, шүүх, прокурорын байгууллагын томилгоог өөрчлөх, шинэчлэх, Улсын Их Хурлын гишүүдийн халдашгүй байдал, эрх мэдлийг бууруулах, ард түмний төлөөлөл сонгогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, сонгуулийн тогтолцоог өөрчлөх зэрэг саналуудыг гаргасан болно гээд. Үүнийг оруулмаар байна. Дарга аа. Яагаад вэ гэхээр өнөөдөр парламент энэ хуулийн байгууллагуудыг шахах хэрэгтэй. Шахаж байж үр дүн гаргах хэрэгтэй. Нэг.

Хоёрдугаарт, цаашдаа тогтолцоогоороо асуудлыг өөрчлөх нь зүйтэй гэдэг дээр иргэд маш олон санал гаргасан. Үүнийгээ бид тогтоолынхоо төсөлд тусгаж өгөөд батлаад явах нь зүйтэй гэсэн ийм тодорхой.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Т.Доржханд гишүүн тодорхой саналууд байгаа. Энэ зарчмын зөрүүтэй саналуудаа одоо энэ тогтоол дээр цөмөөрөө Байнгын хороон дээрээ хураалгаад явж байна.

Та тэгээд тус бүрээр нь саналын томьёолол бичиж өгөөд ингээд энд хураалгачихъя.

Ерөнхийдөө таны тэр хоёр дахь асуудалтай холбоотой. Т.Доржханд гишүүн ээ,

Таны хоёр дахь асуудалтай холбоотой. Аж ахуйн шинж чанартай гэрээнүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр авч хэлэлцэгдэх асуудлуудын хүрээг хязгаарлая. Энд аж ахуйн чанартай гэрээнүүдийн асуудлыг авч хэлэлцдэг юмыг больё гэсэн энэ санал бол угаасаа явж байгаа. Манай бүлэг дээр ярих яригдсан. Тэгээд чухам хаанаас энэ санал орж ирэх юм. Би одоо тэр үед нь сайн мэдээлэлгүй. Гүйцээж сонсоогүй. Энэ дээр яригдаж байгаа шүү. Давхар.

Тэгэхдээ энэ дээр цөмөөрөө санал хураалгая. Би зүйтэй санал л гэж бодож байна. Баярлалаа.

М.Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Түрүүн бид нарын баталсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол. Тийм ээ.

Одоо яг энэ нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан мэдээлэлтэй танилцах ерөнхий сонсголын талаар авч хэрэгжүүлсэнтэй холбох тогтоол гээд хоёр тогтоол гарч байна. Тийм ээ.

Энэ хоёр тогтоол яг Улсын Их Хурлын тогтоол гэдгээрээ зайлшгүй биелүүлж хэрэгжүүлэх ёстой тогтоол байх учиртай. Тэгээд энэ нээлттэй сонсголын тогтоол дээр хоёр санал байгаа юм.

Нэгд нь, өнөөдөр жишээлбэл Дубайн гэрээ Улсын Их Хурлаараа орж хэлэлцэгдээгүйгээс болоод ямар их луйвар явсныг. Тийм ээ. Бид мэдэж байгаа. Саяын Хөгжлийн банк, нүүрс тойрсон хулгай, луйвар. Үнэнийг хэлэхэд ард түмний хувьд ёстой шударга үнэний хуулиар цангахад хүргэж байна шүү дээ. Энэ бол үнэхээр боломжгүй айтгар зүйлүүд болж байна.

Тийм учраас нэгдүгээрт энэ дээр яг саяын гишүүний хэлж байгаатай би санал нэг байгаа юм. Одоо жишээлбэл оффтэйк гэрээ юм уу, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр биш. Харин ийм том хэмжээний гэрээ хэлэлцээрүүдийг олон улсын түвшиндээ, гаднын том хөрөнгө оруулагчтай хийх тохиолдолд заавал Улсын Их Хурлаараа оруулж хэлэлцүүлдэг байх гэдэг заалт энэ дээр байх ёстой. Түүнээс биш энэ дээр ийм гэрээ дахиж байгуулахгүй энэ тэр гэдэг асуудлыг энэ дээр яачихна шүү дээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл биш харин Улсын Их Хурал. Байнга Улсын Их Хуралдаа танилцуулж. Монгол Улс юуны төлөө парламентын засаглалтай орон билээ. Улсын Их Хурлаар хэлэлцүүлдэг байх гэдэг заалтыг энэ дээр зайлшгүй оруулах нь зөв болов уу гэж бодож байна.

Ер нь сая энэ оффтэйк гэрээ гэдэг бол дандаа луйвар гэдэг нь харагдаж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр бид үнэхээр нухацтай нэг заалт оруулахгүй бол энэ өөрөө бас жоохон ерөнхий болж байна гэж нэгдүгээрт харж байна.

Хоёрт, нь яг энэ тогтоолын төсөл дээр харахад түрүүн гишүүдийн яриад байгаа. Би бас түрүүний тогтоол

хэлэлцэхтэй холбоотой гаргаж тавьсан асуудал нь нөгөө 1072 хувьцааг үнэ цэнтэй болгох. Энэ 1072 гэсэн хувьцаа өнөөдөр иргэд тэр хувьцаагаа ч, ашиг аа ч хуулийн дагуу авч чадахгүй байгаад байна шүү дээ.

Тийм учраас авч чадаагүй сүүлийн хоёр жилийн 2021, 2022 оны 1072 хувьцааныхаа ногдол ашгийг иргэдэд нөхөж олгох гэдэг заалтыг энд зайлшгүй оруулах ёстой гэж би харж байна. Энэ тэгж байж тогтоол хэрэгжинэ. Гэхдээ үүнийгээ тодорхой хугацаа зааж өгч оруулах ёстой.

Иргэд ингээд өөрийн хуулийн дагуу ногдсон ашгаа ч хүртэж чадахгүй байхад нэг хэсэг хүмүүс хэдэн тэрбум доллароор нь мөнгө төгрөг ийш тийш нь гувчуулаад байж байхад бид ингээд хөнгөхөн тогтоол дээр тодорхой тусгахгүй, арга хэмжээ авахгүй байх нь өөрөө шударга бус болно.

Тийм учраас энэ хоёр заалтыг яг тодорхой тусгаж энэ тогтоолын төсөлд оруулах санал байна. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** М.Оюунчимэг гишүүн та энэ саналаа гаргаад хураалгаад явчихъя. Тийм. Одоо би ингээд зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалгаж эхэлнэ. Энэ дунд та өгөөд хураалгачихна.

Дараа нь Б.Энхбаяр гишүүн асуултаа асууя.

**Б.Энхбаяр:** Нүүрсний хулгайтай холбогдсон Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулагдаад үүний мөрөөр Улсын Их Хурлын тогтоол гаргая гэж байгаа юм байна.

Тэгээд энэ тогтоолын төсөл бүх л юмыг хам шимээд л биччихсэн ийм

тогтоол болчхоод байна. Тэгээд яг тодорхой шаардлагатай юмнуудаа л бичсэн тогтоол гаргаж байгаа юм. Хумивал яасан юм бэ.

Тухайлах юм бол одоо Ерөнхий сайдад нэг ийм даалгавар өгч байна. Нүүрсний хулгайн асуудлаар шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажиллах. Энд яах гэж байгаа юм. Анхаараад л байгаа биз дээ. Ерөнхий сайд өөрөө. Анхаарч байгаа хүн дээр дахин анхаараарай гэдэг нь юу гэж байгаа юм.

Тэгээд Их Хурал Засгийн газраа хянаж шалгаж байх ёстой ажил одоо ийм нэг ажил хийсэн болж нэг нь нөгөөдөө шийдвэр гаргасан болж яах гээд байгаа юм.

Тухайлбал, төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр гэдэг дээр төрийн өмчит болон түүний оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд улс төрийн болон төрийн өндөр албан тушаалтан хууль бусаар хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар, чиглэл өгөхийг хориглох, хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар саналаа Их Хуралд өргөн мэдүүлэх.

Энэ угаасаа хориотой шүү дээ. Эрүүгийн хуулиар энэ чинь гэмт хэрэг шүү дээ. Авлигын эсрэг хуулиар хориотой. Төрийн албаны хуулиар хориотой.

Хаашдаа байгаа юмыг байхгүй байгаа юм шигээр үүнийг бий болго энэ тэр гэж яах гээд байгаа юм.

Энэ дотоодын төслийн 2.а, 2.б төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн компани болгох.

Энэ компани болох болохгүйтэй холбоотой харилцаа Төрийн болон орон нутгийн өмчийн хууль болон Төрийн өмч болон орон нутгийн өмчийн компанийн хуулиар зохицуулагдах харилцаа. Энэ төсөл нь Засгийн газраас ороод ирчихсэн шүү дээ. Угаасаа үүнийгээ шийдээд. Их Хуралд.

Одоо манай Байнгын хороо чинь ажлын хэсгээ гаргачихсан. Би ахлаад ажиллаж байгаа байхгүй юу. Энэ хаврын чуулганаар батална шүү дээ.

Нэгэнт Засгийн газар өргөн барьчихсан. Өөрөө бас энэ чиглэлээр санаачилга гаргаад ажиллаж байгаа ийм юмнуудыг нь дахиж бичиж энд яах гээд байгаа юм бол гэсэн ийм асуулт байна.

3.б дээр жишээлбэл Түр хороог сонсгол зохион байгуулахыг даалгасугай гэж яах гээд байгаа юм.

Энэ чинь хуулиараа угаасаа сонсгол зохион байгуулна шүү дээ. Түр хороо. Хуульд нь биччихсэн шүү дээ. Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль дээр. Энэ байгуулагдсан Түр хороо чинь нотлох баримтыг шинжлэн сонсох сонсголоо угаасаа зохион байгуулах юм билээ шүү дээ. Тэгээд Их Хуралд бүр тайлагнах юм билээ. Энэ чинь хуультай юм байна лээ.

Одоо Хөгжлийн банкны хянан шалгах хороо ирэх долоо хоногт сонсголоо эхлэх гэж байгаа шүү дээ. Тэгээд 4 сард Улсын Их Хурлын тайлангаа танилцуулах юм билээ. Энэ нөгөө Хяналтын хуулиараа.

Хуульд байж байгаа ийм юмнуудыг бичиж тогтоол гаргасан нэр зүүж яах гээд байгаа юм.

Би энэ “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаан дээр 2012 оноос хойш төрсөн дээр хувьцаа эзэмшүүлээд шийдвэрлэх гэж байгаа шүү. Би энэ дээр тооцоо судалгаагаа мэдмээр байна. Энэ хэдэн хүний асуудал яригдах гээд байгаа юм. Хэдэн төгрөгийн асуудал яригдах гээд байгаа юм. Энэ яаж шийдэх юм. Ийм тооцоо байхгүй.

Тэгээд миний итгэл үнэмшил нэлээн сулраад байна.

Хамгийн сүүлийн тэр дөрөв дэх асуудал. Энэ Их Хурлаас зохион байгуулж байгаа Ерөнхий хяналтын сонсгол дээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдийг оролцуулах. Энэ яах гэж байгаа юм. Оролцуулахгүй байгаад байгаа юм уу. Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд гурвыг. Орьё гээд байгаа юм уу?

**Ц.Цэрэнпунцаг:** Ингээд ерөнхийдөө Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо боловсруулаад чуулганаар оруулах гэж байгаа тогтоолын төсөл байгаа.

Тэгэхээр одоо бүгдээрээ Байнгын хороон дээрээ асуудал болгоноор нь, зүйл болгоноороо ярилцаад явчихъя. Нэгд.

Хоёрт, Б.Энхбаяр гишүүн ээ. Энэ нийтийн хяналтын сонсголтой холбоотойгоор орж ирж байгаа тогтоолын төсөл. Тийм ээ. Тэгээд энэ дээр ард иргэд маань гаргасан саналууд байгаа юм.

Тэгэхээр таны яг саяын асуугаад байгаа энэ асуултыг ард түмнээсээ асуумаар байгаа юм. Яг санал гаргасан нь тэр нэр устайгаа байгаа. Нийтийн

хяналтын сонсгол дээр оролцсон иргэдийн санал байгаа юм шүү.

Тэгэхээр иргэдтэйгээ та чинь харин их сайн харилцдаг гишүүн. Тэгээд бас асуух хэрэгтэй байх аа.

Б.Энхбаяр гишүүн ээ, одоо цөмөөрөө тогтоолынхоо төслөө эхнээсээ яриад явчихна. Б.Энхбаяр гишүүн ээ, Таны саяын энэ саналуудыг цөмөөрөө найруулгыг нь найруулга нь, зарим давхцаж байгааг нь ингээд ингээд явья гээд шууд энэ дээр боловсруулаад явчихаж байгаа учраас Та саяхан идэвхтэй анхааралтай сонсоод цөмөөрөө тогтоолынхоо төслийг гаргая.

Тэгээд тогтоолын эхний болон эцсийн хэлэлцүүлгийг нь хамтатгаж явуулья гээд Байнгын хороон дээрээсээ горимын санал гаргаж хураалгаад дэмжигдвэл нэгтгээд нэг мөсөн гарчих байгаа юм шүү.

Би одоо бүр эхнээс нь уншъя. Тэгвэл би гарчигас нь эхлээд уншъя.

“Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах” Ерөнхий хяналтын сонсголын тайлан хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар дараах арга хэмжээг



хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэд даалгасугай.

1/Удирдлага, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, олон нийтийн хяналтын талаар:

а/нүүрсний экспорт, тээвэрлэлтийн явцад нүүрсний хулгай үүссэн шалтгаан нөхцөлийг тогтоож, бодитой дүн шинжилгээ, дүгнэлт хийн Улсын Их Хуралд танилцуулах. Дахин ийм нөхцөл байдал үүсгэхгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалт, хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэн шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Энэ дээр саналтай гишүүд. Тэгвэл үүгээрээ явчихъя. Тэгэх үү. Уншсан төслөөрөө явчихъя.

Хоёрт. б/нүүрсний хулгайн асуудлаарх Засгийн газрын шалгалтын ажлыг эрчимжүүлэх, Монгол Улсын Их Хурлаас байгуулсан Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаатай уялдуулах, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл харилцан солилцох, нүүрсний экспорт тээвэрлэлтийн хэвийн тасралтгүй үйл ажиллагаанд доголдол үүсгэхгүйгээр шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажиллах.

Энэ дээр саналтай гишүүд. М.Оюунчимэг гишүүн саналаа хэлээрэй.

**М.Оюунчимэг:** Энэ саяын заалт бол маш ерөнхий байна.

Угаасаа Засгийн газар нүүрсний хулгайтай тэмцэнэ гээд зарлаад яваад байгаа. Энэ нь эрчимжээд явж байгаа нь

ойлгомжтой. Гэхдээ нэг ч хүн өнөөдөр яг үүгээр хэчнээн, ямар асуудал үүссэн юм. Нүүрсний хулгай гэдэг бол асар том зохион байгуулалттай хулгай байгаад байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг нь яг жинхэнэ эзний нь, цаад зохион байгуулагчдыг нь. Хууль хүчний байгууллагыг харин илүү энэ рүү нь ажиллаж Их Хуралдаа танилцуулж мэдээлэх эзэн нь тодорхой болгох.

Энд зүгээр нэг сайхан шүгэл үлээгээд байгаад байх биш шүү дээ. Хамгийн гол нь буруутай хүмүүст нь хариуцлага хүлээлгэх. Эргэж тэрийг “Эрдэнэс Тавантолгой” болоод улсын өмчийг, улсын төсвийг алдагдалгүй болгох энэ тэр гээд ийм зүйлүүд л энэ чинь өөрөө хууль хэрэгжих гол заалт шүү дээ.

Тэгэхгүйгээр энэ орж ирж байгаа чинь угаасаа одоо хийж байгаа ерөнхий. Зайлшгүй эд нар эрчимжүүлэх ёстой. Үүнийг хийх ёстой. Харин Их Хурлын гол үүрэг бол энэ яриад байгаа юмаа бодит болго. Тэр авах арга хэмжээгээ бодитоор ав. Тэр эзнийг нь тодорхой болгож үүнийг зүгээр нэг дуулиан шуугиан, шүгэл үлээх биш, харин хэргийг шийдвэрлэж олон түмэнд ил тод мэдээлэх энэ тэр гэж оруулж байж энэ хэрэг явна шүү дээ.

Тэгэхгүй бол одоо ингээд бараг л юу болох гээд байгаа нь мэдэгдэхгүй. Нэг хэрэг нь нөгөө хэргээрээ дарагдах тийшээгээ хүртэл яваад байна гэсэн шүүмжлэл хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хүртэл гарч байна шүү дээ. Бид ч энэ шүүмжлэлтэй хандаж байгаа.

Тэгэхээр яг ингэж тодорхой заалт тусгаж өгмөөр байна гэж хэлмээр байна.



**Ц.Цэрэнпунцаг:** М.Оюунчимэг гишүүн та ямар агуулга, найруулгатайгаар энд оруулбал яг таны саяын энэ тусахаар байна. Энэ агуулгаараа хэлэлцээд цөмөөрөө Байнгын хороон дээрээ одоо бүгдээрээ яг энэ дээрээ хэлэлцээд тэр саналуудаа гишүүдээсээ саналаа хураагаад тийм үү, тэгээд явчихъя.

Та тэгэхээр энэ хоёр дээр яг өөрийнхөө найруулгаар саналаа оруулаад томьёолоод гаргаад ирэх үү. Тэгээд энэ хооронд дахиад дараагийнхаа асуудлыг ярьж байя. Эргээд энэ дээрээ ярьчихъя.

в/байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэн тэгш, шударгаар хүртэх, баялгийн ашиглалт, хуваарилалтын ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтад оруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах хүрээнд Засгийн газарт онцгой дэглэм тогтоох эрх олгосон зохицуулалтыг хүчингүй болгох талаарх санал болон Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн бүтээгдэхүүний ил тод байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлэх.

Энэ дээр саналтай гишүүд байна уу? Тэгвэл цөмөөрөө энэ дээрээ саналаа хураагаад явж байя. Тусад нь хураагаад нэмээд явчихъя л даа.

Б.Энхбаяр гишүүн саналаа хэлээрэй.

**Б.Энхбаяр:** Энэ дээр нэг ийм өгүүлбэр байна л даа.

Засгийн газарт онцгой дэглэм тогтоох эрх олгосон зохицуулалтыг хүчингүй болгох талаарх санал. Энэ нөгөө 1991 оны хуулийг хүчингүй болгох

саналаа Их Хуралд оруулж ир гэж хэлж байна уу? Эсвэл энэ өөр юм яриад байна уу?

**Ц.Цэрэнпунцаг:** Б.Энхбаяр гишүүн ээ. Энэ яг үнэн. Яг тэр агуулгаар орж ирж байгаа юм. Яг нөгөө санал гаргасан хүмүүс бол үүнийг хүчингүй...

**Б.Энхбаяр:** Хуулийнх нь нэрийг нь шууд биччихээч дээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Тэгэх үү.

**Б.Энхбаяр:** Энэ чинь би ойлгохгүй л байна шүү дээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Тэгвэл та энэ дээр нэрээр нь...

**Б.Энхбаяр:** 1991 оны тэр хуулиа гээд бүр хуулийнх нь нэрийг нь биччих. Үүнтэй хамт тэгвэл дахиад нэг хууль хүчингүй болгож оруулж ирээч.

1992 оны шинэ Үндсэн хуулиас өмнө батлагдсан хоёрхон хууль манайд үйлчилж байгаа. Нэг нь, Онцгой дэглэм тогтоох хууль. Нэг нь, Бүгд Найрамдах Монгол Ардын Улсын Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль гэж байгаа юм.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс чинь байхгүй болчихоод байна шүү дээ. Бүгд Найрамдах Монгол Ард Улс чинь өөрчлөгдчихсөн. Байхгүй болчихсон шүү дээ. 1992 онд. Социализмын үеийн Үйлдвэрчний эвлэл гээд нэг юм яваад байна шүү дээ энэ чинь одоо.

Энэ чинь байна шүү дээ, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд ордог, Ажил олгох зөвлөлд ордог. Бид өмчийн хууль хэлэлцэж байгаа. Энэ баахан объектууд эзэмшдэг. Хөрөнгүүд. Тэрийгээ зардаг.

Одоо Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордон чинь энэ байгууллагын мэдэлд байгаад байгаа байхгүй юу. Бүгд Найрамдах Монгол Ардын Улсын Үйлдвэрчний эвлэлийн мэдэлд байгаад байгаа байхгүй юу. Үүнийгээ түрээсэлдэг. Тэгээд тэр Замын цагдаагийн газрын хажууд байсан тэр том газрыг зарсан. Газрын наймаа хийдэг.

Тэгээд үүний чинь шалтгаан, үндэс нь шинэ Үндсэн хуультай нийцэхгүй нэг ийм хууль үйлчлээд байгаа байхгүй юу. Одоо тэгээд үүнийг нь ярихаар Үйлдвэрчин, нөгөө хуучин тогтолцоогоор л нөгөө хөдөлмөрчин ангиасаа айдаг юм уу, яадаг юм. Одоо энэ чинь байхгүй болчихсон шүү дээ. Бүгд хөдөлмөр эрхэлж байгаа.

Тэгээд тэд нараасаа татвар авдаг. Тэгээд улс төр хийдэг. Зарим нь. Энэ байгууллагыг улс төрд гарах гишгүүр болгодог. Тэгээд энэ байгууллага байна шүү дээ. Би яагаад үүнийг яриад байна вэ гэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох үндэсний зөвшилцөлд ороод байгаа байхгүй юу. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ.

Манайх чинь чөлөөт зах зээлийн эдийн засагтай улс. Одоо бид шилжээд 30 жил болчихсон. Зах зээлийн суурь индекс рүү тогтооход оролцдог байгууллага байхгүй юу.

Тийм учраас энэ чинь зүгээр нэг байгууллага, байшингийн асуудал би яриад байгаа биш байхгүй юу. Тийм.

Тэгээд шинэ хуулиар юу болсон гэсэн чинь энэ нөгөө тендерүүд, концессууд дээр дандаа энэ байгууллагын төлөөлөл ордог. Тийм юм байна лээ шүү дээ. Одоо Нийгмийн даатгалын сангийн

мөнгө алга болчихлоо. Яав. Капитал банкинд алга болсон гэсэн. Энд чинь санал хурааж гаргасан 3 хүн байгаад байгаа байхгүй юу. Энэ байгууллагын төлөөлөл. Хариуцлага үүрдэггүй. Ерөөсөө хариуцлага үүрдэггүй. Тэгээд энэ байгууллагынх нь асуудлыг ярихгүй бол.

Энэ төрийн мөнгө, энэ хулгай, луйвар луу чинь нэг ийм схем яваад байгаа байхгүй юу.

Тийм учраас 1991 оны тэр байгууллагын асуудлыг бид шинэчлэх ёстой. Би татан буулгах тухай яриагүй шүү. Тэр Үйлдвэрчний эвлэлийнхэн энд эмзэглээд байх юм байхгүй. Шинэ Үндсэн хуульдаа нийцээд ардчилсан тэр жамаараа байгууллагаа байгуулах хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу.

**Ц.Цэрэнпунцаг:** Б.Энхбаяр гишүүн ээ, та Хууль зүйн байнгын хороон дээрээ энэ асуудлаа, саяын сүүлийн ярьдгийг яривал яах вэ. Асуудлаа.

Зүгээр одоо энэ дээр бол яг таны хэлсэн саналаар нөгөө хуулиа нэрээр нь оруулчихъя. Тэгэх үү. Нэрээр нь оруулчихъя. Тэгвэл нэрийг нь бичээд оруулъя гэдэг дээр цөмөөрөө санал хураачихъя. Тэгэх үү. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

г/төрийн байгууллагуудын мэдээлэл өөр хоорондоо зөрүүтэй байгаад дүгнэлт хийж, Монголбанк, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам зэрэг холбогдох байгууллагуудаас нүүрсний тээвэрлэлтэй холбоотой статистик мэдээллийг үнэн зөвөөр гаргах, нүүрсний

үнийн зөрүүний асуудлыг судалж үзэх, дүгнэлт хийж ажиллах.

Энэ уншсан төслөөр санал хураалт явуулж байна. Санал хураалт. Өөр саналтай гишүүд байхгүй учраас санал хураалт явуулж байна.

Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

д/“Шинэ сэргэлт”-ийн бодлогод тусгагдсан “Боомтын сэргэлт”-ийн хүрээнд хилийн боомтуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, боомт дагасан суурьшлын бүсүүдийн дэд бүтэц, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх Боомтын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Саналтай гишүүд байна уу? Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувийг нь дэмжиж, санал дэмжигдлээ.

е/Ерөнхий хяналтын сонголын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж ажиллан, явц байдлыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тухай бүр танилцуулах.

Санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2/Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр:

а/төрийн өмчит болон түүний оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд улс төрийн болон төрийн

өндөр албан тушаалтан хууль бусаар хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар чиглэл өгөхийг хориглох, хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаарх саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Б.Энхбаяр гишүүн танд санал байгаа юу? Тийм ээ. Б.Энхбаяр гишүүн саналаа хэлье.

**Б.Энхбаяр:** Саяын заалт шаардлагагүй.

Би өөрөө Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ хуульд шингэсэн асуудлаар Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан юм. Судалгааны ажил хийсэн.

Тэгээд Монгол Улсын 40-өөд хуулиар энэ хориотой байгаа. Угаасаа. Энэ өөрөө гэмт хэрэг. Авлигын хуульд байгаа. Тэгээд үүнийг байхгүй юм шиг. “Зохицуулалтыг бий болгох” энэ тэр гэж. Энэ шаардлагагүй.

Энэ байгаа хуулиа л мөрдөөгүйгээс л үүсээд байгаа асуудал шүү дээ. Хамгийн сүүлд бид 2019 онд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулахдаа “улс төрд нөлөө бүхий этгээдүүд, төрийн өндөр албан тушаалтнууд өөрөө гарын үсэг зурдаггүй боловч бусдаар үйлдүүлдэг, эрх нөлөөгөө ашиглах” гэдэг гэмт хэргийг хуульчилчихсан.

Энэ бичээд байгаа тэр заавар, чиглэл өгөх, нөлөөлөх гэдэг юмыг чинь гэмт хэрэг болгоод биччихсэн байхгүй юу.

Тийм учраас энэ угаасаа гэмт хэрэг. Сая бид Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулаад үүнийг бүх насаар нь хорих ялтай болгочихсон.

Одоо бид нарт үүнээс цаашаа, дээш нь сунгах тийм ял байхгүй. Хариуцлага. Тийм. Тэгээд энэ тийм байгаа шүү.

**Ц.Цэрэнпунцаг:** Б.Энхбаяр гишүүн сайхан тодорхой тайлбарласан. Энэ шаардлагагүй зүйлийг шууд хасаад явчихъя.

Дараагийн зүйл. Манай Байнгын хорооныхон, зөвлөх энэ дээрээ редакцаа хийгээд явчихна. Тэгээд дугаарлалтаа шилжүүлээд хийгээд явчхаарай.

б/төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн компани болгох, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах, удирдлага, хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангуулан ажиллах.

Б.Энхбаяр гишүүн саналаа хэлье.

**Б.Энхбаяр:** Үүнийг би дэмжихгүй байгаа юм.

Яагаад дэмжихгүй байна гэхээр би зарчмыг дэмжиж байгаа шүү дээ. Ер нь төрийн өмчийн компаниудыг болиулах, паблик компани болгох ёстой. Энэ ТУЗ гэдэг юмыг нь сонгон шалгаруулдаг болох ёстой, хяналтыг нь сайжруулах ёстой, нээлттэй байдлыг нь хангах ёстой гэдэг зарчмыг нь дэмжиж байгаа юм.

Тэгэхдээ энэ асуудал угаасаа Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн баригдсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслөөр энэ асуудал хуульчлагдаж шийдэгдэнэ. Тогтоолоор биш.

Угаасаа төсөл нь Улсын Их Хуралд ороод ирчихсэн. Манай Байнгын хороогоор хэлэлцэгдэнэ. Энэ чинь ороод ирчихсэн байгаа шүү дээ. Их Хуралд.

Бид хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн байхгүй юу даа. Засаг үүргээ биелүүлчихсэн байхгүй юу. Энэ Их Хуралд оруулаад ирчихсэн.

Одоо бидний ажил болчихсон байхгүй юу. Үүнийг Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдад даалгаад байх ямар ч хэрэггүй. Энэ чинь гайхна шүү дээ.

Дөрвөн сарын өмнө Улсын Их Хуралд өргөн барьчихсан асуудлыг нь өргөн барь гээд бид шийдвэр гаргах гээд байгаа байхгүй юу. Одоо энэ бидний асуудал болчхоод байна шүү дээ. Энэ ямар ч шаардлагагүй болчхоод байгаа байхгүй юу. Бид хуулиар шийднэ шүү дээ. Үүнийг.

Үгүй үгүй. Хууль батлагдах хүртэл гээд ийм ерөнхий заалт оруулчихвал энэ нэг Их Хурлын тогтоол гаргасан юм гээд нөгөө компаниуд чинь бүгдийг нь хувьчлаад хаячихвал яах вэ. Тийм.

Үүнийг чинь далимдуулаад зах зээлийн үнэлгээ нь бага байгаа дээр нь хэсэг нөхдүүд төрийн өмчийг хувьчилж авч хулгай хийх гээд байна гээд Ц.Даваасүрэн гишүүнээс эхлээд яриад байгаа шүү дээ.

Эсвэл тэгэх гээд байгаа юм уу. Нээрэнгээсээ. Би тэгэхгүй л гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь хуулийн дагуу хийхгүй бол одоо нэг ийм уут олгосон ерөнхий тогтоол гаргачихмааргүй байна.

Одоо хөрөнгийн бирж дээр чинь бас л бөөн хэл ам болоод байна шүү дээ. Хэсэг нөхдүүд бас ингээд том хувьцаа эзэмшигч гэдгээр давуу байдал авах гээд байна. Өөрсдөө авах гээд байна гээд л ингээд л асуудал үүсээд байгаа байхгүй юу.

Бид иймэрхүү асуудлуудыг төрийн өмчийнхөө 500 гаруй компани дээр альныг нь яах вэ гэдэг нь мэдэгдэхгүй зүгээр ингээд уут нээгээд өгчхөж болохгүй байгаад байгаа байхгүй юу.

Хэрвээ бид төрийн өмчийн компаниудыг хувьчлах дээрээ хүрвэл үүнийг нэг бүрчлэн Улсын Их Хурлын дээр ярьж байж шийдэх ёстой байхгүй юу. “Эрдэнэ Тавантолгой”-г яг яах юм. Эрдэнэтийг яг яах юм. Багануурыг яг яах юм. ТЭЦ-IV-ийг яг яах юм. Ингэж байж, ярьж байж Их Хурал шийдэх эрх нь Их Хуралд байгаад байгаа байхгүй юу. Ганц үгтэй ийм ерөнхий заалтыг чинь нэг хулгайч ашиглаад л хувьчлаад авчихна шүү дээ. Үүнийг чинь.

Тийм учраас би хасья гэдэг санал гаргаад байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны гишүүд маань үүнийг ерөнхийдөө хасья гэдэг дээр санал нэгдэж байна. Би ч яах вэ хасчихъя. Ийм ерөнхий юм сүүлдээ нэг тийм орон зай үүсгэчихвэл хэцүү.

Тэгэхдээ Б.Энхбаяр гишүүн энэ хуулиуд дээр ажлын хэсэг ахалж ажиллаж байгаа учраас төрийн өмчтэй компаниудаа хамгийн түрүүнд олон нийтийн хяналт оруулахын тулд тодорхой хувиудыг нь хөрөнгийн биржээр дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг оруулж ирж.

Тэгээд хөрөнгө оруулагчид маань компанийнхаа үнэ цэнийг тогтооно шүү дээ. Ямар үнэлгээтэй юм. Үнэлгээг нь тогтоох явцыг явуулаад дараа нь цаашаа гүнзгийрэх юм бол одоо бид нарын тэр үнэлгээн дээр хямдхан байхад нь авах гэж байна. Эсвэл ингэх гэж байна, тэгэх гэж байна гэдэг ийм юмнууд арилах учраас энэ зөв дэс дарааллаараа явах нь зүйтэй байх гэж санаж байна.

Тийм учраас цөмөөрөө үүнийг хасчихъя. Тэгэх үү. Тэгье. Тэгвэл гишүүд маань энэ дээр бүгд санал нэгдэж байна. Ингээд хасаад. Дараагийн “в” хэсгийг уншъя.

в/“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судлан, эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлж, шийдвэрлэх.

М.Оюунчимэг гишүүн. Б.Энхбаяр гишүүн дараа нь. М.Оюунчимэг гишүүн саналаа хэлье.

**М.Оюунчимэг:** Энэ “в” дээр нэг санал нэмж оруулах хүсэлтэй байна.

Энэ нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх гээд таслал тавиад, сүүлийн хоёр жил буюу 2021, 2022 гээд оныг нь яг тавиад, 1072 хувьцаагаа хуулийн хүрээнд авч чадаагүй иргэдэд нөхөж олгох гэдэг заалтыг энд оруулчихвал яг таарна гэж бодож байна.

Энэ чинь шинээр эзэмшүүлэх. Энэ “судлах” биш. Угаасаа “эзэмшүүлэх”. Гэхдээ тооцоо судалгааг нь бодитоор гаргаж ирэх. Тэгээд сүүлийн хоёр жилийн хугацаанд хуулийн дагуу 1072 хувьцаагаа авах чадаагүй иргэдийн эрх зөрчигдөж байгаа учраас нөхөж олгох гэдэг. 1072-ын хувьцааны ашгийг хуулийн хүрээнд нөхөж олгох.

Энэ чинь хууль зөрчигдөөд. Энэ хүмүүс авах ёстой. Авч чадаагүй байгаа шүү дээ. Байгаад байгаа байхгүй юу. Угаасаа 2021, 2022 онд ногдол ашиг хуваарилаагүй, авч чадаагүй байгаа байхгүй юу. Тийм. Ногдол ашгийг хэлж байна шүү дээ. Ногдол ашгийг. Тийм.

Тэгэхээр ногдол ашигтайг энд оруулчихвал зүгээр юм болов уу гэж бодож байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Энэ дээр сая М.Оюунчимэг гишүүн тодорхой саналаа хэлсэн. Б.Энхбаяр гишүүн саналаа хэлье.

**Б.Энхбаяр:** Бид энэ заалт дээр огт тооцоо судалгаагүй ярьж байна. Одоо жишээлбэл саяын ногдол ашиг хуваарилдаг асуудал чинь хувьцаа эзэмшигчийн асуудал шүү дээ. Компанийн хуулиар. Компанийн хуулиар ТУЗ-ийн шийдэх ёстой асуудал байхгүй юу.

Тэгэхээр Их Хурал юугаа шийдэх юм, Засгийн газар юугаа шийдэх юм, эрхэлсэн сайд юугаа шийдэх юм, компанийн ТУЗ юугаа шийдэх гэдэг бүгд хуультай.

Бид улс төрчид учраас төрийн эрх барих дээд байгууллага юу ч хамаагүй шийдэх эрхтэй гэдэг тоглоомын дүрмээр өмнөх ах нарынхаа, эгч нарынхаа алдааг давтаад яваад баймааргүй байна.

Одоо иргэддээ мөнгө өгье гэвэл бүгд л өгмөөр байна л даа. Гэхдээ энэ тооцоо судалгаа хэрэгтэй байна. Одоо жишээлбэл 2012 оны 04 сарын 01-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд гэдэг дээр би хэдэн иргэдэд хэдэн төгрөгийн үнэлгээтэй хувьцаа эзэмшүүлэх гэж байгаа вэ гэдэг асуултыг хэнээс асуух юм бэ. Энэ заалт дээр кноп дарахын тулд. “Yes” гэдэг кноп харахын тулд. Энд хариулт байхгүй. Тэгээд тогтоолын заалт маань юу гэж байна вэ гэхээр судлаад, саналаа хүргүүлээд, шийдвэрлэх гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр нэгэнт ийм хариултгүй маш их олон асуудал байгаа. Нэг.

Хоёрдугаарт, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Компанийн хуулиар энэ асуудлыг компанийн хувьцаа эзэмшигчид чинь шийднэ шүү дээ. Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа шийддэг хуультай байхгүй юу.

Одоо бид нар шууд Улсын Их Хурал. Би хэлээд байгаа шүү дээ. Улсын Их Хурлын өөрөө баталсан хуулиа мөрдөх нь Улсын Их Хуралд бас хамаатай байгаад байгаа шүү дээ. Хууль нь болохгүй бол бид хуулиа янзлах ёстой байхгүй юу. Тэр Компанийн хуулиа.

Одоо энэ асуудал төрийн өмч болон орон нутгийн өмчийн компанийн хуулиар зохицуулагдах гэж байгаа байхгүй юу. Тэгээд ТУЗ-ын шийдвэрлэх асуудлыг Засгийн газар шийдээд байж болохгүй. Мөн Улсын Их Хурлын шийдээд байж болохгүй шүү дээ. Тэгвэл тэр ТУЗ гэж байгаад яах юм. Гүйцэтгэх захирлын эрх хэмжээний асуудлыг ТУЗ бас шийдээд байж болохгүй шүү дээ. Тэгвэл гүйцэтгэх захирал гэж байгаад яах юм.



Тэгэхээр энэ чинь одоо жишээлбэл ийм асуудал байна шүү дээ. Тэгвэл Компанийн хуулиа өөрчилж байж л энэ асуудлыг ярина. Компанийн хуулиар ТУЗ-ын эрх хэмжээний асуудлыг Улсын Их Хурлын тогтоол гаргаж шийдэх гээд байна шүү дээ.

Тэгээд би цэц дээр унана гэж бодож байна. Хэрвээ ингэвэл. Яагаад гэхээр Улсын Их Хурлын тогтоол чинь хуульд үндэслэх ёстой байхгүй юу. Нийцэх ёстой. Хуулиас давсан Улсын Их Хурлын тогтоол гарч болохгүй байхгүй юу. Логик нь.

Тийм учраас хэрвээ энэ асуудал байвал би ийм л байх ёстой гэж бодож байна. Шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж, танилцуулах. Ингээд л боллоо. Судалгаа байхгүй байгаад байна шүү дээ. Хуульдаа нийцэж байгаа юм уу, нийцэхгүй юм уу. Бид шийдэж болох юм уу, болохгүй юм уу. Бид улс төрийн шийдлээ гаргаж болно шүү дээ. 2012 оноос хойших дээр “эзэмшүүлье” гэдэг дээр би зарчмын хувьд санал нэг байгаа.

Санал нэг байгаа асуудал дээрээ гол нь юу байна вэ гэхээр энэ маань хуульд нийцэж байна уу, хэчнээн хүний асуудал, хэчнээн төгрөгийн асуудал яригдах гэж байгаа юм гэдгээ мэдэхгүй байгаад байна шүү дээ. Би асуухаар хэн хариулах юм. Энэ дээр.

Тийм учраас нөгөө тооцоо судалгаа нэхээд байгаа байхгүй юу.

Тийм учраас “судалж, танилцуулах” гэж. Эргэж танилцъя л даа. Үүнийг. “Шийдвэрлэх” гээд дуусаад байна шүү дээ. Наадах чинь. “Түүгээрээ шийдвэрлэ” гэсэн үг байхгүй юу. Энэ чинь. Шууд шийдвэрлэ гээд байгаа

байхгүй юу. “Судлаад”, “хүргүүлээд”, “шийдвэрлэ” гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр чиг засаг чинь Их Хурал шийдвэрлэ гэгчихсэн учраас бид шийднэ гээд шийдэх гээд байна шүү дээ. Их Хурал өөрөө шийдмээр байна шүү дээ. Бид өөрсдөө.

**Ц.Цэрэнпунцаг:** Ж.Бат-Эрдэнэ гишүүн “в” дээр саналтай. Саналаа хэлнэ. Ж.Бат-Эрдэнэ гишүүн саналтай байна. Саналаа хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Түрүүний хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний төсөл дээр байсан 5 дугаар заалтыг л задлаад л орж ирж байгаа юм л даа.

Тэгэхээр энэ 5 дугаар заалт дээр чинь ингэсэн шүү дээ. Түрүүн энэ тавыг эндээс аваад нөгөөд рүү оруулья гэсэн шүү дээ. Тэгэхээр нөгөө боловсруулалтын явцад яг энэ чигээрээ орж ирээгүй болчих гээд байна. Энэ 5 дугаар заалт дээр 2023 оны 1 дүгээр улиралд багтааж танилцуулах гэгчихсэн байгаа шүү дээ. Танилцуулах. Тийм.

Тэгэхээр энэ хувилбараар орох ёстой байхгүй юу. Тэгэхээр Б.Энхбаяр гишүүний хэлдэг зөв л дөө. Орж байгаа шүү дээ. Тийм болохоор ерөөсөө хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж боловсруулан Улсын Их Хуралд эргэн танилцуулах гэсэн энэ үг үсгээрээ. Асуудлыг судалж Улсын Их Хуралд 2023 оны 1 дүгээр улиралд багтаамж танилцуулах гэдгээрээ л явчихъя.

Тэгэхээрээ болж байгаа байхгүй юу. Тэгж байж бид буцаад эргээд яг ямаршуу байдалтай орж ирж байгаа юм, ямар санал орж ирж байгаа юм гэдэг чинь орж ирэх юм. Зөв биз дээ.



Тэгэхээр түрүүний тогтоолыг чинь ийшээ оруулъя гэдгээрээ л. Түрүүн яг энэ байдлаар хассан шүү дээ. Тийм болохоор тийшээ оруулчихъя. Тийм. Тэгье.

**Ц.Цэрэнпунцаг:** Б.Энхбаяр гишүүн ээ, ерөнхийдөө найруулга. Тийм ээ. Бид найруулгын цэгцлээд саяын Ж.Бат-Эрдэнэ гишүүний нөгөө биржийг нь дагасан тогтоол дээр байсан агуулга энд оруулж ирж байгаа учраас ер нь яг ингээд явчихвал одоо тэр 5 дахь заалт энд ороод ирж байгаа, багтаж байгаа гэж ойлгож болох уу?

Ж.Бат-Эрдэнэ гишүүн ээ. Танд санал байгаа юм уу? Тэгвэл үүгээрээ явчихъя. Бид нарын саяын найруулж уншсан Ж.Бат-Эрдэнэ гишүүний уншсанаар ингээд найруулчихлаа.

Тэр “санал хурааж шийдвэрлэх” гэснийг ерөнхийдөө “судалж, танилцуулах” гэж оруулж байгаа. Ж.Бат-Эрдэнэ гишүүн саналаа тодруулж хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цаг хугацаатай байсан нь дээр байх. Тийм үү. “Бүртгэлтэй иргэнд эзэмшүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд 2023 оны 1 дүгээр улиралд багтаан” гэдгээрээ бүр цаг хугацаатайгаа орчихье гэж байгаа шүү дээ. Тийм үү. Яг энэ томьёоллоор авчихъя. Багцаанд танилцуулах гэдгээр.

**Ц.Цэрэнпунцаг:** Тэгвэл Ж.Бат-Эрдэнэ гишүүний уншсанаар ингээд цөмөөрөө баталчихъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 81.8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд М.Оюунчимэг гишүүний зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэндээ танилцуулъя.

Саналын томьёолол нь 2.д оруулах. “Сүүлийн хоёр жилд иргэдэд олгох ёстой 1072 ширхэг хувьцааны ногдол ашгийг нөхөн олгох” гэж бичсэн байна.

Ийм заалт нэмэгдэж оруулъя гэж М.Оюунчимэг гишүүн санал оруулж байна. Яг үүгээр нь хураалгачих уу. Энэ дээр саналтай гишүүд байна уу? М.Оюунчимэг гишүүн та тайлбарлаах даа.

**М.Оюунчимэг:** Энэ өнгөрчихсөн зүйл биш ээ. Энэ хуулиараа бүх 2021 нь ч байгаа, 2020 он, 2023, 2024 он гээд тухайн 1072 хувьцаа эзэмшиж байгаа хүн ногдол ашгаа авах ёстой байхгүй юу. Авах ёстой мөнгө нь.

Гэтэл сая 2021, 2022 он буюу сүүлийн хоёр жил энэ “Эрдэнэ Тавантолгой”-гоос авах ёстой ногдол ашгаа иргэд авч чадаагүй байгаа учраас үүнийг нь өгөх ёстой байхгүй юу. Түүнээс биш энэ нөхөн олговор ч биш. Зүгээр халамж ч биш. Авах ёстой юмаа л авч байгаа зүйл. Сая үүнийг нь олгоогүй байхгүй юу.

Тийм учраас энэ тогтоол дээрээ үүнийг нь нөхөж олгох. Иргэдийн хуулийн дагуу авах ёстой ногдол ашгийг нөхөж олгох гэж оруулах ёстой гэж байр сууриа бичиж байгаа. Оны нь харин яг биччих хэрэгтэй. 2021, 2022 он гээд.

**Ц.Цэрэнпунцаг:** М.Оюунчимэг гишүүний саналаар санал хураалт явуулъя.

С.Чинзориг гишүүний татаад авчихсан санал чинь энэ байхгүй юу. Энэ агуулгаар явж байсан юм. С.Чинзориг гишүүнийх бол ер нь төмөр замаас тэгвэл та нар мөнгө авч чадахгүй бол хувьцаа өгөх ёстой гэсэн ийм агуулгаар оруулж л байсан юм л даа.

Сая томьёоллоо уншчихсан. Тийм ээ. Санал хураачихья. Бүгдээрээ. Тэгэх үү. Ингээд санал хураалт явуулчихья.

Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал. Ш.Адьяшаа гишүүн гаргасан.

Энэ 2.г дээр. Ш.Адьяшаа гишүүн өөрөө алга байх юм. Уншаад ерөөсөө учрыг нь ойлгохгүй байна. Хачин. Ингээд холиод сүүлд нь засаад давхардуулаад биччихсэн. Та бүхэн ойлгохыг хичээгээрэй.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн горимын санал гаргах гэж байна уу? Та. Ж.Бат-Эрдэнэ гишүүн санал гаргая.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ буруу дээр дарагдчихлаа. Тийм болохоор дахин саналыг танилцуулаад саяын саналыг хүчингүйд тооцож өгөөч ээ гэсэн санал гаргаж байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Сая Ж.Бат-Эрдэнэ гишүүн горимын санал гаргасан. Хамгийн сүүлд хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн. Үгүй үгүй. Харин тийм. Ж.Бат-Эрдэнэ гишүүн сая тийм санал гаргасан шүү дээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй саналаар санал. Би томьёолол уншаадахья. Чуулган дээр цөмөөрөө ингэж ярилцъя. Нэгэнт сая бид дэмжээд

хураалгачихсан. М.Оюунчимэг гишүүний саналыг.

Тэгэхээр чуулган дээр гишүүд бас дахиад юу байвал бололцоо байгаа шүү дээ. Тэгээд цаашаагаа үргэлжлүүлье.

Сая би Ш.Адьяшаа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг сая уншсан. Дахиад уншаад өгье. Томьёоллыг нь.

Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн 1072 хувьцааг иргэн бүрд эзэмшүүлэх. Урьд нь дээрх хувьцааны талаар иргэдэд олгосон мөнгөнүүдийн сүүлийн хувьцааны ашгаас. Мөнгөнүүдийг юм уу. Сүүлийн хувьцааны ашгаас суутган бүх хувьцааг иргэнд эзэмшүүлэх.

Ийм юм бичиж өгчээ. Ш.Адьяшаа гишүүн уг нь өөрөө тайлбарласан бол хэрэгтэй байсан. Энэ дээр санал хураалт явуулчихья. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн дийлэнх олонх нь дэмжсэнгүй. Ш.Адьяшаа гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй.

Түрүүн бид 1.2-ыг орхиод явчихсан шүү дээ. М.Оюунчимэг гишүүн ээ. Тийм ээ. 1.2-ыг орхиод явчихсан. Тийм.

Түрүүн буцаж эргэж хураалгаж байгаа шүү. 1.2 дээр алгасаад явчихсан юм. Сонсож байгаарай.

Нүүрсний хулгайн асуудлаарх Засгийн газрын шалгалтын ажил, авч буй арга хэмжээ бодитой үр дүнд хүрэх, авлигал, мөнгө угаасан байж болох зохион байгуулалттай бүлэглэл, цаад эздийг шударгаар тогтоож, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, хөрөнгийг хураах, буцаан төлүүлэх, шударгаар

шийтгэхийг хууль хүчний байгууллагуудаас шаардаж хяналт тавих.

**М.Оюунчимэг** гишүүн найруулсан юм. М.Оюунчимэг гишүүн та энэ найруулгаа дахиад нэг сайхан уншаадааа.

**М.Оюунчимэг:** Энэ дээр ингэж байгаа юм. Нүүрс тээвэрлэлттэй холбоотой Засгийн газраас авч байгаа арга хэмжээ эрчимжүүлэх гэж байгаа юм.

Засгийн газар угаасаа нүүрсний хулгайтай тэмцэж байгаа. Ерөнхий сайд өөрөө чинь энэ дээр манлайлаад яваад байна л даа.

Гэхдээ нийгмийн шүүмжлэл ч байгаад байна. Яг бодитой эзэн рүү нь очих, тэр бүлэглэл хулгайг нь таслан зогсоох, эргэж төрийн өмч, тэр төрийн өмчит компанийг өр төлбөргүй болгох. Энэ авлигалыг зогсоох гээд байгаа шүү дээ. Оффтэйк гэрээ байгуулахгүй.

Энэ дээр дэндүү ерөнхий байгаа учраас хуулийн дагуу хариуцлага хүлээх, хууль хүчний байгууллагыг энэ дээр шахаж ажиллаж хяналт тавих гэдэг нэлээд тодорхой болгох хэрэгтэй байна гэсэн заалт оруулж байгаа юм шүү. Түүнээс тэр түрүүнийх дээр Ц.Цэрэнпунцаг дарга аа. Яг саяынхаар тэгээд л оруулах хэрэгтэй байна. Ийм ерөнхий биш.

**Ц.Цэрэнпунцаг:** Ш.Оюунчимэг гишүүн ээ, тогтоол анхны энэ оруулж ирсэн төсөл дээрхээр явчихъя. Тэгэх үү. Т.Доржханд гишүүн дараагийнх дээр нь өгсөн байгаа. Энэ дээр байгаа.

Т.Доржханд гишүүний гаргасан дээр саяын санаанууд бүгд ороод явчихсан учраас цөмөөрөө энэ

тогтоолынх нь төслөөрөө явчихъя. Тэгэх үү. Түрүүн алгассанаа бид ярьж байгаа юм.

Тэгэхээр байна шүү дээ. Ингэе. Одоо ингээд байвал бид нар юм явахгүй нь. Ажил явахгүй нь.

Тэгэхээр таны наадхыг чинь энэ тогтоолын төсөл дээрээ байгаагаараа үлдээчхээд Т.Доржханд гишүүний оруулсан санал дээр. М.Оюунчимэг гишүүн Та саналаа хэл.

**М.Оюунчимэг:** Нэгд, Б.Энхбаяр гишүүн ээ, Та өөрөө түрүүн энэ нүүрсний хулгайн дээр бөөрөнхий байна. Үүнийгээ зас гээд л хашхираад байсан. Одоо болсон чинь тэс өөр юм яриад унах юм. Үүнийг чинь л яриад байна шүү дээ. Энэ заалтыг маш тодорхой болгох хэрэгтэй.

Тийм учраас түрүүн Т.Доржханд гишүүн, би, Д.Батлут гишүүн бид нийлээд ингээд санал оруулчихсан байгаа учраас яг өөрийнхөө нэрээр оруулснаа татаад авчихъя. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** М.Оюунчимэг гишүүн татаж явсан. Тэгэхдээ түрүүний би төсөл дээр уншсанаар ингээд баталчихъя. Санал хураалт.

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3/Ард түмний мэдэх эрхийг хангах чиглэлээр:

а/нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой хяналт, шалгалтын ажлын үр дүн, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, хэрэгжилтийн явц байдал, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцсон талаарх мэдээллийг олон нийтэд тухай бүр шуурхай мэдээлж байх.

Н.Ганибал гишүүн саналтай байна.  
Н.Ганибал гишүүн саналаа хэлье.

**Н.Ганибал:** Энэ ард түмний мэдэх эрхийг хангах чиглэлээр энэ 3 дугаар заалтыг бүхлээр нь авах санал байна.

Энэ яагаад гэхээрээ өнөө хил боомтын үйл ажиллагааг сайжруулах нөгөө Хяналтын түр хороо байгаа. Түр хорооны бүх ажлууд бүгдээрээ ингээд орчихсон байгаа байхгүй юу.

Түр хорооны ажил дуусаагүй байгаа. Түр хорооны үүрэг нь өөрөө ард түмэнд мэдэх эрхийг нь хангуулах зорилготой байхгүй юу.

Тэгэхээр үүнийг заавал ингэж одоо манай Байнгын хороотой яг ингээд параллель ажиллаж байгаа Түр хороо ажлаа хийх л үүрэг байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нэг Байнгын хороо Түр хороондоо чиглэл өгөх нь зөв юм уу, буруу юм уу. Тийм.

Харин тэр 3-т нь бид нарт нэг ийм асуудлыг нэг оруулж тавих санал байна. 3-т нь богинын тээвэр энэ тэр гээд одоо бид нарын хэллэгээрээ “Си” зөвшөөрөл гээд энэ нэг асуудал байгаа шүү дээ. Одоо манай уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын асуудал, биржийн асуудал гээд. Энэ дээр харин бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг түрүүний уг нь л юу шүү дээ. Хууль гарсантай дагалдах арга хэмжээ гэдэгтэй адилхан хуулийн хэрэгжилтийг түргэн шуурхай болгох гээд. Тэр чиглэлүүдийг л өгөх хэрэгтэй.

Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улстай нүүрс тээврийн тэр хэлэлцээрүүдээ дахин шинэчлэн сайжруулах гэсэн ийм нэг тэр л тэр асуудлыг л оруулбал манай яг одоо юу

гэдэг юм Эдийн засгийн байнгын хорооноос хууль эрх зүйгээ сайжруул, төрийн өмчит үйлдвэрийн газруудынхаа үйл ажиллагаан дээр саяынхаа заалтуудыг оруулаад тээвэр дээр нэг заалтаа оруулаад өгчихвөл ингээд болох юм уу гэсэн санал байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Н.Ганибал гишүүний сая санал хэллээ. Энэ “а”-г хасъя гэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр түрүүн бас энэ асуудал яригдаж байсан. Давхцаад хэлсэн. Энэ бол Түр хянан шалгах хороо чинь тэр шалгаж байгаа, хамарч байгаа хүрээ бол их өргөн цар хүрээтэй. Бид нар бол энэ нүүрсний хулгайтай холбоотой учраас энэ дээрээ нарийвчилж яг Тавантолгой, энэ дээр энэ хяналт шалгалтынхаа ажлын үр дүн юу болж байгааг мэдээлье л гэсэн үг байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөөдөх чинь боомт, тэгээд олон асуудал байгаа. Тийм ээ.

Тийм учраас үүгээрээ санал хураалгачихъя гэсэн би саналтай байна. Ингээд яг миний саяын уншсанаар санал хураалтаа явуулчихъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдээ анхааралтай байгаарай. Санал хураалт.

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

б/нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой оффтэйк гэрээнүүд, түүний нууцад хамааруулсан шийдвэр, ажил гүйцэтгэх, туслан гүйцэтгэх гэрээнүүд, 2010 оноос хойших 1072 хувьцаа эзэмшигчдийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын хурлын бүх тэмдэглэл, тушаал, шийдвэр,

худалдах, худалдан авах гэрээнүүдийн хуулбарыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд ил тод болгох.

Саналтай гишүүд алга байна. Санал хураалт явуулья.

Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд Т.Доржханд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар. Энэ 3.в-д заалт нэмэх. Т.Доржанд гишүүн, М.Оюунчимэг гишүүн, Д.Батлут гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй санал.

Цаашид Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж дээр үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтэйк гэрээг байгуулахгүй байх, улсын нууцад хамруулахгүй байх шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хуралд танилцуулж хэлэлцүүлэх. Энэ дээр ерөнхийдөө агуулга ойлгогдож байгаа.

Тэгэхээр энэ дээр найруулга дээрээ редакци хийх дээрээ та бүхэн анхаараад энэ гурван гишүүн анхаараад ажиллачихаарай. Ингээд энүүгээр санал хураалт явуулчихья. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 63.6 хувийг нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Протоколд тэмдэглэлээрээ. Д.Батлут гишүүн дэмжиж өгсөн. Өөрийнх нь санал юм чинь.

3.г дээр нь заалт нэмэх. Т.Доржханд гишүүн, М.Оюунчимэг гишүүн, Д.Батлут гишүүн.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-иас санхүүжүүлсэн оффтэйк гэрээний хүрээнд хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төмөр замын бүтээн байгуулалтад хөндлөнгийн аудит оруулах, аудитын дүгнэлт дээр үндэслэн санхүүжилтийг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх.

Саналын томьёоллыг танилцууллаа. Үүнийг бүгдээрээ сайхан Байнгын хороогоор дэмжиж гаргаад, энэ дээр Байнгын хороо энэ ард нь гарч үүний араас юм болгож ажилламаар байгаа шүү. Үүнийг Байнгын хорооныхоо гишүүдэд уриалан хэлчихье. Тийм ээ. Санал хураалт.

Гишүүдийн 63.6 хувийг нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Протокол тэмдэглээрэй. Д.Бат-Эрдэнэ гишүүн дэмжсэн.

2.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэлийг шалган тогтоох” үүрэг бүхий Хянан шалгах түр хороо үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, цуглуулсан нотлох баримтуудыг шинжлэн судлах сонсголыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог хороо /Г.Ганболд/-нд даалгасугай.

Энэ дээр санал хурааж явуулах юм байна шүү. Энэ дээр санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд төрийн өмчит компанийг шинээр байгуулах, үйл ажиллагааны үр ашигтай, ил тод байдлыг хангах зохицуулалтыг сайжруулах, онцгой дэглэм тогтоох, бүрэн эрх төлөөлөгч томилох шаардлага, үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулах чиглэлээр анхаарч ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

Энэ дээр санал байна уу? Д.Батлут гишүүн. Санал хураалт явуулчих уу. Санал хураалт. /алх цохив/

Дэмжсэнгүй. Дэмжигдсэнгүй. Би дэмжиж өгсөн санагдаад байх. Би дэмжээгүй явж байна шүү дээ. Юу вэ. Дэмжсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа нийтийн эрх ашгийг хөндсөн Ерөнхий хяналтын сонсголын зохион байгуулалт, үр нөлөөг сайжруулах зорилгоор оролцогчдын хамрах хүрээг нэмэгдүүлэх, эрх, үүргийг тодорхой болгох, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдийг оролцуулах, сонсголын үр дүнг мэдээлэх, сонсголын мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, зохих байгууллагад үүрэг даалгавар өгөх, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байх, шаардлагатай бол холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар саналаа Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг холбогдох Байнгын хороодод даалгасугай.

Энэ дээр саналтай гишүүд байхгүй бол санал хураалт явуулчихья. /алх цохив/

Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ зарчмын зөрүүтэй санал байна. Т.Доржханд гишүүн, М.Оюунчимэг гишүүн, Д.Батлут гишүүн гаргасан.

5 дугаар зүйлд нэмэх. Төрийн байгуулалтын харилцан хяналт тэнцлийг хангах хүрээнд Улсын Их Хурал нь Засгийн газартаа тавих хяналтыг сайжруулах, шүүх, прокурорын байгууллагын томилгоог өөрчлөх, шинэчлэх, иргэдийн төлөөлөл сонгогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, сонгуулийн тогтолцоог өөрчлөх ажлыг эрчимжүүлсүгэй.

Ийм зарчим зөрүүтэй санал. Зарчмын зөрүүтэй ийм санал оруулж ирж байна. Сая би томъёоллыг уншлаа. Санал хураалт явуулчихья. Тэгэх үү. Санал хураалтаараа шийдчихье. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Мөнхбат/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.

Санал хураалт явуулж дууслаа.

“Ерөнхий хяналтын сонсголын тайлан хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын

хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хороонд санал иржээ. Энэ бол эдийн засгийг тогтворжуулах багц арга хэмжээ хэрэгжүүлэх тухай. Ингээд энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна.

Үүнийг бид дараагийн долоо хоногт Эдийн засгийн байнгын хороогоор

энэ дээр ажлын хэсэг байгуулж энэ саналыг судалж ажиллая гэдэг ийм саналтай байна. Үүнийг протоколдоо тэмдэглэхээрэй. Ингээд Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдааны үүгээр өндөрлөж байна.

Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

*Хуралдаан 3 цаг 15 минут үргэлжилж, 12 цаг 57 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**